



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025.11.18 № 107/3329
танай -ны № -т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлохыг хүсье.

Хавсралт . . . хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



С.БЯМБАЦОГТ


000255018241

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 29 дүгээр хуралдааны тэмдэглэлд:

“1.ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хуулийн төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2025.11.28 № 1/2428

танай _____-ны № _____-т

**МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР
САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН САЙД Ж.ЭНХБАЯР
ТАНАА**

Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



Б.ЭНХБАЯР

А5.файл.2025

151603432



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>

2025.11.28 № 01/10516

танай 2025.11.28-ны № 01/3189 -т

МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД Ж.ЭНХБАЯР ТАНАА

Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг зөвшөөрч байна.

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН

9761002234



**МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХАРИЛЦААНЫ
САЙД**

Энхтайвны өргөн чөлөө 7а,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14210
Утас: 262135, Факс: (976-11)322127
Цахим шуудан: info@mfa.gov.mn
Цахим хуудас: www.mfa.gov.mn

2025.11.28 № 01/5684


танай _____-ны № _____-т

**「МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР」
САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ
ХӨГЖЛИЙН САЙД Ж.ЭНХБАЯР
ТАНАА**

Танаас 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр ирүүлсэн “Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.9 дэх хэсгийн дагуу олгож байна.



Гадаад харилцааны яам
Удирдлага
Гадаад харилцааны сайд
Батмөнх БАТЦЭЦЭГ
2025-11-28 16:17:55



**МОНГОЛ УЛС БОЛОН ЕВРАЗИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХОЛБОО, ТҮҮНИЙ
ГИШҮҮН ОРНУУД ХООРОНДЫН ХУДАЛДААНЫ ТҮР ХЭЛЭЛЦЭЭРИЙГ
СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1 .Хууль зүйн үндэслэл

“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн Зорилт 4.4-т “Бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцид нэгдэж, худалдааг хөнгөвчилнө”, “Зорилтыг хэрэгжүүлэх I үе шат 2021-2030 онд Хөрш орнуудыг дамжсан эдийн засгийн коридорыг хөгжүүлэх, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Оросын Холбооны Улстай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулж, бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцид нэгдэх замаар эдийн засгийн гадаад харилцааг эрс нэмэгдүүлэх үе” гэж заасан.

Мөн Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.5.1-т “Цөөн зах зээл, цөөн нэр төрлийн бүтээгдэхүүний экспорт, импортоос хэт хамааралтай үндэсний эдийн засгийн эмзэг байдлыг бууруулна.”, 3.2.5.3-т “Нэг орноос худалдан авах бараа бүтээгдэхүүн нийт импортод хэт давамгайлахаас сэргийлэх бодлого баримтална”, 3.2.5.4-т “Бүс нутгийн болон олон улсын интеграцид нэгдэх, чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах асуудлыг эдийн засгийн аюулгүй байдал, хөгжлийн шаардлагыг харгалзан, судалгаа, тооцоонд тулгуурлан, шат дараатай, сонголттойгоор хэрэгжүүлнэ” гэж тус тус заасан.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.2.11-т “Бүгд Найрамдах Солонгос Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, Бүгд Найрамдах Хятад Ард Улстай эдийн засгийн түншлэл, чөлөөт худалдааны

хэлэлцээрийг байгуулж, худалдааны түнш улс орнуудтай хамтран ажиллах эдийн засгийн чиглэлийг нарийвчлан тодорхойлж, хөрөнгө оруулалт, экспорт, бизнесийг дэмжсэн харилцааг хөгжүүлнэ” гэж тусгагдсан.

1.2. Практик шаардлага

2024 оны байдлаар Монгол Улсын худалдааны салбар дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ний 17.8 хувь, идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн 38.2 хувийг бүрдүүлж, 195,081 хүн буюу нийт ажиллагсдын 14.4 хувийг ажлын байраар хангаж байна.

Монгол Улс нь зөвхөн Япон Улстай эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг 2015 онд байгуулсан. Мөн Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрт 2019 онд, Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх тухай ерөнхий хэлэлцээрт 2022 нэгдэн орж, тус тус соёрхон баталсан. Бусад улс орнуудтай харьцуулахад Монгол Улс олон улсын хэмжээнд чөлөөт худалдааны гэрээ байгуулсан орны үзүүлэлтээр хамгийн цөөн гэрээ байгуулсан орны тоонд багтаж байна.

Монгол Улс нь далайд гарцгүй, хоёр том эдийн засгийн дунд байрладаг тул уул уурхайн бүтээгдэхүүний түүхий эдийн зах зээл болон үнийн хэлбэлзэлд тэсвэртэй байдал болон гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжихэд бүс нутгийн эдийн засгийн интеграцид нэгдэх, гадаад худалдааны зах зээлийг тэлэх, нэг эдийн засгаас хараат байдлыг бууруулах, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг хэрэгжүүлэх, цаашлаад хувийн хэвшил, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, экспортын зах зээлийг тэлэх, худалдааг хөнгөвчлөх бодлогыг хэрэгжүүлэх нь чухал ач холбогдолтой байна.

Монгол Улсын нийт бараа эргэлтийн 69.5 хувийг Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ), 10.7 хувийг Оросын Холбооны Улс (ОХУ) тус тус эзэлж байна. Манай улсын нийт экспортын 91.3 хувийг БНХАУ эзэлж байна. Энэ нь экспортын зах зээлийн хэт төвлөрөл болон хамаарлын эрсдэлийг бий болгож байгаа тул экспортын зах зээлийг төрөлжүүлэх, шинэ зах зээлд нэвтрэх зайлшгүй шаардлагатай байна.

Монгол Улс Евразийн эдийн засгийн холбоо (ЕАЭЗХ)-ны гишүүн орнууд болох ОХУ, Бүгд Найрамдах Беларусь Улс (Беларусь), Бүгд Найрамдах Казахстан Улс (Казахстан), Бүгд Найрамдах Армени Улс (Армени), Бүгд Найрамдах Киргиз Улс (Киргиз) орнуудтай хийсэн гадаад худалдааны нийт бараа эргэлт 2024 онд 3.0 тэрбум ам.доллар байгаагаас 2.9 тэрбум ам.доллар нь импорт байна. Манай улстай хийсэн тус холбооны гишүүн 5 орны худалдааны 97.2 хувийг ОХУ, 1.8 хувийг Казахстан Улс, 0.8 хувийг Беларусь Улс, 0.1 хувийг Киргиз Улс, 0.02 хувийг Армени Улс тус тус бүрдүүлж байна. ЕАЭЗХ нь манай улсын нийт бараа эргэлтийн 11 хувь, экспортын 0.7 хувь, импортын 25 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд бараа эргэлтийн харьцаа 96:4 байна. Энэ нь гадаад худалдааны тэнцэл эрс алдагдсан байгааг харуулж байна.

ЕАЭЗХ нь гаалийн нэгдсэн нэг нутаг дэвсгэртэй ба бусад орнуудтай хийх худалдаанд гаалийн нэгдсэн нэг татвар болон зохицуулалтыг хэрэгжүүлдэг. ЕАЭЗХ-ны гишүүн орнуудаас хөдөө аж ахуй болон боловсруулах салбарын бүтээгдэхүүнд дунджаар 15-50 хувийн гаалийн татвар ногдуулдаг, тарифын бус саад тотгор их байгаа нь Монгол Улсын бүтээгдэхүүн ЕАЭЗХ-ны зах зээлд нэвтрэх, өрсөлдөх

чадварт сөрөг нөлөө үзүүлж байгаа гол хүчин зүйл болж байна.

Монгол Улс ЕАЭЗХ-ны гишүүн орнуудтай худалдааны хэлэлцээр байгуулах замаар экспортыг төрөлжүүлэх, нэмэгдүүлэх, тарифын болон тарифын бус саад тотгорыг бууруулах, гадаад худалдааны тэнцлийг сайжруулах, улмаар бүс нутгийн эдийн засгийн интеграцид тэнцвэртэй, үр ашигтайгаар нэгдэх нь зүйтэй байна.

Түүнчлэн эрүүл ахуй, хорио цээрийн шаардлагыг харилцан уялдуулах, тохирлын үнэлгээний үр дүнг талууд харилцан зөвшөөрөх, барааг гаалиас хурдан шуурхай олгох, эрсдэлд суурилсан гаалийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх зэрэг худалдааг хөнгөвчлөх арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Түүнчлэн Худалдааны түр хэлэлцээрт талууд итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж (ИААН) хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр тохирсон бөгөөд одоогоор уг асуудлыг холбогдох журмаар зохицуулж байна. Иймд ИААН-д олгох хөнгөлөлтийн асуудлыг Гаалийн тухай хуульд тусгахаар байна.

Мөн хэлэлцээрт 5,000.0 еврогоос бага үнийн дүн бүхий барааны гарал үүслийн мэдүүлгийг үйлдвэрлэгч, эсхүл экспортлогч өөрөө гаргаж болохоор заасан тул Гаалийн тариф, татварын тухай хуульд үйлдвэрлэгч, экспортлогч гарал үүслийн мэдүүлэг гаргаж болох тухай, гарал үүслийн баримтыг нөхөн гаргах хугацааны асуудлыг хэлэлцээрийн зохицуулалттай уялдуулах асуудлыг тус тус нэмж тусгах шаардлагатай байна.

Дээр дурдсан хууль зүйн үндэслэл, практик шаардлагад тулгуурлан Монгол Улс болон ЕАЭЗХ, түүний гишүүн орнууд хоорондын Худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг боловсруулах шаардлагатай байна.

Хоёр.Хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл нь 1 зүйлтэй байх бөгөөд тус зүйлд 2025 оны 6 дугаар сарын 27-ны өдөр байгуулсан Монгол Улс болон ЕАЭЗХ, түүний гишүүн орнууд хоорондын Худалдааны түр хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлахаар тусгасан.

Гурав.Хууль батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Монгол Улс болон ЕАЭЗХ, түүний гишүүн орнууд хоорондын Худалдааны түр хэлэлцээрийн хүлээгдэж буй эдийн засгийн нөлөөллийн шинжилгээг Дэлхийн худалдааны анализ төсөл ерөнхий тэнцвэрийн стандарт загвар (GTAP) ашиглан хийсэн.

Импортын 367 мөр барааны 356 барааны тарифыг тэглэх, 6 барааны тарифыг 25-50 хувь бууруулах, 2 бараанд тохирсон квотын хэмжээнд тарифыг тэглэх, 3 бараанд тохирсон квотын хэмжээнд тарифын хөнгөлөлт эдэлснээр импортын тарифын орлого багасах хэдий ч өрхийн хэрэглээ болон экспорт нэмэгдэж улмаар эцсийн хэрэглээ өсөж, ДНБ-ний бодит өсөлтөд эерэг нөлөө үзүүлэхээр байна.

Өрсөлдөх чадвар бүхий салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээ өсөх хандлагатай байгаа бөгөөд үүнд савхин эдлэл, малын мах, дайвар бүтээгдэхүүн, үхэр, хонь, ямаа зэрэг малын тоо толгой, тослог ургамал, нэхмэл, нөөшилсөн махан бүтээгдэхүүн зэрэг 30 салбар (GAP шинжилгээ нийт 65 салбартай) багтаж байна. Тус хэлэлцээрийг хэрэгжүүлэх тохиолдолд дотоодын хувцас үйлдвэрлэл 2.6 хувь, арьс шир савхин эдлэл 1.4 хувь, малын мах, дайвар бүтээгдэхүүн 1.4 хувь, амьд үхэр, хонь, ямаа 1.2 хувь, тослог ургамал 0.8 хувь болон нэхмэл эдлэл 0.7 хувиар тус тус өсөх төлөвтэй байна.

Тус шинжилгээгээр ОХУ-д экспортлох хиам, зайдас, нухаш зэрэг нөөшилсөн махан бүтээгдэхүүний хэмжээ 140.0 хувь, малын мах, дайвар бүтээгдэхүүн 125.0 хувь, бэлэн хувцас 84.3 хувь, нэхмэл эдлэл 55.4 хувь, савхин эдлэл 45.7 хувь тус тус өсөхөөр, Казахстан Улсад экспортлох арьс ширэн бүтээгдэхүүн 152 хувь хүртэл, малын мах, дайвар бүтээгдэхүүн 113.0 хувь, бэлэн хувцас 134.0 хувь, нэхмэл эдлэл 27.0 хувь, савхин эдлэл 152.0 хувиар тус тус өсөхөөр байна.

ЕАЭЗХ-ны гишүүн орнуудын экспорт буюу Монгол Улсын импортын барааны өөрчлөлтийн хувь бага байна. Тухайлбал Монгол Улсын модон эдлэлийн импорт 3.6 хувь, шил керамик гипс 2.8 хувь, гахай тахианы мах 2.1 хувь, судаг өвсний үр 2.0 хувь, жимс жимсгэнэ, шүүс, сахар, шоколад зэрэг хүнсний бүтээгдэхүүн 1.5 хувь, хар төмөрлөг 1.5 хувь тус тус өсөхөөр байна.

Монгол Улсаас ЕАЭЗХ-ны гишүүн орнууд руу экспортлох барааны гаалийн тарифыг тэглэснээр тухайн барааг үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдийн орлого нэмэгдэж, шинэ зах зээлд нэвтрэх боломж бүрдэж, хөдөө аж ахуйн салбарын өрсөлдөх чадвар сайжран олон улсын стандартад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд чухал түлхэц болно.

Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн экспортлоход тавигдах эрүүл ахуй, хорио цээрийн шаардлагыг хялбаршуулах, тохирлын үнэлгээний дүнг харилцан хүлээн зөвшөөрөх талаар хэлэлцээг эхлүүлэх нөхцөл бүрдэнэ.

Гаалийн мэдүүлгийг бүртгэснээс хойш 4 цагийн дотор барааг олгох зохицуулалт нь бараа бүтээгдэхүүн хил дээр саатах эрсдэлийг бууруулж, нийлүүлэлтийн сүлжээг шуурхай болгоно. Цахимаар мэдээлэл солилцох, бага эрсдэлтэй бараанд хялбаршуулсан горим хэрэглэх, итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж хөтөлбөрийг хэрэгжүүлснээр бизнес эрхлэгчдийн цаг хугацаа, зардлыг хэмнэж, Монгол Улсын гаалийн шинэчлэлийг олон улсын жишигт нийцүүлэхэд чухал алхам болох юм.

Гарал үүслийн гэрчилгээг цахимаар солилцох боломжийг бүрдүүлж, биет байдлаар шаардахгүй болсноор гаалийн үйл ажиллагаа хурдсаж, бичиг баримтын бүрдүүлэлтийг хялбаршуулна. Мөн гадаад худалдаа эрхлэгч бараа экспортлоход гарал үүслийн гэрчилгээг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас олгох шаардлагагүй болох бөгөөд 5,000.0 еврогоос хэтрэхгүй бараанд гарал үүслийн мэдүүлгийг бизнес эрхлэгч өөрөө гаалийн байгууллагад мэдүүлж болохоор тусгасан нь цаг хугацаа, зардал хэмнэсэн, жижиг, дунд үйлдвэрлэгчдийг дэмжсэн зохицуулалт болно.

ЕАЭЗХ-ны гишүүн орнуудаас гаралтай түүхий эд, барааг ашиглан Монгол Улсад үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд

тооцох, барааг тээвэрлэхэд зориулж савласан савлагаа, баглаа боодлын материал, хайрцаг савыг тухайн барааны гарал үүслийг тогтооход тооцохгүй байхаар заасан. Мөн барааны гарал үүслийг 50 хувиас дээш Монгол Улсаас гаралтай бараа байх тохиолдолд Монгол Улсаас гаралтай бараа гэж тооцохоор байгаа нь дотоодын үйлдвэрлэгчдэд гарал үүслийн хувьд таатай нөхцөл олгож байна.

Түүнчлэн худалдааны эргэлт нэмэгдсэнээр гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалт өсөх боломжтой бөгөөд улмаар хүнс, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл, өрсөлдөх чадвар, чанар, бүтээмж сайжирч, ажлын байр нэмэгдэнэ. Мөн үйлдвэрлэлийн зардал, импортын бүтээгдэхүүний үнэ буурснаар эцсийн хэрэглэгчид болон өрхийн хэрэглээнд таатай нөлөө үзүүлж, инфляцыг бууруулах боломжтой.

Уул уурхайн бус бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдсэнээр эдийн засгийг төрөлжүүлж худалдааны хараат байдлыг бууруулна. Хэлэлцээрийн үр дүнд экспортын чиг баримжаатай хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх суурь нөхцөл бүрдэх юм.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал

Тус хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай нийцсэн бөгөөд уг хуулийн төсөлтэй холбогдуулан Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулна.

—ooOoo—

ТАНИЛЦУУЛГА

Монгол Улс 2024 онд нийт 162 оронтой худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 27.4 тэрбум ам.долларт хүрсэн ба үүний 80.2 хувийг Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ), Оросын Холбооны Улс (ОХУ) эзэлж байна. Нийт экспортын 93 хувийг уул уурхайн бүтээгдэхүүн бүрдүүлж байгаа нь эдийн засгийн төрөлжилт сул, гадаад зах зээлийн савлагаа, түүхий эдийн үнийн хэлбэлзэлд өртөмтгий байдлыг нэмэгдүүлж байна. Мөн нийт экспортын 91.3 хувь, уул уурхайн бүтээгдэхүүний 94.7 хувь, хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүний 82.7 хувийг зөвхөн БНХАУ-д экспортолж байгаа нь нэг улсын зах зээлээс хэт хамааралтай болж, эдийн засгийн аюулгүй байдалд сөрөг нөлөө учруулах хэмжээнд хүрээд байна. Иймд, экспортын зах зээлийг төрөлжүүлж, шинэ бүс нутаг, улсын зах зээлд нэвтрэх зайлшгүй шаардлагатай байна.

2024 оны байдлаар ОХУ-тай хийсэн худалдаа 2.7 тэрбум ам.долларын алдагдалтай байна. Сүүлийн 10 жилд ОХУ руу экспортлох хэмжээ төдийлөн нэмэгдээгүй бөгөөд шатахууны эрэлт нэмэгдсэнтэй холбоотой импорт өсөж, худалдааны бүтэц тэнцвэргүй байна. ОХУ нь Евразийн эдийн засгийн холбоо (ЕАЭЗХ)-ны гишүүн тул холбооны бусад гишүүн орнуудтай адил нэгдсэн гаалийн тарифын бодлого хэрэгжүүлдэг. Монгол Улсаас ЕАЭЗХ-д экспортлох бараанд 15–50 хувийн гаалийн тариф ногдуулж, эрүүл ахуй, хорио цээрийн өндөр шаардлага тавьж байгаа нь экспортын боломжийг хязгаарлаж байна.

Тиймээс Монгол Улс болон ЕАЭЗХ, түүний гишүүн орнууд хооронд худалдааны түр хэлэлцээр байгуулах албан ёсны хэлэлцээг 2023 оны 9 дүгээр сараас эхлүүлж, удаа дараа хийсэн олон нийтийн хэлэлцүүлгээс гарсан саналуудыг тусган эцэслэж, 2025 оны 6 дугаар сарын 27-ны өдөр гарын үсэг зурж байгуулсан.

Тус хэлэлцээр нийт 31 зүйл, 4 хавсралтаас бүрдэх бөгөөд хөрөнгө оруулалт, үйлчилгээний худалдаа, банк санхүү, төлбөр тооцоо зэрэг асуудлыг тусгаагүй, зөвхөн 367 барааны хүрээнд тохиролцсон. Мөн хэлэлцээр 3 жилийн хугацаатай бөгөөд талууд өөрөөр тохиролцоогүй бол хугацааг сунгасанд тооцно.

Хэлэлцээрийн хүрээнд 2 талаас ижил тооны буюу “Бараа тодорхойлох кодчлолын уялдуулсан систем” (БТКУС)-ийн 6 оронтой кодоор 367 бараанд “тарифыг шууд тэглэх”, “тариф бууруулах”, “тохирсон квотын хэмжээнд тарифыг тэглэх”, “тохирсон квотын хэмжээнд тарифын хөнгөлөлт эдлэх” гэсэн 4 төрлөөр тарифыг бууруулах, хөнгөлөлт үзүүлэхээр тохиролцсон. Энэ нь зөвхөн гаалийн тарифт хамаарах бөгөөд нэмэгдсэн өртгийн албан татвар болон онцгой албан татварт хамаарахгүй.

Хэлэлцээрийн хүрээнд Монгол Улсаас экспортлох 367 барааны 97.5 хувь нь хөдөө аж ахуй, мал аж ахуйн гаралтай бараа байна. Харин ЕАЭЗХ-ноос манай улсад импортлох 367 барааны 81.7 хувь нь манай улсад үйлдвэрлэх боломж хязгаарлагдмал эрдэс, химийн салбарын, 7.5 хувь нь аж үйлдвэрийн салбарын бараа байна. Мөн улаанбуудай, өндөг зэрэг хүнсний гол нэрийн барааны импортын нөлөөллийг бага байлгах, дотоодын зах зээлийг хамгаалахад онцгойлон анхаарч

жилд импортлох хэмжээнд квот тогтоох, квотоос хэтэрсэн тохиолдолд гаалийн тарифыг хэвээр ногдуулах зэрэг дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах зохицуулалтыг тусгасан.

Хэлэлцээр хэрэгжсэнээр худалдааг хөнгөвчилж, үйлдвэрлэл болон бизнесийн зардал буурна. Тухайлбал, барааны өртгийн 50 хувиас дээш хэсэг Монгол Улсаас гаралтай тохиолдолд тарифын хөнгөлөлт эдлэх, барааг гаалийн мэдүүлгийг бүртгэснээс хойш 4 цагийн дотор олгох, 5000 еврогоос бага дүнтэй бараанд гарал үүслийн гэрчилгээг үйлдвэрлэгч, экспортлогч өөрөө гаргах, эрсдэлийн үнэлгээнд суурилсан гаалийн шалгалт явуулах зэрэг зохицуулалт туссан. Мөн итгэмжлэгдсэн аж ахуй нэгжийн хөтөлбөрийг талууд хамтран хэрэгжүүлснээр бичиг баримт, шалгалтын ачаалал буурна.

Олон улсад чөлөөт худалдааны хэлэлцээр хийхэд түгээмэл ашигладаг “Ерөнхий тэнцвэрийн загвар” (GAP)-ын аргаар тооцоход хэлэлцээр хэрэгжсэнээр манай улсын ДНБ 0.02 хувь, хөрөнгө оруулалт 2.57 хувь, ЕАЭЗХ руу хийх экспорт 24.1 хувь өсөхөөр байна. Тухайлбал, мах, махан бүтээгдэхүүн, ноос ноолуур, нэхмэл, сүлжмэл болон арьс шир зэрэг боловсруулах үйлдвэрийн гол бүтээгдэхүүний экспорт 152 хувь хүртэл нэмэгдэж, гаалийн татваргүйгээр 180 сая хүн ам бүхий, 5 улсын зах зээлд нэвтрэх нөхцөл бүрдэнэ. Түүнчлэн, манай улсад үйлдвэрлэдэггүй, бүтээн байгуулалт болон үйлдвэрлэлд зайлшгүй шаардагдах бараа, тоног төхөөрөмжийн татварыг тэглэснээр импортын өртөг буурч, инфляцын дарамт багасна. Инфляц тооцоход ашигладаг 42 нэрийн импортын бүтээгдэхүүний тариф тэглэгдэхээр байгаа нь өрхийн жилийн дундаж хэрэглээний зардлыг бууруулах тооцоотой байна.

Монгол Улс болон ЕАЭЗХ, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээр байгуулах асуудал нь “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн Зорилт 4.4, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.5.1, 3.2.5.3, 3.2.5.4, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.2.11-т тус тус тусгагдсан.

“Цагаан алт”, “Хүнсний хувьсгал”, “Шинэ хоршоо хөдөлгөөн” зэрэг төрийн бодлогын хүрээнд хөдөө аж ахуйн салбарыг дэмжих ажил идэвхтэй өрнөж буй энэ үед тус хэлэлцээр нь дотоодын боловсруулах үйлдвэрлэл болон нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлж, малчин өрх болон үйлдвэрлэгч, экспортлогчдын орлогыг өсгөх, ажлын байрыг нэмэгдүүлэх ач холбогдолтой. Мөн дээр дурдсан Монгол Улсын бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан бүс нутгийн интеграцид нэгдэх, нэг эдийн засгаас хараат байдлыг бууруулах, экспортын зах зээлийг тэлж, төрөлжүүлэх зорилтыг хэрэгжүүлэх, худалдааг хөнгөвчлөх, хувийн хэвшил, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих ач холбогдолтой.

---oOo---

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

“Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээр”-ийг соёрхон батлах Монгол Улсын хуулийн төслийн тухай

“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн Зорилт 4.4-т “Бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцид нэгдэж, худалдааг хөнгөвчилнө” гэж, “Зорилтыг хэрэгжүүлэх I үе шат болох 2021-2030 онд “Хөрш орнуудыг дамжсан эдийн засгийн коридорыг хөгжүүлэх, Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ), Оросын Холбооны Улс (ОХУ)-тай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулж, бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцид нэгдэх замаар эдийн засгийн гадаад харилцааг эрс нэмэгдүүлэх үе” гэж тус тус заасан.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.5.1-т “Цөөн зах зээл, цөөн нэр төрлийн бүтээгдэхүүний экспорт, импортоос хэт хамааралтай үндэсний эдийн засгийн эмзэг байдлыг бууруулна.” гэж, 3.2.5.3-т “Нэг орноос худалдан авах бараа бүтээгдэхүүн нийт импортод хэт давамгайлахаас сэргийлэх бодлого баримтална” гэж, 3.2.5.4-т “Бүс нутгийн болон олон улсын интеграцид нэгдэх, чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах асуудлыг эдийн засгийн аюулгүй байдал, хөгжлийн шаардлагыг харгалзан, судалгаа, тооцоонд тулгуурлан, шат дараатай, сонголттойгоор хэрэгжүүлнэ” гэж тус тус заасан.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.2.11-т “Бүгд Найрамдах Солонгос Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, (ЕАЭЗХ) БНХАУ-тай эдийн засгийн түншлэл, чөлөөт худалдааны хэлэлцээрийг байгуулж, худалдааны түнш улс орнуудтай хамтран ажиллах эдийн засгийн чиглэлийг нарийвчлан тодорхойлж, хөрөнгө оруулалт, экспорт, бизнесийг дэмжсэн харилцааг хөгжүүлнэ” гэж тусгагдсан.

Худалдааны нөхцөл байдал:

2024 оны байдлаар Монгол Улсын худалдааны салбар дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ний 17.8 хувь, идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн 38.2 хувийг бүрдүүлж, 195,081 хүн буюу нийт ажиллагсдын 14.4 хувийг ажлын байраар хангаж байна¹.

Монгол Улс Япон Улстай эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг 2015 онд байгуулсан. Мөн Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрт 2019 онд, Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх тухай ерөнхий хэлэлцээрт 2022 нэгдэн орж, тус тус соёрхон баталсан. Бусад улстай харьцуулахад Монгол Улс олон улсын хэмжээнд чөлөөт худалдааны гэрээ байгуулсан орны үзүүлэлтээр хамгийн цөөн гэрээ байгуулсан орны тоонд багтаж байна.

Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулснаар тарифын болон тарифын бус саад тотгорыг бууруулж, үндэсний үйлдвэрлэгчдэд шинэ зах зээлд нэвтрэх, хөрөнгө оруулагчдад тогтвортой, урьдчилан таамаглах боломж бүхий эрх зүйн орчин бүрдүүлж,

¹ Үндэсний Статистикийн Хороо

шууд хөрөнгө оруулалт татах нэг нөхцөлийг бүрдүүлдэг. Монгол Улсын бараа, үйлчилгээ бусад орны зах зээлд ижил төрлийн бүтээгдэхүүн нийлүүлж буй өрсөлдөгч орнуудаас илүү өндөр татвар, хатуу тарифын бус шаардлагатай тулгарч байгаа нь Монгол Улсын экспортын бүтэц, хөрөнгө оруулалт татах чадавхын хувьд бусад улсын өрсөлдөгч орнуудтай харьцуулахад хязгаарлагдмал байх нөхцөлийг бүрдүүлж байна.

Үүний улмаас Монгол Улсын эдийн засаг төрөлжих болон өсөх, экспортын бараа, үйлчилгээний өрсөлдөх чадвар, гадаадын шууд хөрөнгө оруулалт, ажлын байр нэмэгдэх, бүс нутгийн нийлүүлэлтийн сүлжээнд нэгдэх, үйлдвэрлэлийг шаталсан хэлбэрээр гүнзгийрүүлэх, дэвшилтэт технологи, ноу-хау зэрэг шилдэг туршлагыг нэвтрүүлэх боломжийг хязгаарладаг.

Монгол Улсын нийт бараа эргэлтийн 69.5 хувийг БНХАУ, 10.7 хувийг ОХУ тус тус эзэлж байна. Манай улсын нийт экспортын 91.3 хувийг БНХАУ эзэлж байна. Энэ нь экспортын зах зээлийн хэт төвлөрөл болон хамаарлын эрсдэлийг бий болгож байгаа тул экспортын зах зээлийг төрөлжүүлэх, шинэ зах зээлд нэвтрэх зайлшгүй шаардлагатай байна.

Монгол Улс нь далайд гарцгүй, хоёр том эдийн засгийн дунд байрладаг тул уул уурхайн бүтээгдэхүүний түүхий эдийн зах зээл болон үнийн хэлбэлзэлд тэсвэртэй байдал болон гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжихэд бүс нутгийн эдийн засгийн интеграцид нэгдэх, гадаад худалдааны зах зээлийг тэлэх, нэг эдийн засгаас хараат байдлыг бууруулах, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг хэрэгжүүлэх, цаашлаад хувийн хэвшил, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, экспортын зах зээлийг тэлэх, худалдааг хөнгөвчлөх бодлогыг хэрэгжүүлэх нь чухал ач холбогдолтой байна.

Монгол Улс, ЕАЭЗХ-ны гишүүн орнууд болох ОХУ, Бүгд Найрамдах Беларусь Улс (Беларусь), Бүгд Найрамдах Казахстан Улс (Казахстан), Бүгд Найрамдах Армени Улс (Армени), Бүгд Найрамдах Киргиз Улс (Киргиз) орнуудтай хийсэн гадаад худалдааны нийт бараа эргэлт 2024 онд 3.0 тэрбум ам.доллар байгаагаас 2.9 тэрбум ам.доллар нь импорт байна. Манай улстай хийсэн тус холбооны гишүүн 5 орны худалдааны 97.2 хувийг ОХУ, 1.8 хувийг Казахстан Улс, 0.8 хувийг Беларусь Улс, 0.1 хувийг Киргиз Улс, 0.02 хувийг Армен Улс тус тус бүрдүүлж байна. ЕАЭЗХ нь манай улсын нийт бараа эргэлтийн 11 хувь, экспортын 0.7 хувь, импортын 25 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд бараа эргэлтийн харьцаа 96:4 байна. Энэ нь гадаад худалдааны тэнцэл эрс алдагдсан байгааг харуулж байна.

ЕАЭЗХ нь гаалийн нэгдсэн нэг нутаг дэвсгэртэй ба бусад орнуудтай хийх худалдаанд гаалийн нэгдсэн нэг тарифын бодлогыг хэрэгжүүлдэг. ЕАЭЗХ-ны гишүүн орнуудаас хөдөө аж ахуй болон боловсруулах салбарын бүтээгдэхүүнд дунджаар 15-50 хувийн гаалийн тариф ногдуулж, хатуу тарифын бус шаардлагатай тулгарч байгаа нь Монгол Улсын бүтээгдэхүүн ЕАЭЗХ-ны зах зээлд нэвтрэх, өрсөлдөх чадварт сөрөг нөлөө үзүүлж байгаа гол хүчин зүйл болж байна.

Олон нийтийн хэлэлцүүлэг:

Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим (МҮХАҮТ), Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ)-ны холбогдох мэргэжилтнүүдтэй уулзалт зохион байгуулж, барааны жагсаалтын талаар санал солилцсон.

Эдийн засаг, хөгжлийн яам (ЭЗХЯ)-ны зүгээс 2023 оны 10 дугаар сарын 20-ны 03/1978 дугаартай албан бичгээр ХХААХҮЯ болон МҮХАҮТ-аас барааны жагсаалтад санал авсан. ХХААХҮЯ-ны 2023 оны 11 дүгээр 13-ны 01/3970 дугаартай албан бичиг ирүүлсэн хөдөө аж ахуй, мал аж ахуйн гаралтай барааны 96 хувийг манай улсаас экспортлох барааны жагсаалтад оруулсан. МҮХАҮТ-ийн 2023 оны 11 дүгээр сарын 29-ны 01/1124 тоот албан бичгээр Монгол Улсын гарал үүсэлтэй бүх барааны жагсаалтыг 2 хавсралтаар ирүүлсэн ба манай барааг 375 болгон гүйцээн жагсаалтад оруулсан.

ЭЗХЯ-ны зүгээс 2023 оны 12 дугаар 13-ны өдөр болон 2024 оны 05 дугаар сарын 09-ны өдрүүдэд 2 удаагийн төр, хувийн хэвшлийн нийт 150 гаруй төлөөлөгчидтэй хэлэлцүүлэг зохион байгуулж, санал авсан. Тухайлбал, Монголын арьс ширний үйлдвэрлэлийн холбоо желатин барааг экспортлох барааны жагсаалтад оруулах, хөдөлмөр хамгааллын арьсан бээлий болон гутал хамгаалах барааны жагсаалтад оруулах санал ирүүлсэн. Монголын ноос ноолуурын холбоо ОХУ-д экспортлох бараанд тулгардаг саад бэрхшээлийн талаар дурдсан. Мөн Монголын махны холбоо экспортлох барааны саналаа МҮХАҮТ-д албан бичгээр хүргүүлсэн саналыг тусгасан. Мөн, АПУ ХК-иас шингэн хүнсний бүтээгдэхүүнийг ЕАЭЗХ руу экспортлох барааны жагсаалтад оруулах санал ирүүлснийг хэлэлцээрт тусгасан.

Хэлэлцээрийн хамрах хүрээ:

Хэлэлцээр нь нийт 31 зүйл, 4 хавсралтаас бүрдэнэ. Үүнд Барааны ангилал, Гаалийн татварын хөнгөлөлт болон/эсхүл чөлөөлөлт, Гарал үүслийн дүрэм, Гаалийн байгууллага ба худалдааг хөнгөвчлөх, Гаалийн хамтын ажиллагаа, Чөлөөтэй дамжин өнгөрөх, Амьтан, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээ, Төлбөрийн тэнцлийг хангах зорилгоор хэрэгжүүлэх хязгаарлалт, Худалдааны хохирлыг арилгах арга хэмжээ, Ил тод байдал болон мэдээлэл солилцох, Цахим худалдаа, Эдийн засгийн хамтын ажиллагаа, Хамтарсан хороо багтаж байна.

Хэлэлцээрт хөрөнгө оруулалт, үйлчилгээний худалдаа, банк санхүү, төлбөр тооцоо зэрэг асуудлууд тусгагдаагүй, зөвхөн барааны худалдааны хүрээнд байгуулсан. Хэлэлцээрийг 3 жилийн хугацаатай байгуулах бөгөөд талууд өөрөөр тохиролцоогүй бол тус хугацаа сунгагдсанд тооцно. Мөн энэхүү хэлэлцээрт зөвхөн гаалийн тариф хамаарах бөгөөд НӨАТ, онцгой албан татварын зохицуулалт хамаарахгүй.

Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлснээр Монгол Улс ЕАЭЗХ-ны гишүүн улс болохгүй бөгөөд зөвхөн хэлэлцээрт хамрагдсан 367 нэр төрөл бүхий барааны хувьд Монгол Улс, ЕАЭЗХ болон түүний гишүүн улсуудын хоорондын худалдаанд тарифын хөнгөлөлт, илүү таатай нөхцөл бүхий эрх зүйн орчин бүрдүүлнэ.

Тарифын хөнгөлөлтийн жагсаалтын тухай:

Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем (БТКУС)-ийн 6 оронгийн түвшингийн Монгол Улсаас гаралтай 367 нэр төрлийн бараа нь 621 үндэсний кодтой

бараа, ЕАЭЗХ-ны гишүүн орнуудаас гаралтай нийт 367 нэр төрлийн бараа нь 499 үндэсний кодтой бараа болж тус тус гаалийн цахим үйлчилгээний системд бүртгэгдэнэ.

Монголын тал хэлэлцээрийн хүрээнд нийт 367 нэр төрлийн барааг сонгосон бөгөөд эдгээр нь манай улсын харьцангуй давуу тал бүхий мах, махан бүтээгдэхүүн, арьс, ширэн бүтээгдэхүүн, ноос, ноолуурын бүтээгдэхүүн, түүнчлэн сүү, цагаан идээ, малын дайвар бүтээгдэхүүн, тэжээл зэрэг хөдөө аж ахуйн салбарын бусад бүтээгдэхүүн, давс, хайлуур жонш, зэс, молибден, тугалга, гянтболд зэрэг бусад бүлгийн бараанаас бүрдэж байна. Эдгээр нь дотоодын түүхий эдэд тулгуурласан, нэмүү өртөг шингэсэн экспортын бүтцийг төрөлжүүлэх гол бараанууд юм.

Мах, махан бүтээгдэхүүний нийт 29 нэр төрлийн барааг ЕАЭЗХ-ны зах зээл рүү татваргүй гаргах боломжтой болж, одоогийн байдлаар ЕАЭЗХ-ны мах, махан бүтээгдэхүүний нийт импортын 0.8 хувийг (5.8 сая ам.доллар) цаашид тогтвортой нэмэгдүүлэх суурь бүрдэнэ. Өөрөөр хэлбэл, ЕАЭЗХ-той чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулаагүй бөгөөд мах, махан бүтээгдэхүүн экспортолдог гол нийлүүлэгч зарим улстай харьцуулахад 15-аас 50 хувийн гаалийн тариф ногдуулж буй Монгол Улсын бүтээгдэхүүн "0" хувийн татвартай болох нь зах зээл дээр шууд үнийн давуу талыг бий болгож, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ. ЕАЭЗХ-тай байгуулсан чөлөөт худалдааны хэлэлцээрт мах, махан бүтээгдэхүүн нь ЕАЭЗХ-ын хувьд эмзэг бараа гэж тооцогддог ба ЕАЭЗХ-той чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулсан орнууд болох Вьетнам, Серби, Иран зэрэг улсын хувьд энэ төрлийн бараанд татварын хөнгөлөлт аваагүй байна. Энэ нь Монгол Улсын хувьд ЕАЭЗХ-ны махны зах зээлд өрсөлдөхөд бусад улсад олгож буй тарифын хөнгөлөлтөөс илүү өргөн хүрээний, таатай, давуу байр суурийг бүрдүүлж байна.

Монгол Улсаас ЕАЭЗХ руу экспортлох 60 нэр төрлийн арьс, ширэн бүтээгдэхүүн, 204 нэр төрлийн ноос, ноолуурын бүтээгдэхүүн, 65 нэр төрлийн сүү, цагаан идээ, малын дайвар бүтээгдэхүүн зэрэг хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн "0" тарифтай болно. Үүнээс гадна хайлуур жонш, давс, зэс, молибден, тугалга, гянтболд зэрэг ашигт малтмалын барааг гаалийн татварыг тэглүүлнэ. Манай экспортлогч аж ахуйн нэгжүүд жилд хамгийн багадаа 16.6 сая ам.долларын гаалийн татвараас чөлөөлөгдөх боломж бүрдэнэ.

ЕАЭЗХ-аас Монгол Улсад импортлох 367 нэр төрлийн бүтээгдэхүүн нь аж үйлдвэрийн, хүнсний, эрдэс-химийн гэсэн 3 үндсэн хэсгээс бүрдэнэ. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 222 нэр төрлийн бараанд гаалийн татварыг тэглэснээр хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж, ган төмөр хийц, трансформатор, хүнд машин механизм зэрэг манай улсад үйлдвэрлэдэггүй барааг үйлдвэрлэлийн зориулалтаар хямд өртгөөр авах боломж бүрдэнэ.

Хүнсний 94 нэр төрлийн бүтээгдэхүүнд элсэн чихэр, хуурай сүү, өндөг, жимс зэрэг хүнсний орц бүтээгдэхүүн импортын татваргүй болсноор дотоодын үйлдвэрлэлийн өртөг буурна. Хүнсний салбарын өндөг, улаан буудай зэрэг бүтээгдэхүүнд квот тогтоон, зах зээлийг хамгаалах зохицуулалт тусгагдсан.

Эрдэс, химийн бүтээгдэхүүний салбарын бордоо, ургамлын хамгаалалтын бодис, витамин, вакцин, шингэн антибиотик, азотын бордоо, автобензин, дизель түлш,

шампунь, угаалгын нунтаг зэрэг газар тариалан, мал аж ахуй, эрүүл мэндийн салбарын зайлшгүй хэрэгцээтэй 51 нэр төрлийн бараанд ногдох гаалийн татварыг тэглэсэн.

Хэлэлцээрийн 19 дүгээр зүйлээр дотоодын зах зээлийг хамгаалах тусгай заалт тусгагдсан. Өөрөөр хэлбэл, тодорхой барааны импорт огцом өсөж, дотоодын үйлдвэрлэлд ноцтой хохирол учруулсан, эсхүл учруулах бодит эрсдэл бий болсон тохиолдолд Монгол Улс тул тариф нэмэгдүүлэх, квот тогтоох, тарифын хөнгөлөлтийг түр түдгэлзүүлэх, тарифын квот тогтоох зэрэг хамгаалалтын арга хэмжээг авах байдлаар дотоодын зах зээлийг хамгаалах боломжтой.

Гаалийн тарифын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх нөхцөл:

Талууд Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем (БТКУС)-ийн 6 оронгийн түвшинд ижил тооны барааг хэлэлцээрт хамруулж, гаалийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг эдлүүлэхээр тохиролцсон бөгөөд тус бүр 367 барааны жагсаалт хэлэлцээрийн хавсралтаар туссан.

Тайлбар: БТКУС-ын 6 орон нь Дэлхийн гаалийн байгууллагын гишүүн бүх орнуудад ижил түвшинд мөрдөнө.

Хөнгөлөлт, чөлөөлөлтийг дараах 4 төрлөөр эдлүүлнэ. Үүнд:

- Гаалийн тарифыг шууд тэглэх;
- Гаалийн тарифыг 25, эсхүл 50 хувиар бууруулах;
- Квот тогтоож, заасан хэмжээнд тарифыг тэглэх;
- Квот тогтоож, заасан хэмжээнд тарифыг бууруулах.

Монгол Улсаас ЕАЭЗХ-ны гишүүн орнуудад экспортлох нийт 621 үндэсний бараанаас 611 барааны гаалийн тарифыг тэглэх бөгөөд цагаан архи, шар айргийн тарифыг 25 хувиар, бусад бяслаг барааны тарифыг 50 хувиар бууруулна. Өөрөөр хэлбэл, манай улсын экспортын тэргүүлэх ач холбогдол бүхий бараанууд татваргүй экспорт хийх боломжтой. Монгол Улсаас ЕАЭЗХ-ны гишүүн орнууд руу экспортлоход одоогийн байдлаар ногдуулж буй татварын дараах хувь хэмжээ бүгд тэглэгдэнэ. Үүнд: үхрийн махны 50 хувь, адууны махны 15 хувь, махан бүтээгдэхүүний 15-аас 20 хувь, ноос ноолуурын 5-аас 10 хувь нэхмэл, оёмол эдлэлийн 18 хувь.

Тус хэлэлцээрийн хүрэх үр дүн, ач холбогдол нь Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээнүүдтэй нийцэх төдийгүй, төсөл, хөтөлбөрүүдийн хүрээнд боловсруулах үйлдвэрүүдийг ашиглалтад оруулах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх арга хэмжээнүүдтэй цаг хугацааны хувьд нийцтэй болно.

2023 оны ОХУ руу экспортын гүйцэтгэлээр тооцож үзвэл Монгол Улсын аж ахуйн нэгжүүд 1 жилд багадаа 16.6 сая ам.доллартай тэнцэх гаалийн тарифыг тэглүүлнэ.

Манай улсын стратегийн хүнсний бүтээгдэхүүн болох улаанбуудай болон өндөгний хувьд дотоодын үйлдвэрлэл, хэрэглээний хэмжээг харгалзан дотоодын

үйлдвэрлэлийг хамгаалах зорилгоор квот тогтоож, тарифыг тэглэхгүйгээр бууруулах байдлаар тохирсон.

Сүүлийн 3 жилийн өндөгний дотоодын нийт хэрэглээ 448.6 сая ширхэг бөгөөд үүнээс 165 сая ширхэг буюу 36.8 хувийг импортоор нийлүүлсэн. Дотоодын өндөг үйлдвэрлэлийг хамгаалах зорилгоор нийт зах зээлийн 20 хувийг импортын орон зайд хэвээр үлдээж, 90 сая ширхэг хүртэлх импортын өндөгт татварыг 50 хувь бууруулж, 7.5 хувийн татвартай байх, 90 саяас дээш импортолсон тохиолдолд татварыг хэвээр үлдээх буюу 15 хувийн татвартай байхаар тохиролцсон.

Жил бүр ургац хураалтын нөхцөл байдлаас хамааран 30.0-50.0 мянган тонн улаанбуудайг импортлох шаардлага үүсдэг. Энэ хүрээнд айлын талаас хатуу болон зөөлөн улаанбуудайд нийтдээ 180.0 мянган тонны квот санал болгосныг 50.0 мянган тонн болгон бууруулж, айлын талыг буулт хийлгэн талууд тохиролцоонд хүрсэн.

Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ)-ын 2024 оны тарифын мэдээллээр ЕАЭЗХ-ны нэн тааламжтай тарифын дундаж 6.6 хувь (хөдөө аж ахуйн бараанд 9.7 хувь) байхад Монгол Улсын нэн тааламжтай тарифын дундаж 5.2 хувь (хөдөө аж ахуйн бараанд 6.3 хувь) байгаа нь Монгол Улсын гаалийн тарифын дундаж ЕАЭЗХ-той харьцуулахад харьцангуй бага байна.

Ийнхүү Монгол Улсаас экспортлох бүтээгдэхүүний гаалийн тарифыг тэглэснээр тухайн барааг үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдийн орлого нэмэгдэж, хөдөө аж ахуйн салбарын шинэ зах зээлд нэвтрэх боломж бүрдэж, дотоодын бизнес эрхлэгчдийн гадаад худалдааны туршлага, чадвар нэмэгдэж, олон улсын стандартад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд түлхэц болно.

Хэлэлцээрийн хүлээгдэж буй үр дүн:

Олон улсад чөлөөт худалдааны хэлэлцээр хийхэд түгээмэл ашигладаг “Ерөнхий тэнцвэрийн загвар” (GТAP)-ын тооцооллын дагуу хэлэлцээр хэрэгжсэнээр манай улсын ДНБ 0.02 хувь, хөрөнгө оруулалт 2.57 хувь, ЕАЭЗХ руу хийх экспорт 24.1 хувь өсөх боломжтой байна.

Монгол Улсын хувьд ЕАЭЗХ-ны гишүүн орнуудад нийт 367 бараанд гаалийн тарифын хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлснээр аж ахуйн нэгжүүдийн орлого нэмэгдэж, хөдөө аж ахуйн салбарын шинэ зах зээлд нэвтрэх боломж бүрдэж, дотоодын бизнес эрхлэгчдийн гадаад худалдааны туршлага, чадварыг нэмэгдүүлж, олон улсын стандартад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд түлхэц болно.

Нийт экспортын хэмжээ 24.1 хувиар нэмэгдэнэ. Тухайлбал,

- Мах, махан бүтээгдэхүүний бүлэгт (үхрийн мах, хонь, ямааны мах, адууны мах, малын дайвар бүтээгдхүүн, утсан, нөөшилсөн мах зэрэг) хамаарах 15-аас 50 хувийн гаалийн татварыг тэглэснээр экспорт 140 хувь хүртэл өсөхөөр;

- Арьс, ширэн бүтээгдэхүүн (арьсан гарт цүнх, бээлий, савхин хувцас, нэхий, хүйтний хувцас, бүх төрлийн арьс, шир, желатин)-ий 5-аас 15 хувийн татварыг тэглэснээр экспорт 152 хувь хүртэл нэмэгдэхээр;
- Малын тэжээл, ясны шөл, биологийн идэвхт бодис, малын гаралтай бордоо, саван зэрэг бусад хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнд 5–12.5 хувийн татварыг тэглэснээр 140 хувь хүртэл өсөлт үзүүлэхээр;
- Ноос, ноолуурын хувцас, нэхмэл эдлэл, хөнжил, дэвсгэр зэрэг ноолуурын эцсийн бүтээгдэхүүнд 10-аас 18 хувийн гаалийн татварыг тэглэснээр экспортын хэмжээ 134 хувь хүртэл нэмэгдэхээр;
- Мөн гоймон, чихэр шоколад, төмс, хүнсний ногоо, чацаргана, жимсний шүүс, чанамал зэрэг хүнсний боловсруулсан бүтээгдэхүүний 8-аас 15 хувийн гаалийн татвар тэглэснээр дунджаар 51 хувийн өсөлт үзүүлэхээр;
- Архины болон шар айрагны тарифыг 25 хувиар бууруулснаар экспорт 17 хувиар өсөхөөр тус тус тооцооллын үр дүн гарсан байна.

Мөн Монгол Улсын уул уурхайн бус бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэн эдийн засаг төрөлжиж, аливаа нэг улсаас хамаарах худалдааны хамаарал байдал багасаж, эдийн засаг төрөлжинө. Энэ нь эдийн засгийн тогтвортой байдалд эерэг нөлөө үзүүлнэ.

Монгол Улсаас ЕАЭЗХ-д экспортлох бараанд үндэсний нөхцөл олгож байгаа буюу тухайн улсын дотоодод үйлчлэх татвар, хураамжтай ижил хэмжээний татвар ногдуулах, дотоодын бараатай ижил дүрэм, журам, шаардлага тавигдах боломж бүрдсэн.

Худалдаанд шаардлагагүй саад тотгор үүсгэсэн тохиолдолд Талууд Хамтарсан хорооны түвшинд техникийн зөвлөлдөх уулзалт хийн асуудлыг шийдвэрлэх нөхцөл бүрдсэн. Мөн хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн экспортлох үеийн эрүүл ахуй, хорио цээрийн шаардлагыг хялбаршуулах, тохирлын гэрчилгээний үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээг эхлүүлэх боломж бүрдэнэ.

Гаалийн үйл ажиллагааг хялбаршуулж, хөнгөвчилсөн. Тухайлбал, гаалийн мэдээллийг цахимаар солилцох боломж бүрдэж, өндөр эрсдэлтэй бараанд хяналт, шалгалтыг төвлөрүүлж, бага эрсдэлтэй бараанд гаалийн ажиллагааг хялбарчлахаар тусгагдсан. Гаалийн мэдүүлгийг бүртгэснээс хойш 4 цагаас хэтрэхгүй хугацаанд барааг олгохоор заасан. Тал тус бүр итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжид зориулсан худалдааг хөнгөвчлөх хөтөлбөрийг хэрэгжүүлэх, цаашид эдгээр аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг хөнгөвчлөх, хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар холбогдох зохицуулалтыг тусгасан.

Гарал үүслийн гэрчилгээг цахимаар солилцох боломж бүрдэж, заавал эх хувийг шаардахгүй байхаар тусгагдсан. Гадаад худалдаа эрхлэгч бараагаа экспортлох үед бүрдүүлэх гарал үүслийн гэрчилгээг МҮХАҮТ-аас авах шаардлагагүй бөгөөд 5000 еврогоос хэтрэхгүй бараанд гарал үүслийн мэдүүлгийг өөрөө гаргаж болохоор тусгасан.

Ийнхүү гарал үүслийн мэдүүлгийг өөрсдөө гаргах нь цаг хугацаа, зардал хэмнэсэн, жижиг, дунд үйлдвэрлэгчдийг дэмжсэн зохицуулалт болно.

ЕАЭЗХ-ны гишүүн орнуудаас гаралтай материалыг ашиглан Монгол Улсад үйлдвэрлэсэн барааг Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд тооцох боломжтой. Барааг гагцхүү тээвэрлэхэд зориулж савласан савлагаа, баглаа боодлын материал, хайрцаг савыг тухайн барааны гарал үүслийг тогтооход тооцохгүй, тухайн бараанд 50 хувиас ихгүй хувийн зохих гарал үүслийг тодорхойлсон нь барааг үйлдвэрлэхэд зарим нэг гарал үүсэлгүй материалыг ашиглах боломжийг олгосон нь үйлдвэрлэгчдэд гарал үүслийн хувьд илүү таатай нөхцөл олгоно. Дотоодын үйлдвэрлэл өссөнөөр ажлын байр нэмэгдүүлнэ. Хөдөө аж ахуйн салбарт чиглэсэн хөрөнгө оруулалт нэмэгдэнэ.

---o0o---

МОНГОЛ УЛС БОЛОН ЕВРАЗИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХОЛБОО,
ТҮҮНИЙ ГИШҮҮН ОРНУУД ХООРОНДЫН ХУДАЛДААНЫ ТҮР ХЭЛЭЛЦЭЭР

Нэг талаас Монгол Улс, нөгөө талаас Евразийн эдийн засгийн холбоо (цаашид “ЕАЭЗХ” гэх) болон түүний гишүүн болох Бүгд Найрамдах Армени Улс, Бүгд Найрамдах Беларусь Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс, Бүгд Найрамдах Киргиз Улс, Оросын Холбооны Улс (цаашид “ЕАЭЗХ-ны гишүүн орон” гэх):

Монгол Улс болон ЕАЭЗХ-ны гишүүн орнуудын харилцан сонирхсон салбарт худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих болон гүнзгийрүүлэхийг эрэлхийлэн;

зах зээлийн эдийн засгийн зарчмуудыг худалдаа, эдийн засгийн харилцааны үндэс болгон баримтлах үүрэг, амлалт болон Монгол Улс, ЕАЭЗХ-ны гишүүн орнууд хоорондын харилцан ашигтай худалдаа, эдийн засгийн харилцаанд идэвхтэй оролцох, өргөжүүлэн дэмжих эрмэлзлээ баталгаажуулан;

ЕАЭЗХ-ны хууль, Монгол Улсын болон ЕАЭЗХ-ны гишүүн орнуудын хууль, дүрэм, журам, түүнчлэн Дэлхийн худалдааны байгууллага (цаашид “ДХБ” гэх)-ын дүрэм, журмын дагуу бараа болон хөрөнгийн чөлөөтэй хөдөлгөөнд шаардлагатай нөхцөлийг бүрдүүлэн;

дараах зүйлийг тохиролцов:



1 дүгээр зүйл
Ерөнхий зүйл

1. Энэхүү Хэлэлцээрийн Талууд нь нэг талаас Монгол Улс, нөгөө талаас Евразийн эдийн засгийн холбооны 2014 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн хэлэлцээр (цаашид "ЕАЭЗХ-ны хэлэлцээр" гэх)-ээр олгогдсон эрх хэмжээний хүрээнд хамтран, эсхүл бие даан оролцох ЕАЭЗХ болон ЕАЭЗХ-ны гишүүн орнууд (цаашид "Талууд" гэх) болно.
2. Нэг талаас Монгол Улс, нөгөө талаас ЕАЭЗХ болон ЕАЭЗХ-ны гишүүн орнуудын хооронд чөлөөт худалдааны журам тогтоох зорилгоор Талууд хоорондын худалдааг энэ Хэлэлцээр болон ялангуяа 1994 оны Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр (цаашид "ТХЕХ" гэх)-ийн 24 дүгээр зүйл зэрэг ДХБ-ын дүрэм, журамд заасны дагуу чөлөөлнө.

2 дугаар зүйл
Зорилго

Энэхүү Хэлэлцээрийн зорилго нь түүний зарчим, дүрэмд тухайлан заасанчлан:

- (a) энэ Хэлэлцээрийн холбогдох заалтын дагуу Талууд хоорондын барааны худалдааг, тухайлбал тариф болон тарифын бус саад тотгорыг багасгах, эсхүл арилгах замаар хөнгөвчлөх болон чөлөөлөх;
- (b) Талууд хоорондын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааг дэмжих;
- (c) Талууд хоорондын худалдааг өргөжүүлэн төрөлжүүлэхийг дэмжихэд оршино.

3 дугаар зүйл
Олон улсын бусад хэлэлцээртэй уялдах нь

1. Энэхүү Хэлэлцээр болон 1994 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр байгуулсан Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Марракешийн хэлэлцээр (цаашид "ДХБ-ын хэлэлцээр" гэх)-ийн заалт хооронд аливаа зөрүү үүсэх тохиолдолд тухайн нийцэхгүй байгаа зохицуулалтад ДХБ-ын хэлэлцээр давуу эрхтэй байна.
2. Энэ зүйлийн 1 дүгээр хэсэгт заасан зөрүүтэй байдал үүссэн тохиолдолд харилцан хүлээн зөвшөөрөх шийдэлд хүрэхийн тулд Талууд даруй зөвлөлдөнө.



4 дүгээр зүйл
Барааны ангилал

1. Талуудын хоорондын худалдаанд хамаарах барааны ангиллыг 1983 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн тухай олон улсын конвенцоор тогтоосон Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем (цаашид "Уялдуулсан Систем", эсхүл "УС" гэх)-д нийцүүлсэн Талуудын холбогдох тарифын жагсаалтаар зохицуулна.
2. Тал тус бүр өөрийн тарифын жагсаалтад аливаа өөрчлөлт оруулахдаа энэхүү хэлэлцээрийн Хавсралт 1 (ЕАЭЗХ-ны тарифын үүрэг амлалтын жагсаалт) ба 2 (Монгол Улсын тарифын үүрэг амлалтын жагсаалт)-т заасны дагуу тогтоосон тарифын хөнгөлөлтийг бууруулахгүй, сөрөг нөлөө үзүүлэхгүй байхыг хангана. ЕАЭЗХ-ны Гадаад эдийн засгийн үйл ажиллагааны барааны жагсаалт болон Монгол Улсын Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системд Евразийн эдийн засгийн комисс болон Монгол Улс тус тус өөрчлөлт оруулна.

5 дугаар зүйл
Гаалийн татварын хөнгөлөлт болон/эсхүл чөлөөлөлт

1. Тал тус бүр энэхүү Хэлэлцээрийн Хавсралт 1 болон 2-т заасны дагуу Талуудын Тарифын үүрэг амлалтын жагсаалтад тусгагдсан нөхцөлөөс дутуугүй таатай нөхцөлийг нөгөө Талаас гарал үүсэлтэй бараанд олгоно.
2. Аль нэг Тал аливаа барааг импортлоход дараахыг ямар ч үед ногдуулахад энэ зүйл аливаа байдлаар саад болохгүй:
 - (a) дотоодын үйлдвэрийн ижил барааны хувьд энэхүү Хэлэлцээрийн 9 дүгээр зүйл (Үндэсний нөхцөл)-ийн дагуу ногдуулж буй дотоодын татвартай тэнцэх хураамж;
 - (b) Талуудын хууль, журмын дагуу энэ Хэлэлцээрийн 19 дүгээр зүйл (Худалдааны хохирлыг арилгах арга хэмжээ)-ийн дагуу ногдуулсан аливаа татвар;
 - (c) энэхүү Хэлэлцээрийн 7 дугаар зүйл (Хураамж болон шимтгэл)-ийн дагуу үзүүлсэн үйлчилгээний өртөгтэй дүйцэх бусад хураамж, эсхүл шимтгэл.
3. Энэхүү Хэлэлцээрийн Хавсралт 1 болон 2-т заасны дагуу нэг Талаас гарал үүсэлтэй бараанд ногдуулах гаалийн хөнгөлөлттэй татварын хувь хэмжээ нь тухайн бараанд үндэсний нэн тааламжтай нөхцөлөөр ногдуулах гаалийн



татварын хувь хэмжээнээс өндөр байх тохиолдолд үндэсний нэн тааламжтай нөхцөлийн татварын хувь хэмжээг баримтална.

4. Экспортын татварыг Талуудын холбогдох хууль, журам болон ДХБ-ын хэлэлцээрээр хүлээсэн үүргийн дагуу тус тус ногдуулна.

6 дугаар зүйл

Үндэсний нэн тааламжтай нөхцөл

1994 оны ТХЕХ-ийн 1 дүгээр зүйл болон түүний тайлбар тэмдэглэл, ДХБ-ын хэлэлцээрийн дагуу хэрэгжүүлэх 1994 оны ТХЕХ-ийн 1 дүгээр зүйлд заасан нөхцөлийг олгох үүргээс чөлөөлөгдөх, үл хамаарах, үл үйлчлэх зэрэг нь энэ Хэлэлцээрт хамаарч байгаа бөгөөд Хэлэлцээрийн салшгүй хэсэг мөн.

7 дугаар зүйл

Хураамж ба шимтгэл

Тал тус бүр барааны импорт, экспортод ногдуулах, эсхүл тэдгээрт холбогдох бүх хураамж, шимтгэл нь 1994 оны ТХЕХ-ийн 8 дугаар зүйлд нийцсэн байхыг баталгаажуулна. Энэ зорилгоор 1994 оны ТХЕХ-ийн 8 дугаар зүйл болон түүний тайлбар тэмдэглэл, нэмэлт заалтууд энэ Хэлэлцээрт хамаарч байгаа бөгөөд Хэлэлцээрийн салшгүй хэсэг мөн.

8 дугаар зүйл


Хориг, тооны хязгаарлалт болон
түүнтэй адилтгах нөлөө бүхий арга хэмжээ

Энэ Хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол Талууд 1994 оны ТХЕХ-ийн 11 болон 8 дугаар зүйлд нийцүүлэн Талуудын хоорондын худалдаанд хамаарах барааны импорт, экспортод хориг тавих, тооны хязгаарлалт тогтоох, эсхүл түүнтэй адилтгах нөлөө бүхий арга хэмжээ авч хэрэгжүүлж болно.

9 дүгээр зүйл

Үндэсний нөхцөл

Тал тус бүр нөгөө Талын бараанд 1994 оны ТХЕХ-ийн 3 дугаар зүйлийн дагуу үндэсний нөхцөл олгоно. Энэ зорилгоор 1994 оны ТХЕХ-ийн 3 дугаар зүйл болон түүний тайлбар энэ Хэлэлцээрт хамаарах бөгөөд Хэлэлцээрийн салшгүй хэсэг мөн.



10 дугаар зүйл
Худалдаан дахь техникийн саад тотгор

1. Талууд ДХБ-ын хэлэлцээрийн Хавсралт 1А-гийн Худалдаан дахь техникийн саад тотгорын тухай хэлэлцээрийн заалтуудад нийцүүлэн техникийн зохицуулалтын чиглэлээр дотоодын холбогдох хууль, журмыг хэрэгжүүлнэ.
2. Талууд энэхүү хэлэлцээрийн заалтуудыг хэрэгжүүлэх үүднээс стандартчилал, техникийн зохицуулалт, хэмжил зүй, зах зээлийн тандалт болон магадлан итгэмжлэл, туршилт, баталгаажуулалтыг хамарсан тохирлын үнэлгээний асуудал хариуцсан эрх бүхий байгууллагын хооронд хоёр талын хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжинэ.
3. Талууд худалдааг хөнгөвчлөх зорилгоор тодорхой бараа, эсхүл бүлэг барааны хувьд тохирлын үнэлгээний журмын үр дүнг харилцан зөвшөөрөх зэрэг техникийн саад тотгорыг арилгах тухай хэлэлцээрт гарын үсэг зурах талаар хэлэлцээ эхлүүлж болно.
4. Заавал биелүүлэх шаардлагад бараа нийцэж байгаа эсэх тухай тохирлыг үнэлэх шаардлага, аргачлалыг импортлогч Талын холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу болон ДХБ-ын хэлэлцээрийн Хавсралт 1А-гийн Худалдаан дахь техникийн саад тотгорын тухай хэлэлцээрийн зүйл, заалтуудад нийцүүлэн Талуудын холбогдох эрх бүхий байгууллага тодорхойлно.
5. Хэрэв нэг Талаас экспортолсон барааг нөгөө Талын техникийн зохицуулалт, эсхүл тохирлын үнэлгээний журмын дагуу нийцлийг баталгаажуулахад шаардагдах баримт бичгийн бүрдэл дутуу, эсхүл импортлогч Талын техникийн зохицуулалт, эсхүл тохирлын үнэлгээний шаардлагыг хангаагүй гэх үндэслэлээр орох боомт дээр саатуулсан тохиолдолд саатуулсан шалтгааныг импортлогч Талд эсхүл түүний төлөөлөгч (тээвэрлэгч)-д яаралтай мэдэгдэнэ.
6. Талуудын нэг нь нөгөө Талын авсан арга хэмжээ нь худалдаанд шаардлагагүй саад тотгор үүсгэсэн, эсхүл үүсгэж болзошгүй гэж үзсэн тохиолдолд Талууд харилцан хүлээн зөвшөөрч болох шийдвэрт хүрэх зорилгоор Хамтарсан хорооны хүрээнд техникийн зөвлөлдөх уулзалт хийнэ. Техникийн зөвлөлдөх уулзалтыг Талуудын харилцан тохиролцсон аливаа хэлбэрээр зохион байгуулж болно.



11 дүгээр зүйл
Амьтан, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээ

1. Талууд амьтан, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээнд хамаарах хууль болон журмыг ДХБ-ын Хавсралт 1А-гийн Амьтан, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэх тухай хэлэлцээрийн дагуу хэрэгжүүлнэ.
2. Талуудын хоорондын худалдаанд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах зорилгоор амьтан, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээг боловсруулах, батлах болон/эсхүл хэрэгжүүлэх асуудлын талаар нэмэлт тохиролцоонд хүрч болно.
3. Хоорондын худалдаанаас үүссэн, эсхүл үүсэж болзошгүй амьтан, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээтэй холбоотой аливаа асуудлын талаар нэг Тал бичгээр хүсэлт гаргасан тохиолдолд нөгөө Тал цаг тухайд нь мэдээллийг гаргаж өгнө.
4. Хэрэв нэг Тал нь нөгөө Талыг худалдаанд далд хориг үүсгэх, эсхүл үүсгэсэн арга хэмжээг авсан гэж үзвэл Хамтарсан хорооны хүрээнд Талууд тохиролцон техникийн зөвлөлдөх уулзалт хийнэ. Техникийн зөвлөлдөх уулзалтыг Талуудын харилцан тохиролцсон аливаа хэлбэрээр зохион байгуулж болно.

12 дугаар зүйл
Барааны гарал үүсэл


Барааны гарал үүслийг энэхүү хэлэлцээрийн Хавсралт 3-д заасан “Гарал үүслийн дүрэм”-д үндэслэн тодорхойлно.

13 дугаар зүйл
Гаалийн байгууллага ба худалдааг хөнгөвчлөх

1. Энэхүү зүйлийг гаалийн байгууллагын арга хэмжээнд, мөн Талууд хооронд худалдаалсан барааг олгоход шаардлагатай гаалийн арга ажиллагаанд дараах зүйлсийг хөхиүлэн дэмжих зорилгоор мөрдөнө:
 - (a) гаалийн горим болон гаалийн ёс журмын ажиллагаа ил тод байх;
 - (b) худалдааг хөнгөвчлөх; мөн
 - (c) гаалийн хамтын ажиллагаа, түүний дотор Талуудын гаалийн байгууллагууд хоорондоо мэдээлэл солилцох.
2. Талууд нь өөрсдийн гаалийн байгууллагаас авч хэрэгжүүлж буй гаалийн байгууллагын арга хэмжээ тодорхой, нийцтэй, ил тод байх нөхцөлийг бүрдүүлнэ.



3. Талуудын гаалийн горим нь боломжтой бол, мөн тэдгээрийн гаалийн хууль тогтоомж, дүрэм журмыг үл зөрчих хэмжээнд, Дэлхийн гаалийн байгууллагын стандарт заалтууд болон практик зөвлөмжийг үндэслэсэн байна.
4. Талуудын гаалийн байгууллагууд нь тэдгээрийн гаалийн байгууллагын арга хэмжээг худалдааг хөнгөвчлөх зорилгоор хялбарчлах үүднээс хянан үзэж байхыг эрмэлзэнэ.
5. Талууд гаалийн хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх дүрэм журмыг аль болох англи хэлээр нийтэлнэ.
6. Талууд тэдгээрийн хоорондын худалдааг хөнгөвчлөх үүднээс барааг түргэн шуурхай олгоход чиглэсэн гаалийн горим, арга ажиллагаа баталж, эсхүл тийм горим, арга ажиллагаатай бол цаашид үргэлжлүүлэн мөрдөнө. Энэ нь аль нэг Талын бараа олгоход тавьсан шаардлага хангагдаагүй тохиолдолд уг барааг олгохыг тухайн Талаас шаардаагүй болно.
7. Талууд энэхүү зүйлийн 6 дахь хэсэгт заасны дагуу дараах арга хэмжээг авна:
 - (a) Талуудын гаалийн хууль тогтоомж, дүрэм журамд өөрөөр зааснаас бусад тохиолдолд, барааг гаалийн мэдүүлгийг бүртгэснээс хойш 4 цагаас илүүгүй хугацааны дотор олгохоор заах;
 - (b) бараа ирмэгц түргэн шуурхай олгох нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор гаалийн мэдээллийг бараа ирэхээс өмнө цахимаар илгээх болон боловсруулах журам батлах, эсхүл тийм журамтай бол цаашид үргэлжлүүлэн мөрдөх;
 - (c) хяналт шалгалтыг өндөр эрсдэлтэй бараанд төвлөрүүлэх, бага эрсдэлтэй бараанд хамаарах гаалийн арга ажиллагааг хялбарчлах зорилгоор эрсдэлийг системтэй үнэлэх боломжтой эрсдэлийн удирдлагын системийг хэрэгжүүлэх.
8. Талууд цаашид Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж (ИААН)-ийн хөтөлбөр гэх аюулгүй байдлын тодорхой шалгуур хангасан аж ахуйн нэгжид зориулсан худалдааг хөнгөвчлөх түншлэлийн хөтөлбөрийг Дэлхийн гаалийн байгууллагын Дэлхийн худалдааг аюулгүй байлгах, хөнгөвчлөх Аюулгүй байдлын багц стандартын дагуу хэрэгжүүлнэ.
9. Талууд дараах байдлаар хамтран ажиллахыг эрмэлзэнэ:
 - (a) тэдгээрийн ИААН-ийн холбогдох хөтөлбөрийг хэрэгжүүлсэн болон сайжруулсан туршлагаасаа солилцох, боломжтой бол шилдэг туршлагуудаас нэвтрүүлэхийг эрмэлзэх;



- (b) хөтөлбөр тус бүрийн дагуу итгэмжлэл авсан аж ахуйн нэгжүүдийн талаарх мэдээллийг тус тусын Талын хууль тогтоомж болон тогтсон журмын дагуу харилцан солилцох;
- (c) Нөгөө Талын итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжид худалдааг хөнгөвчлөх чиглэлээр үзүүлэх хөнгөлөлтийг тодорхойлох, хэрэгжүүлэхэд хамтран ажиллах.

14 дүгээр зүйл
Гаалийн хамтын ажиллагаа

1. Энэхүү Хэлэлцээр үр дүнтэй хэрэгжих явдлыг хөнгөвчлөх зорилгоор Талуудын гаалийн байгууллагууд Талууд хооронд худалдаалсан бараанд нөлөөлөхүйц гаалийн гол гол асуудлын хүрээнд бие биетэйгээ хамтран ажиллахыг хөхүүлэн дэмжинэ.
2. Аль нэг Талын гаалийн байгууллага өөрийн холбогдох хууль тогтоомж болон дүрэм журмынхаа дагуу хууль бус ямар нэг үйл ажиллагаа явагдсан гэх баттай сэжиг тогтоосон бол ерөнхийдөө бараа гаргах болон (эсхүл) оруулахтай холбогдуулан хүлээн авдаг тусгайлсан нууц мэдээлэл өгөхийг нөгөө Талын гаалийн байгууллагаас хүсэж болно.
3. Аль нэг Талаас энэхүү зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу гаргасан хүсэлт нь бичгээр байх бөгөөд түүнд тухайн мэдээллийг ямар зорилгоор хүсэж байгаа талаар тодорхой бичсэн, мөн тухайн барааг ялган таних хангалттай мэдээллийг хавсаргасан байна. Хүсэлтийг энэ Зүйлийн 6 дахь хэсэгт заасан харилцаа холбооны сувгийг ашиглан цахим хэлбэрээр дамжуулна. Мөн хүсэлтийн цаасан хувийг шуудангаар илгээнэ. Энэхүү зүйлд заасан бүх хүсэлт, тэдгээрийн бүх хариуг англи хэл дээр илгээнэ.
4. Энэхүү зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу гаргасан хүсэлтийг хүлээн авсан Талын гаалийн байгууллага нь уг хүсэлтэд заасан мэдээлэл агуулсан хариуг өөрийн Талын холбогдох хууль тогтоомж болон дүрэм журмын дагуу, уг хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 2 (хоёр) сарын дотор бичгээр гаргаж өгнө. Хариуг тогтоосон хугацаанд бүрэн, эсхүл хэсэгчилсэн байдлаар гаргаж өгөх боломжгүй бол хүсэлт хүлээн авсан гаалийн байгууллага нь хүсэлт гаргасан гаалийн байгууллагад тухайн мэдээллийг гаргаж өгөх тодорхой хугацааг мэдэгдэнэ.
5. Энэ зүйлийн 2-4 дэх хэсэгт заасны дагуу гаргаж өгсөн бүх мэдээллийг Талууд нууцад тооцно. Уг мэдээллийг шүүхийн шүүн таслах ажиллагаанд ашиглахаас



бусад тохиолдолд түүнийг гаргаж өгсөн Талын этгээдийн, эсхүл эрх бүхий байгууллагын бичгээр үйлдсэн зөвшөөрөлгүйгээр задруулахыг хориглоно.

6. Талуудын гаалийн байгууллагууд мэдээллийг түргэн шуурхай бөгөөд аюулгүй байдлаар солилцох, мөн гаалийн асуудлыг зохицуулах ажлыг боловсронгуй болгох явдлыг хөнгөвчлөх үүрэг бүхий холбоо барих этгээдүүдийг томилох зэргээр гаалийн хамтын ажиллагааны харилцаа холбооны сувгууд бий болгож, ажиллуулахыг эрмэлзэнэ.
7. Гаалийн байгууллага ба худалдааг хөнгөвчлөхөд хамаарах тодорхой асуудлуудыг хэлэлцэх техникийн уулзалтуудыг Талуудын тохиролцсон хугацаа, газарт зохион байгуулна.
8. Талууд гаалийн горим хэрэгжүүлэх ажлыг хөнгөвчлөх, мөн гаалийн хууль тогтоомж, дүрэм журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Талууд хооронд худалдаалсан бараатай холбоотой мэдээллийг Талуудын гаалийн байгууллага хооронд тогтмол солилцох (цаашид "мэдээллийг цахимаар солилцох" гэх) арга хэмжээ авч, хэрэгжүүлж болно.
9. Мэдээллийг цахимаар солилцох үйл ажиллагаанд тавигдах бүх шаардлага, техникийн тодорхойлолтыг, мөн солилцох мэдээллийн тодорхой агуулгыг ЕАЭЗХ-ны гишүүн орнуудын болон Монгол Улсын эрх бүхий байгууллага хооронд тохиролцсон тусгай протоколоор тодорхойлно.
10. Талууд мэдээллийг цахимаар солилцохдоо ЕАЭЗХ-ны Мэдээллийн нэгдсэн системийн техникийн дэд бүтэц болон Монгол Улсын холбогдох дэд бүтцийг ашиглана.
11. ЕАЭЗХ-г төлөөлж Евразийн эдийн засгийн комисс мэдээллийг цахимаар солилцох, түүний ажиллагааг хялбарчлах ажлыг зохион байгуулна.

15 дугаар зүйл

Чөлөөтэй дамжин өнгөрөх

1994 оны ТХЕХ-ийн 5 дугаар зүйл болон ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн 11 дүгээр зүйл энэ Хэлэлцээрт хамаарах бөгөөд Хэлэлцээрийн салшгүй хэсэг мөн.



16 дугаар зүйл
Үл хэрэглэх нийтлэг тохиолдол

1. Тухайн арга хэмжээг ижил нөхцөлтэй улсуудын хооронд хүндэтгэх шалтгаангүйгээр алагчлах хэрэгсэл, эсхүл олон улсын худалдаанд далд хязгаарлалтын хэлбэрээр хэрэглэхгүй байх нөхцөлийг хангасан бол энэхүү хэлэлцээрийн заалтууд нь аль нэг Тал дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд саад болохгүй:

- (a) олон нийтийн ёс суртахууныг хамгаалахад шаардлагатай;
- (b) хүн, амьтан, эсхүл ургамлын амьдрал, эсхүл эрүүл мэндийг хамгаалахад шаардлагатай;
- (c) алт, эсхүл мөнгийг импортлох, экспортлоход холбогдох;
- (d) 1994 оны ТХЕХ-ийн 2 дугаар зүйлийн 4 дэх хэсэг болон 17 дугаар зүйлийн дагуу үйл ажиллагаа явуулж буй дангаар ноёрхогчийн эсрэг гаалийн хууль, патент, барааны тэмдэг, зохиогчийн эрхийг хамгаалах болон хууран мэхлэх хэв заншлаас урьдчилан сэргийлэх зэргийг оролцуулан энэхүү Хэлэлцээрийн заалтуудтай нийцсэн хууль тогтоомжийг дагаж мөрдөхөд шаардлагатай;
- (e) хоригдлуудын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнтэй холбогдсон арга хэмжээ;
- (f) уран сайхны, түүх, археологийн ховор үндэсний баялгийг хамгаалах зорилгоор авах;
- (g) хэрэв тухайн арга хэмжээг дотоодын үйлдвэрлэл, эсхүл хэрэглээг хязгаарлахтай уялдуулан авсан бол байгалийн шавхагдах нөөцийг хэвээр хадгалахтай холбогдсон арга хэмжээ;
- (h) ДХБ-д өргөн мэдүүлсэн шаардлагад нийцсэн, ДХБ-аас зөвшөөрөгдөөгүй бус, эсхүл ДХБ-д гэрээг танилцуулж ДХБ-аас зөвшөөрөгдөөгүй бус засгийн газар хоорондын түүхий эдийн гэрээний үүргийг биелүүлэх зорилгоор хэрэгжүүлж буй;
- (i) засгийн газрын тогтворжуулах төлөвлөгөөний хүрээнд дотоодын түүхий эдийн үнийг дэлхийн зах зээлийн үнээс доогуур байх үед дотоодын үйлдвэрийг шаардлагатай түүхий эдээр хангах үүднээс дотоодын түүхий эдийн экспортод хязгаарлалт тавихтай холбогдсон арга хэмжээ; энэхүү хязгаарлалт нь тухайн дотоодын үйлдвэрийг хамгаалах, эсхүл экспортыг нэмэгдүүлэх зорилгогүй байх бөгөөд 1994 оны ТХЕХ-ийн үл ялгаварлах зарчмыг зөрчөөгүй байх нөхцөлийг хангасан байна;
- (j) нийтээр, эсхүл орон нутагт хомсдол үүссэн барааг олж авах, хуваарилахад зайлшгүй шаардагдах; энэхүү арга хэмжээ нь Талууд тухайн барааны олон улсын нийлүүлэлтээс шударга, тэнцүү хувь хүртэх эрхтэй гэсэн зарчимд

нийцсэн байх ёстой бөгөөд эдгээр арга хэмжээ нь энэхүү Хэлэлцээрийн бусад заалтуудтай зөрчилдөж байвал уг арга хэмжээг бий болгосон нөхцөл байдал арилмагц даруй зогсооно.

2. Талууд энэхүү зүйлийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болон тэдгээрийг дуусгавар болгосон тухай бие биедээ боломжит хэмжээнд мэдээлнэ.

17 дугаар зүйл

Аюулгүй байдлын үндэслэлээр үл хамаарах

Энэхүү Хэлэлцээрийн заалтууд нь:

- (a) задруулснаар аюулгүй байдлын нэн чухал ашиг сонирхолд нь харшлах аливаа мэдээллээр хангахыг аль нэг Талаас шаардахгүй; эсхүл
- (b) аюулгүй байдлын эн тэргүүний ашиг сонирхлоо хамгаалахад шаардлагатай гэж үзсэн аливаа үйлдэл хийхэд нь аль нэг Талд саад болохгүй:
 - (i) цөмийн зэвсэг үйлдвэрлэхэд ордог материалтай холбогдох;
 - (ii) зэвсэг, техник, түүний сэлбэг хэрэгсэл болон цэрэг дайны зориулалтаар шууд буюу шууд бус байдлаар нийлүүлэх бараа, материалын худалдаатай холбогдох;
 - (iii) дайн, эсхүл олон улсын харилцаан дахь бусад онцгой байдал бүхий үед авсан арга хэмжээ; эсхүл
- (c) энх тайван, аюулгүй байдлыг тогтоох тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмээр хүлээсэн үүргээ биелүүлэх хүрээнд аливаа үйлдэл хийхэд аль нэг Талд саад болохгүй.

18 дугаар зүйл

Төлбөрийн тэнцлийг хангах зорилгоор хэрэгжүүлэх хязгаарлалт

1. Аль нэг Талд төлбөрийн тэнцэл болон гадаад санхүүгийн ноцтой хүндрэл учирсан, эсхүл учирч болзошгүй бол 1994 оны ТХЕХ-ийн 12 дугаар зүйл, 1994 оны ТХЕХ-ийн төлбөрийн тэнцэлтэй холбогдсон заалтын тухай харилцан ойлголцлын баримт бичгийн дагуу импортыг хязгаарлах арга хэмжээ хэрэгжүүлж болно. Тухайн хязгаарлалтын арга хэмжээ нь Олон улсын валютын сангийн тухай хэлэлцээрт нийцүүлнэ.



2. Тухайн арга хэмжээг авч хэрэгжүүлэх гэж буй Тал нь төлбөрийн тэнцлийг хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухай болон хэрэгжүүлэх, цуцлах хугацааны талаар нөгөө Талдаа мэдэгдэнэ.

3. Энэ зүйлийн 1 дүгээр хэсгийн дагуу хязгаарлалтын арга хэмжээ хэрэгжүүлсэн, эсхүл үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн тохиолдолд, тухайн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн Тал Хамтарсан хорооны зөвлөгөөнийг хязгаарлалтын арга хэмжээг хэлэлцэх зорилгоор яаралтай зохион байгуулна. Зөвлөгөөнөөр хязгаарлалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн Талын төлбөрийн тэнцлийн нөхцөл байдал болон энэ зүйлийн дагуу авч хэрэгжүүлсэн, эсхүл үргэлжлүүлэн авсан арга хэмжээг үнэлэх бөгөөд дараах зүйлсийг харгалзан үзнэ:


- (a) төлбөрийн тэнцлийн хүндрэл бэрхшээлийн шинж чанар, цар хүрээ;
- (b) эдгээр хязгаарлалтын арга хэмжээний нөгөө Талын эдийн засагт үзүүлэх боломжит нөлөө;
- (c) залруулах боломжит арга хэмжээний бусад хувилбар.

Зөвлөгөөнөөр хязгаарлалтын аливаа арга хэмжээ нь 1994 оны ТХЕХ-ийн 12 дугаар зүйлд нийцэж байгаа эсэхийг хэлэлцэнэ.

19 дүгээр зүйл

Худалдааны хохирлыг арилгах арга хэмжээ

1. Талууд нийтлэг хамгаалалтын, демпингийн эсрэг болон татаасны эсрэг хариу арга хэмжээг ДХБ-ын хэлэлцээрийн Хавсралт 1А-д заасан 1994 оны ТХЕХ-ийн 19 болон 6 дугаар зүйлийн нөхцөлүүд, Хамгаалалтын арга хэмжээний тухай хэлэлцээр, 1994 оны ТХЕХ-ийн 6 дугаар зүйлийг хэрэгжүүлэх тухай хэлэлцээр, Татаас болон хариу арга хэмжээний тухай хэлэлцээр, ДХБ-ын хэлэлцээрийн 1А хавсралтад тусгагдсаны дагуу хэрэгжүүлнэ.
2. Нийтлэг хамгаалалтын, демпингийн эсрэг болон татаасны эсрэг арга хэмжээний мөрдөн шалгалт, эдгээр арга хэмжээнээс тойрч гарах оролдлогын эсрэг зэрэг бусад холбогдох арга хэмжээг Монгол Улсаас авч хэрэгжүүлэхдээ ЕАЭЗХ-ны эсрэг бүхэлд нь бус гишүүн тус бүрээр авч үзэх бөгөөд ЕАЭЗХ-ноос оруулж буй импортыг бүхэлд нь нэг гэж тооцон демпингийн эсрэг, саармагжуулах болон нийтлэг хамгаалалтын арга хэмжээ, тойрч гарах оролдлогын эсрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхгүй.



3. Демпингийн эсрэг болон татаасны эсрэг хариу татвар ногдуулахтай холбоотой мөрдөн шалгах ажиллагаа эхлүүлэх гэж буй Тал нь мөрдөн шалгах ажиллагааг эхлэхээс 15 (арван тав)-аас доошгүй хоногийн өмнө мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлэх өргөдөл хүлээн авсан тухайгаа нөгөө Талдаа бичгээр мэдэгдэнэ.
4. Нийтлэг хамгаалалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй Тал нь нөгөө Талдаа мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлэхтэй холбоотой бүх мэдээлэл, мөрдөн шалгалтын урьдчилсан болон эцсийн дүгнэлтийн талаар нэн даруй бичгээр мэдэгдэнэ.
5. Аль нэг Тал бичгээр хүсэлт гаргасан даруйд Талууд демпингийн эсрэг, татаасны эсрэг болон нийтлэг хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар зөвлөлдөж болно. Энэхүү зөвлөлдөх уулзалтыг бичгээр ирүүлсэн хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 (гуч) хоногийн дотор боломжит хурдан хугацаанд зохион байгуулна. Ийнхүү зөвлөлдөх нь Талуудыг демпингийн эсрэг, татаасны эсрэг хариу татвар, эсхүл нийтлэг хамгаалалтын арга хэмжээний мөрдөн шалгалтыг эхлүүлэхэд саад болохгүй бөгөөд мөрдөн шалгалтын ажиллагааг зогсоохгүй.

20 дугаар зүйл
Маргаан шийдвэрлэх

Энэхүү хэлэлцээрийг тайлбарлах ба/эсхүл хэрэглэхтэй холбогдон үүссэн Талууд хоорондын аливаа маргааныг энэхүү хэлэлцээрийн Хавсралт 4 "Маргаан шийдвэрлэх"-д заасан дүрэм, журмын дагуу шийдвэрлэнэ.

21 дүгээр зүйл
Ил тод байдал болон мэдээлэл солилцох

1. Тал тус бүр энэхүү хэлэлцээрт хамаарах аливаа асуудалд холбогдох нийтээр дагаж мөрдөх хууль болон журам, олон улсын гэрээг хүчин төгөлдөр болохоос нь өмнө буюу хүчин төгөлдөр болох үед дотоодын хууль, журмын дагуу нийтлэх, эсхүл боломжтой бол цахим болон бусад хэлбэрээр нийтэд ил болгоно.
2. Тал тус бүр энэхүү хэлэлцээрийн хэрэгжилтэд ноцтой нөлөөлөх, эсхүл энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх хүрээнд нөгөө Талын ашиг сонирхолд ихээхэн нөлөө үзүүлж болзошгүй гэж үзэх аливаа арга хэмжээний талаар аль болох боломжит хэмжээнд нөгөө Талд мэдэгдэнэ.



22 дугаар зүйл
Нууц мэдээлэл

1. Тал тус бүр энэхүү хэлэлцээрийн дагуу нөгөө Талаас өгсөн мэдээллийн нууцлалыг дотоодын холбогдох хууль, журмын дагуу хамгаална.
2. Хэрэв задруулсан тохиолдолд хууль сахиулах үйл ажиллагаанд саад учруулах, эсхүл Хэлэлцээрийн талын хууль болон журмаар задруулахыг хориглосон эсхүл хязгаарласан, эсхүл нийтийн ашиг сонирхолд харшлах, эсхүл төрийн болон хувийн аж ахуйн нэгж, тодорхой хуулийн этгээд (аливаа эдийн засгийн оператор)-ийн хууль ёсны арилжааны ашиг сонирхолд хохирол учруулах мэдээллийг өгөх, эсхүл түүнд хандах боломжоор хангах үүргийг аль ч Тал энэхүү Хэлэлцээрийн хүрээнд хүлээхгүй.

23 дугаар зүйл
Цахим худалдаа

1. Энэхүү зүйл нь Хэлэлцээрийн аль нэг Талын цахим худалдаанд нөлөөлөх, шинээр хэрэгжүүлсэн, эсхүл хэрэгжүүлж буй арга хэмжээнд үйлчилнэ.
2. Талууд нь цахим худалдаанаас бий болох эдийн засгийн өсөлт, боломжууд, мөн Талуудын хоорондын худалдааны өсөлтөд эерэг нөлөө үзүүлэх цахим худалдааны шинэлэг бөгөөд динамик шинж чанар, цахим худалдаанд итгэх хэрэглэгчдийн итгэлийг нэмэгдүүлэхийн ач холбогдлыг хүлээн зөвшөөрч байна.
3. Талууд нь үр ашигтай хил дамнасан худалдааг хөнгөвчлөх зорилгоор Чөлөөт худалдааны бүс, эсхүл цахим худалдаа эрхлэгчдийн цахим худалдааны үйл ажиллагаанд зориулсан агуулахад хийгдэх гаалийн бүрдүүлэлтийн үйл явцыг оновчтой болгох, хялбарчлахыг эрмэлзэнэ.
4. Талууд нь цахим худалдаанд шаардлагагүй зохицуулалтын дарамтаас зайлсхийх нь ач холбогдолтой болохыг хүлээн зөвшөөрч байна.
5. Талуудын хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол цахим гарын үсэг нь цахим бус гарын үсэгтэй адил хууль ёсны бөгөөд хүчин төгөлдөр үйлчлэхийг Талууд үгүйсгэхгүй. Энэхүү заалтыг илүү тодорхой болгох үүднээс, энэ заалтад дурдсан цахим гарын үсэг нь аль нэг Талын хууль болон журмаар тогтоосон хууль зүйн шаардлагад нийцсэн байна.



6. Талууд холбогдох тохиолдолд цахим гарын үсгийг харилцан хүлээн зөвшөөрөхийг эрмэлзэнэ.
7. Тал тус бүр нь Талуудын хоорондын худалдаанд холбогдох баримт бичгүүдийг цахим хэлбэрээр нийтэд нээлттэй болгохыг эрмэлзэнэ.
8. Талууд цахим худалдааны хэрэглэгчдийн хувийн мэдээллийг хамгаалах нь эдийн засаг, нийгэмд үзүүлэх үр өгөөж болон цахим худалдаанд итгэх хэрэглэгчдийн итгэлийг нэмэгдүүлэхэд оруулах хувь нэмрийг хүлээн зөвшөөрч байна.
9. Талууд дотоодын хууль тогтоомж, дүрэм журмын дагуу хувийн мэдээллийг хамгаалах, түүний дотор хувийн мэдээллийг хил дамнуулан дамжуулах болон хувийн мэдээллийг хил дамнуулан дамжуулахтай холбогдох нөхцөл, шаардлагыг хангах арга хэмжээг баталж, хэрэгжүүлнэ.
10. Тал тус бүр энэхүү зүйлийн хэрэгжилтээс үүдэх аливаа асуудлаар нөгөө Тал болон Хамтарсан хороотой харилцах харилцааг хариуцах холбоо барих этгээдийг томилно.
11. Талуудын хоорондын харилцан ойлголцлыг дэмжих, эсхүл энэхүү бүлгээс үүссэн тодорхой асуудлыг шийдвэрлэх зорилгоор Хэлэлцээрийн аль нэг Тал энэхүү Хэлэлцээрийн 27 дугаар зүйл (Холбоо барих этгээд)-д заасны дагуу томилогдсон холбоо барих этгээдээр дамжуулан нөгөө Талтай зөвлөлдөх хүсэлт гаргаж болно.
12. Хэлэлцээрийн Талууд ийнхүү зөвлөлдөхөөр харилцан тохиролцсон тохиолдолд зөвлөлдөөнийг Талуудын харилцан тохиролцсон аливаа хэлбэрээр явуулж болно.

24 дүгээр зүйл

Эдийн засгийн хамтын ажиллагаа

1. Талуудын хөгжил болон чадавхын харилцан адилгүй түвшнийг харгалзан эдийн засгийн хамтын ажиллагааны ач холбогдлыг хүлээн зөвшөөрч, Талуудын харилцан ашигтай салбарт хамтын ажиллагааг өргөжүүлэхээр тохиролцсон болно.
2. Талууд эдийн засгийн хамтын ажиллагааг дэмжих, хэрэгжүүлэхдээ тус тусын Засгийн газрын байгууллагуудын хоорондын хамтын ажиллагааг болон



шаардлагатай буюу зохистой тохиолдолд Талуудын аж ахуйн нэгжүүдийн хамтын ажиллагааг дэмжиж, хөнгөвчилнө.

25 дугаар зүйл
Хавсралтууд

Энэхүү Хэлэлцээрийн Хавсралтууд нь энэхүү Хэлэлцээрийн салшгүй хэсэг болно.

26 дугаар зүйл
Хамтарсан хороо

1. Талууд нь Хэлэлцээрийн Тал бүрийн төлөөлөгчдөөс бүрдсэн Хамтарсан хороог байгуулах ба тус хороог хоёр төлөөлөгч хамтран даргалах ба нэг төлөөлөгч нь ЕАЭЗХ болон түүний гишүүн орнуудыг төлөөлж Евразийн Эдийн Засгийн Комиссын Удирдах зөвлөлийн гишүүн, нөгөө төлөөлөгч нь Монгол Улсын Эдийн засаг, хөгжлийн яам ба/эсхүл түүнийг залгамжлагч этгээд байна. Энэхүү зорилгоор зохих ёсоор эрх олгогдсон өндөр албан тушаалтнууд Талуудыг төлөөлнө.
2. Талууд Хамтарсан хорооны хуралдаан болохоос 30 (гуч)-аас ихгүй хоногийн өмнө Хамтарсан хороонд томилсон тус тусын төлөөлөгчийн талаар харилцан мэдэгдэнэ.
3. Хамтарсан хороо нь дараах чиг үүрэгтэй байна:
 - (a) энэхүү Хэлэлцээрийн хэрэгжилт, үйл ажиллагаатай холбоотой бүх асуудалд хяналт тавих, шалгах;
 - (b) Талуудын хоорондын худалдааны харилцааг цаашид хөгжүүлэх боломжийг судлах;
 - (c) энэхүү Хэлэлцээрт оруулах нэмэлт, өөрчлөлтийг судалж, Талуудад хэлэлцүүлэхээр хүргүүлэх; мөн
 - (d) энэхүү Хэлэлцээрийн хамрах хүрээ, зорилгын хүрээнд Талуудаас тус Хамтарсан хороонд даалгасан Хэлэлцээрт хамаарах аливаа асуудалтай холбоотой бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх.
4. Хамтарсан хороо нь чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд байнгын, эсхүл түр дэд хороо, эсхүл ажлын хэсэг байгуулж, тодорхой асуудлаар үүрэг, чиглэл өгч ажиллуулж болно.
5. Хамтарсан хорооны бүх шийдвэр болон зөвлөмжийг Талуудын зөвшилцлөөр батална.



6. Талууд өөрөөр тохиролцоогүй бол Хамтарсан хорооны хуралдааныг дор хаяж жил тутам тухай бүр Талуудад ээлжлэн хуралдуулна.
7. Гэрээний аль нэг Талын хүсэлтээр ээлжит бус хуралдаан зохион байгуулж болно. Талууд өөрөөр тохиролцоогүй бол энэхүү хуралдааныг хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш аль болох 30 (гуч) хоногийн дотор Хүсэлт гаргагч Талын нутаг дэвсгэрт зохион байгуулна.
8. Талууд Хамтарсан хорооны үйл ажиллагааны дүрмийг нэгтгэн боловсруулж, Хамтарсан хорооны анхны хуралдаанаар батална.

27 дугаар зүйл
Холбоо барих этгээд

1. Энэхүү Хэлэлцээрийн үр дүнтэй хэрэгжилтийг хангах болон энэхүү Хэлэлцээрт хамаарах аливаа асуудлаар Талуудын хоорондын харилцаа холбоог дэмжихийн тулд Тал тус бүр энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 1 (нэг) сарын дотор холбоо барих этгээд эсхүл холбоо барих этгээдүүдийг томилж, нөгөө Талд мэдэгдэнэ. Талууд харилцах этгээдийн тухай дэлгэрэнгүй мэдээлэлд оруулсан аливаа өөрчлөлтийг нөгөө Талдаа даруй мэдэгдэнэ.
2. Талуудын холбоо барих этгээд нь дор дурдсан үүрэгтэй байна:
 - (a) нөгөө Талаас гаргасан санал эсхүл хүсэлтийг хүлээн авах;
 - (b) энэхүү хэсгийн (a) заалтад дурдсан санал, хүсэлтэд хариу өгөх бөгөөд шаардлагатай тохиолдолд тухайн Талын холбогдох бусад эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллана.
3. Энэхүү зүйлийн 1 болон 2 дугаар хэсэг нь Талуудын бизнесийн салбаруудаас нөгөө Талын холбогдох эрх бүхий байгууллагатай шууд холбоо барихыг хориглох буюу хязгаарлахгүй.
4. Нэг Талын хүсэлтээр нөгөө Талын холбоо барих этгээд эсхүл холбоо барих этгээдүүд нь Талуудын хоорондын худалдаанд нөлөөлж болзошгүй асуудлыг хариуцаж буй албан байгууллага эсхүл албан тушаалтныг тодорхойлон, харилцаа холбоо явуулахад шаардагдах дэмжлэгийг үзүүлнэ.



28 дугаар зүйл
Хэлэлцээрийн хүчинтэй хугацаа, Хэлэлцээрээс гарах болон цуцлах

1. Энэхүү Хэлэлцээр нь 3 (гурван) жилийн хугацаанд хүчинтэй байх бөгөөд Талууд өөрөөр тохиролцоогүй бол Хэлэлцээрийг дахин 3 (гурван) жилийн хугацаагаар сунгасанд тооцно.
2. Энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн эхний гурван жилийн хугацаа дууссанаас хойш нэг жилийн дотор Талуудын хоорондын худалдааны ихэнх хэсэгт хамаарах татварыг болон худалдааны бусад хязгаарлалтыг арилгах, худалдааг хөнгөвчлөх зорилгоор энэхүү Хэлэлцээрийг хянан үзнэ.
3. Тал тус бүр энэхүү Хэлэлцээрийг цуцлах тухай мэдэгдлийг нөгөө Талдаа мэдэгдэж энэхүү Хэлэлцээрийг цуцалж болно. Энэхүү мэдэгдлийг хүлээн авагч Тал хүлээн авсан сараас хойш 13 дахь сарын эхний өдрөөс энэхүү Хэлэлцээр хүчингүй болно.
4. Энэхүү Хэлэлцээр нь ЕАЭЗХ-ны Хэлэлцээрээс гарсан ЕАЭЗХ-ны гишүүн аливаа орны хувьд ЕАЭЗХ-ны Хэлэлцээрээс гарсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр бус болно. Евразийн эдийн засгийн комисс нь ийнхүү ЕАЭЗХ-ны Хэлэлцээрээс гарах тухай асуудал хүчин төгөлдөр үйлчилж эхлэх өдрөөс 6 (зургаан) сарын өмнө Монгол Улсад мэдэгдэх үүрэгтэй. Талууд ЕАЭЗХ-ны Хэлэлцээрээс гарсан асуудал энэхүү Хэлэлцээрт хэрхэн нөлөөлөх асуудлыг хэлэлцэх зорилгоор зөвлөлдөнө.

29 дүгээр зүйл
Нэмэлт өөрчлөлт

1. Талууд бичгээр тохиролцсоны дагуу энэхүү Хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
2. Энэхүү Хэлэлцээрийн нэмэлт, өөрчлөлтүүд нь энэхүү Хэлэлцээрийн салшгүй хэсэг байна. Мөн энэхүү Хэлэлцээрийн нэмэлт, өөрчлөлтийг тусад нь протокол хэлбэрээр үйлдэж, энэхүү Хэлэлцээрийн 31 дүгээр зүйлд заасны дагуу хүчин төгөлдөр болно.
3. Хэрэв энэхүү Хэлэлцээрт тусгагдсан ДХБ-ын хэлэлцээр эсхүл Талуудын нэгдэн орсон бусад хэлэлцээрийн аль нэг заалтад өөрчлөлт орсон бол Талууд энэхүү Хэлэлцээрт холбогдох өөрчлөлт оруулах эсэх талаар зөвлөлдөнө.



30 дугаар зүйл
ЕАЭЗХ-нд шинээр гишүүн улс элсэх

1. ЕАЭЗХ-нд шинээр элссэн гишүүн улс нь Талуудын харилцан зөвшөөрсний дагуу энэхүү Хэлэлцээрт нэгдэн орно. Энэхүү Хэлэлцээрт нэгдэн орсныг нэмэлт протоколоор баталгаажуулна.
2. ЕАЭЗХ нь аливаа гуравдагч улсад ЕАЭЗХ-д элсэх нэр дэвшигч улсын статус олгосон, түүнчлэн ЕАЭЗХ-д элссэн талаар Монгол Улсад нэн даруй бичгээр мэдэгдэнэ.

31 дүгээр зүйл
Хүчин төгөлдөр болох

Энэхүү Хэлэлцээр нь ЕАЭЗХ, ЕАЭЗХ-ны гишүүн болон Монгол Улс энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болоход шаардлагатай дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг биелүүлсэн тухай эцсийн мэдэгдлийг бичгээр хүлээн авснаас хойш жар (60) хоногийн дараа хүчин төгөлдөр болно. Тус мэдэгдлийг Евразийн Эдийн Засгийн Комисс болон Монгол Улс дипломат шугамаар солилцоно.

Дээрхийг нотолж, Талуудын зохих ёсоор эрх олгогдсон төлөөлөгчид энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурав.


Энэхүү Хэлэлцээрийг Минск хотноо 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдөр англи хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд эдгээр эх бичвэр адил хүчинтэй.

Бүгд Найрамдах Армен Улсыг
төлөөлж

Монгол Улсыг төлөөлж

Бүгд Найрамдах Беларусь Улсыг
төлөөлж

Бүгд Найрамдах Казахстан Улсыг
төлөөлж



Бүгд Найрамдах Киргиз Улсыг
төлөөлж

Оросын Холбооны Улсыг
төлөөлж




ХАВСРАЛТ 1
ЕВРАЗИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХОЛБООНЫ ТАРИФЫН ЖАГСААЛТ

Энэхүү Хавсралтын зорилгоор “БТКУС-ийн код”, “Барааны бичиглэл” нь Евразийн эдийн засгийн холбооны хувьд 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр үйлчилж буй Уялдуулсан системийн жагсаалтыг үндэслэсэн болно.

Энэ Хавсралтад заасан зохих гарал үүсэлтэй бараанд аль нэг Тал ногдуулсан гаалийн татварын хувь хэмжээ Талууд тохиролцон энэ Хавсралтын 4 дүгээр баганад заасан холбогдох хувь хэмжээнээс ихгүй байна.


No.	УС-ийн код	Барааны бичиглэл	Хөнгөлөлттэй тарифын хувь хэмжээ
1	2	3	4
1	0201 20	- Ястай нь хэсэглэсэн бусад мах:	0%
2	0201 30	- Ясгүй:	0%
3	0202 20	- Ястай нь хэсэглэсэн бусад мах:	0%
4	0202 30	- Ясгүй:	0%
5	0204 10	- Хурганы шинэ эсвэл хөргөсөн гулууз болон өрөөл	0%
6	0204 21	-- Гулууз болон өрөөл	0%
7	0204 22	-- Ястай бусад хэсэг	0%
8	0204 23	-- Ясгүй	0%
9	0204 41	-- Гулууз болон өрөөл	0%
10	0204 42	-- Ястай бусад хэсэг	0%
11	0204 50	- Ямааны мах	0%
12	0205 00	Адуу, илжиг, луус эсвэл хөдий луусын шинэ, хөргөсөн эсвэл хөлдүү мах.	0%
13	0206 10	- Үхрийн шинэ эсвэл хөргөсөн	0%
14	0206 21	-- Хэл	0%
15	0206 29	-- Бусад	0%
16	0206 41	-- Элэг	0%
17	0206 80	- Шинэ эсвэл хөргөсөн бусад	0%
18	0206 90	- Хөлдүү, бусад	0%
19	0208 90	- Бусад:	0%
20	0210 11	-- Гуя, хаа болон тэдгээрийн ястай хэсэглэсэн мах	0%




21	0210 12	-- Өвчүү болон тэдгээрийн хэсэг	0%
22	0210 20	- үхрийн мах	0%
23	0210 99	-- Бусад	0%
24	0403 90	- Бусад:	0%
25	0405 90	- Бусад	0%
26	0406 90	- Бусад бяслаг	Үндэсний нэн тааламжтай нөхцөлөөс 50% бууруулах
27	0409 00	Зөгийн цэвэр бал.	0%
28	0410 90	-- Бусад	0%
29	0504 00	Мал амьтны (загаснаас бусад) шинэ, хөргөсөн, хөлдөөсөн, давсалсан, давсны уусмалд хадгалсан, хатаасан, утсан бүтэн эсвэл хэсэглэсэн өлөн гэдэс, давсаг, гузээ.	0%
30	0505 90	- Бусад	0%
31	0506 10	- Оссеин болон хүчлээр боловсруулсан яс	0%
32	0506 90	- Бусад:	0%
33	0507 90	- Бусад:	0%
34	0510 00	Цайвар бойшил, минж, мануул болон хүдрийн заар; цох; хатаасан эсвэл хатаагаагүй цөс; эмийн үйлдвэрлэлд хэрэглэгддэг шинэ, хөргөсөн, хөлдүү эсвэл бусад байдлаар түр хадгалсан булчирхай болон амьтны гаралтай бусад бүтээгдэхүүн.	0%
35	0511 99	-- Бусад:	0%
36	0704 90	- Бусад:	0%
37	0710 10	- Төмс	0%
38	0710 80	- Бусад ногоо	0%
39	0712 39	-- Бусад	0%
40	0712 90	- Бусад ногоо; холимог ногоо	0%
41	0810 90	- Бусад	0%
42	0811 90	- Бусад	0%
43	1003 90	- Бусад:	0%
44	1502 10	- Өөхөн тос	0%
45	1502 90	- Бусад	0%



46	1506 00	Мал, амьтны гаралтай, цэвэршүүлсэн эсвэл цэвэршүүлээгүй, гэхдээ химийн хувиргалт хийгээгүй бусад өөх, тос, түүний фракц.	0%
47	1514 19	-- Бусад	0%
48	1514 91	-- Боловсруулаагүй эх тос	0%
49	1515 90	- Бусад	0%
50	1516 10	- Мал амьтны өөх, тос, эдгээрийн фракц	0%
51	1601 00	Мах, дайвар мах эсвэл цус эсвэл шавжаар хийсэн хиам болон түүнтэй төстэй бүтээгдэхүүн; тэдгээрээр хийсэн хүнсний бэлдмэл.	0%
52	1602 10	- Нэгэн төрлийн болгосон бэлдмэл	0%
53	1602 20	- Амьтны элгээр хийсэн бүтээгдэхүүн	0%
54	1602 50	- Үхрийн махан	0%
55	1602 90	- Бусад (аливаа амьтны цусаар хийсэн бэлдмэл орно)	0%
56	1604 19	-- Бусад	0%
57	1704 90	- Бусад:	0%
58	1806 90	- Бусад	0%
59	1902 11	-- Өндөгний найрлагатай	0%
60	1902 19	-- Бусад	0%
61	1902 30	- Бусад тоймлогчийн зүйлс	0%
62	2007 10	- Нэгэн төрлийн болгосон бэлдмэл	0%
63	2007 91	-- Жүржийн төрлийн жимсний	0%
64	2007 99	-- Бусад	0%
65	2009 71	-- Бриксийн утга нь 20-иос ихгүй байх	0%
66	2009 89	-- Бусад	0%
67	2009 90	- Холимог шүүс	0%
68	2104 10	- Шөлтэй бэлэн хоол эсвэл тунгалаг шөл, тэдгээрийг хийх бэлдмэл	0%
69	2106 10	- Уурагт концентрат болон хэлбэржүүлсэн уурагт бодис	0%
70	2106 90	- Бусад:	0%



71	2202 10	- Саахар эсвэл амт, үнэр оруулагч бусад бодисын хольцтой ус, байгалийн эсвэл хиймэл рашаан, хийжүүлсэн ус	0%
72	2202 99	-- Бусад	0%
73	2203 00	Амуугаар исгэсэн шар айраг	Үндэсний нэн тааламжтай нөхцөлөөс 25% бууруулах
74	2208 20	- Усан үзмийн дарс эсвэл усан үзмийн шахдасыг нэрж гаргаж авсан архины зүйлс:	0%
75	2208 30	- Виски:	0%
76	2208 60	- Цагаан архи:	Үндэсний нэн тааламжтай нөхцөлөөс 25% бууруулах
77	2208 90	- Бусад:	0%
78	2301 10	- Мах эсвэл дайвар махны гурил, буталмал болон хорголж; шахдас	0%
79	2302 30	- Улаанбуудайн	0%
80	2309 10	- Муур, нохойны жижиглэн худалдаалахаар савласан хоол	0%
81	2309 90	- Бусад	0%
82	2501 00	Тоосжилтыг дарах, бөөгнөрөлтөөс хамгаалах бодис нэмсэн эсвэл нэмээгүй, усанд уусгасан эсвэл уусгаагүй давс (хүнсний болон хүнсний биш), цэвэр хлорт натри; далайн шорвог ус.	0%
83	2529 21	-- Жингийн 97% буюу түүнээс бага хэсэгт фторт кальци агуулсан:	0%
84	2529 22	-- Жингийн 97%-иас их фторт кальци агуулсан:	0%
85	2603 00	Зэсийн хүдэр болон баяжмал.	0%
86	2609 00	Цагаан тугалганы хүдэр болон баяжмал.	0%
87	2611 00	Гянт болдын хүдэр болон баяжмал.	0%
88	2613 90	- Бусад:	0%



	3101 00	Химийн боловсруулалт хийгдсэн эсвэл хийгдээгүй, хольсон буюу холиогүй, ургамал, мал амьтны гаралтай бордоо; ургамал, мал амьтны гаралтай бүтээгдэхүүнийг холих, химийн боловсруулалт хийх аргаар гаргаж авсан бордоо.	0%
89			
90	3304 10	- Уруулын гоо сайхны бэлдмэл	0%
91	3304 30	- Гар, хөлийн хумс заслын бэлдмэл	0%
92	3304 99	-- Бусад	0%
93	3305 10	- Шампунь	0%
94	3305 90	- Бусад	0%
95	3306 10	- Шүд цэвэрлэгээний бэлдмэл	0%
96	3401 20	- Бусад хэлбэрийн саван	0%
97	3402 50	- Жижиглэн худалдаалах зориулалтаар савласан бэлдмэл:	0%
	3503 00	Гадаргуугийн боловсруулалт хийсэн эсвэл хийгээгүй, өнгө будаг оруулсан буюу оруулаагүй, тэгш өнцөгт (квадрат орно) хуудас хэлбэрийн желатин болон желатины уламжлал; загасны цавуу; Зүйл 35.01-д заасан ээдэмцрийн цавуунаас бусад мал амьтны гаралтай бусад цавуу.	0%
98			
99	3926 90	- Бусад	0%
	4101 20	- Үхрийн эсвэл адууны, ширхэг нь энгийн хатаасан байдлаар 8 кг-аас, давсалж-хатаасан байдлаар 10 кг-аас, шинэ, давсалсан-нойтон эсвэл бусад аргаар чанарын хамгаалалт хийсэн байдлаар 16 кг-аас ихгүй жинтэй, бүтэн, хавтгайгаар зүсээгүй арьс, шир:	0%
100			
101	4101 50	- 16 кг-аас дээш жинтэй бүтэн шир:	0%
102	4101 90	- Бусад (түүнчлэн сүүл, зоо болон хэвлийн хэсгийн арьс орно):	0%
103	4102 10	- Үс ноостой арьс:	0%
104	4102 21	-- Гандсан	0%
105	4102 29	-- Бусад	0%
106	4103 90	- Бусад:	0%
107	4104 11	-- Бүтэн, хавтгайгаар зүсээгүй; өнгөн хуулдас:	0%
108	4104 19	-- Бусад:	0%

Монгол Улсын Гадаад харилцааны яам
АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН

Гарын үсэг /Signature/ 

2025 оны 07 сарын 09 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION

109	4104 41	-- Бүтэн, хавтгайгаар зүсээгүй; өнгөн хуулдас:	0%
110	4104 49	-- Бусад:	0%
111	4105 10	- Нойтон байдалтай (хром идээлэг хийсэн арьс орно)	0%
112	4105 30	- Хуурай байдалтай (идээлж- хатаасан)	0%
113	4106 21	-- Нойтон байдалтай (хром идээлэг хийсэн арьс орно)	0%
114	4106 22	-- Хуурай байдалтай (идээлж- хатаасан)	0%
115	4106 91	-- Нойтон байдалтай (хром идээлэг хийсэн арьс шир орно)	0%
116	4107 11	-- Бүтэн, хавтгайгаар зүсээгүй:	0%
117	4107 12	-- Өнгөн хуулдас:	0%
118	4107 99	-- Бусад:	0%
119	4112 00	Хонь эсвэл хурганы арьсыг идээлэх буюу идээлж-хатаах боловсруулалт хийсний дараахь цаашдын боловсруулалт хийсэн (элдэж-зөөлрүүлсэн савхи орно), үс ноосгүй, хавтгайгаар зүссэн (хуулдас) эсвэл зүсээгүй (бүтэн), Зүйл 41.14-т зааснаас бусад савхи.	0%
120	4113 10	- Ямаа эсвэл ишигний	0%
121	4114 10	- Илгэн савхи (хиймэл илгэн савхи орно):	0%
122	4201 00	Мал, амьтны зориулалттай бүх төрлийн материалаар хийсэн эмээлийн хэрэгсэл болон тоног хэрэгсэл (жолоо, цулбуур, олонцог, хошуувч, тохом, богц, нэмнээ болон тэдгээртэй төстэй зүйлс).	0%
123	4202 11	-- Гадна тал нь савхин эсвэл хиймэл савхин	0%
124	4202 12	-- Гадна тал нь хуванцар эсвэл нэхмэл материалаар хийгдсэн	0%
125	4202 19	-- Бусад	0%
126	4202 21	-- Гадна тал нь савхин эсвэл хиймэл савхин	0%
127	4202 22	-- Гадна тал нь хуванцар хуудсан эсвэл нэхмэлийн материалан	0%
128	4202 29	-- Бусад	0%

Монгол Улсын Гадаад харилцааны яам
АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН

Гарын үсэг /Signature/ 

2025 оны 07 сарын 09 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION

129	4202 31	-- Гадна тал нь савхин эсвэл хиймэл савхин	0%
130	4202 32	-- Гадна тал нь хуванцар хуудсан эсвэл нэхмэлийн материалаар хийгдсэн	0%
131	4202 39	-- Бусад	0%
132	4202 91	-- Гадна тал нь савхин эсвэл хиймэл савхин	0%
133	4202 92	-- Гадна тал нь хуванцар хуудсан эсвэл нэхмэлийн материалан	0%
134	4202 99	-- Бусад	0%
135	4203 10	- Хувцас:	0%
136	4203 21	-- Биеийн тамирын зориулалтаар тусгайлан хийсэн	0%
137	4203 29	-- Бусад	0%
138	4203 30	- Бүс, тэлээ, дайз	0%
139	4203 40	- Хувцасны бусад тоног, хэрэглэл	0%
140	4205 00	Савхи, шир эсвэл хиймэл савхи, ширэн бусад зүйлс.	0%
141	4301 80	- Бусад үслэг бүтэн арьс, толгой, сүүл, савартай эсвэл үгүй:	0%
142	4301 90	- Үслэг эдлэлийн зорилгоор ашиглаж болох толгой, сүүл, савар болон бусад хэсэг болон зүссэн хэсгүүд	0%
143	4302 19	-- Бусад:	0%
144	4302 20	- Толгой, сүүл, савар болон бусад хэсгүүд эсвэл огтолсон зүйлс, эгнээгүй	0%
145	4303 10	- Хувцасны зүйлс болон хувцасны тоноглол:	0%
146	4303 90	- Бусад	0%
147	5101 11	-- Хяргасан ноос	0%
148	5101 21	-- Хяргасан ноос	0%
149	5101 29	-- Бусад	0%
150	5102 11	-- Кашмир ноолуурын чиглэлийн ямааны:	0%
151	5102 19	-- Бусад:	0%
152	5102 20	- Мал, амьтны бүдүүн үс, ноос, хялгас:	0%
153	5103 10	- Хонины ноос буюу мал, амьтны нарийн үс, ноосны самнуурын сав	0%



154	5103 20	- Хонины бусад хаягдал ноос буюу мал, амьтны нарийн үс, ноосны бусад хаягдал:	0%
155	5105 10	- Бүдүүн зүүний самнах боловсруулалт хийсэн хонины ноос	0%
156	5105 21	-- Нарийн зүүний самнах боловсруулалт хийсэн тайрмал ноос	0%
157	5105 29	-- Бусад:	0%
158	5105 31	-- Кашмир ноолуурын чиглэлийн ямааны:	0%
159	5105 39	-- Бусад:	0%
160	5105 40	- Бүдүүн эсвэл нарийн зүүний самнах боловсруулалт хийсэн мал, амьтны бүдүүн үс, ноос, хялгас	0%
161	5106 10	- Жингийн 85% буюу түүнээс их ноос агуулсан	0%
162	5106 20	- Жингийн 85%-иас бага хэсэгт ноос агуулсан	0%
163	5107 10	- Жингийн 85% буюу түүнээс их ноос агуулсан	0%
164	5107 20	- Жингийн 85%-иас бага ноос агуулсан	0%
165	5108 10	- Бүдүүн зүүний самнах боловсруулалт хийсэн	0%
166	5108 20	- Нарийн зүүний самнах боловсруулалт хийсэн	0%
167	5109 10	- Жингийн 85% эсвэл түүнээс их хэсэгт хонины ноос эсвэл мал, амьтны нарийн үс, ноос агуулсан	0%
168	5109 90	- Бусад	0%
169	5110 00	Жижиглэн худалдаалах зориулалтаар савласан эсвэл савлаагүй, мал, амьтны бүдүүн үс, ноос, хялгасан ээрмэл эсвэл адууны хялгасан ээрмэл (ороож бүдүүрүүлсэн адууны хялгасан ээрмэл орно).	0%
170	5111 11	-- Жин нь 300 г/м ² -аас ихгүй	0%
171	5111 19	-- Бусад	0%
172	5111 90	- Бусад	0%
173	5112 11	-- 200 г/м ² -аас ихгүй жинтэй	0%
174	5112 19	-- Бусад	0%

Монгол Улсын Гадаад харилцааны яам
АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН

Гарын үсэг /Signature/ 

2025 оны 07 сарын 09 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION

175	5112 90	- Бусад	0%
176	5113 00	Мал, амьтны бүдүүн үс, ноос, хялгас, адууны хялгасаар нэхсэн даавуу.	0%
177	5503 20	- Полиэфирийн	0%
178	5601 21	-- Хөвөн	0%
179	5602 10	- Шивсэн эсгий, мяндсыг нь өөр хооронд нь хэрсэн бүтээгдэхүүн	0%
180	5602 21	-- Хонины ноос эсвэл мал, амьтны нарийн үс, ноосон	0%
181	5602 90	- Бусад	0%
182	5603 94	-- 150 г/м ² -аас их жинтэй	0%
183	5605 00	Металлжуулсан ээрмэл (нэхмэлийн ээрмэлийн зориулалтаар ороож бүдүүрүүлсэн эсвэл бүдүүрүүлээгүй), утас, тууз эсвэл нунтаг хэлбэрт байгаа металлтай хослуулсан, эсвэл металлаар бүрсэн Зүйл 54.04, 54.05-д заагдсан тууз, түүнтэй төстэй зүйлс.	0%
184	5607 41	-- Холбох, боох оосор	0%
185	5701 10	- Хонины ноос эсвэл мал, амьтны нарийн үс, ноосоор нэхсэн	0%
186	5702 41	-- Хонины ноос эсвэл мал, амьтны нарийн үс, ноосон	0%
187	5702 91	-- Хонины ноос эсвэл мал, амьтны нарийн үс, ноосон	0%
188	5703 10	- Хонины ноос эсвэл мал, амьтны нарийн үс, ноосон	0%
189	5703 29	Бусад	0%
190	5704 10	- Дөрвөлжин хэлбэртэй, хамгийн ихдээ 0.3 м ² талбайтай	0%
191	5704 90	- Бусад:	0%
192	5705 00	Гүйцэд боловсруулсан эсвэл гүйцэд боловсруулаагүй бусад хивс болон бусад нэхмэл дэвсгэр.	0%
193	5801 10	- Хонины ноос эсвэл мал, амьтны нарийн үс, ноосон	0%
194	5805 00	Гүйцэд боловсруулалт хийсэн эсвэл хийгээгүй, Gobelin, Flander, Aubusson, Beauvai болон тэдгээртэй төстэй төрлийн гар нэхмэл болон оёж, хатгасан гобелен /аравчны материал/	0%

Монгол Улсын Гадаад харилцааны яам
АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН

Гарын үсэг /Signature/

2025 оны 09 сарын 09 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION

		(жишээлбэл: шаглаа, тоонолжин оёдол)	
195	5905 00	Хана бүрэх нэхмэл материал.	0%
196	6006 10	- Хонины эсвэл мал, амьтны үс, ноосон	0%
197	6101 90	- Нэхмэлийн бусад материалан:	0%
198	6102 10	- Хонины ноос эсвэл мал, амьтны нарийн үс, ноосон:	0%
199	6102 20	- Хөвөн	0%
200	6103 29	-- Нэхмэлийн бусад материалан:	0%
201	6103 31	-- Хонины ноос эсвэл мал, амьтны нарийн үс, ноосон:	0%
202	6103 41	-- Хонины ноос эсвэл мал, амьтны нарийн үс, ноосон	0%
203	6103 42	-- Хөвөн	0%
204	6103 49	-- Нэхмэлийн бусад материалан	0%
205	6104 29	-- Нэхмэлийн бусад материалан:	0%
206	6104 31	-- Хонины ноос эсвэл мал, амьтны нарийн үс, ноосон:	0%
207	6104 32	-- Хөвөн	0%
208	6104 41	-- Хонины ноос буюу мал, амьтны нарийн үс, ноосон:	0%
209	6104 42	-- Хөвөн	0%
210	6104 43	-- Нийлэг мяндсан	0%
211	6104 51	-- Хонины ноос эсвэл мал, амьтны нарийн үс, ноосон:	0%
212	6104 59	-- Нэхмэлийн бусад материалан	0%
213	6104 61	-- Хонины ноос эсвэл мал, амьтны нарийн үс, ноосон:	0%
214	6104 62	-- Хөвөн	0%
215	6104 69	-- Нэхмэлийн бусад материалан	0%
216	6105 10	- Хөвөн	0%
217	6105 90	- Нэхмэлийн бусад материалан:	0%
218	6106 10	- Хөвөн	0%
219	6106 20	- Химийн мяндсан	0%
220	6106 90	- Нэхмэлийн бусад материалан:	0%
221	6107 99	-- Нэхмэлийн бусад материалан	0%
222	6108 99	-- Нэхмэлийн бусад материалан	0%
223	6109 10	- Хөвөн	0%
224	6109 90	- Нэхмэлийн бусад материалан:	0%

Монгол Улсын Гадаад харилцааны яам
АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН

Гарын үсэг /Signature/


25 07 09
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION

225	6110 11	-- Хонины ноосон	0%
226	6110 12	-- Кашмир ноолуурын чиглэлийн ямааны	0%
227	6110 19	-- Бусад	0%
228	6110 20	- Хөвөн	0%
229	6110 90	- Нэхмэлийн бусад материалан	0%
230	6111 20	- Хөвөн	0%
231	6111 90	- Нэхмэлийн бусад материалан:	0%
232	6112 19	-- Нэхмэлийн бусад материалан	0%
233	6113 00	Зүйл 59.03, 59.06 эсвэл 59.07-д заасан сүлжмэл материалаар хийсэн хувцас.	0%
234	6114 20	- Хөвөн	0%
235	6114 30	- Химийн мяндсан	0%
236	6114 90	- Нэхмэлийн бусад материалан:	0%
237	6115 29	-- Нэхмэлийн бусад материалан	0%
238	6115 94	-- Хонины ноос эсвэл мал, амьтны нарийн үс, ноосон:	0%
239	6115 95	-- Хөвөн	0%
240	6115 99	-- Нэхмэлийн бусад материалан	0%
241	6116 91	-- Хонины ноос эсвэл мал, амьтны нарийн үс, ноосон:	0%
242	6116 99	-- Нэхмэлийн бусад материалан	0%
243	6117 10	- Сүлжмэл шаль, ороолт, хүзүүний алчуур, толгойн алчуур, нүүрний тор (гивлүүр) болон бусад төстэй зүйлс:	0%
244	6117 80	- Бусад тоног хэрэглэл	0%
245	6117 90	- Эд анги	0%
246	6201 20	- Хонины ноосон эсвэл мал, амьтны нарийн үс, ноосон	0%
247	6201 30	- Хөвөн	0%
248	6201 90	- Нэхмэлийн бусад материалан	0%
249	6202 20	- Хонины ноосон эсвэл мал, амьтны нарийн үс, ноосон	0%
250	6202 30	- Хөвөн	0%
251	6202 90	-- Нэхмэлийн бусад материалан	0%
252	6203 11	-- Хонины ноосон эсвэл мал, амьтны нарийн үс, ноосон	0%
253	6203 19	-- Нэхмэлийн бусад материалан	0%
254	6203 31	-- Хонины ноосон эсвэл мал, амьтны нарийн үс, ноосон	0%
255	6203 32	-- Хөвөн	0%
256	6203 39	-- Нэхмэлийн бусад материалан	0%



257	6203 41	-- Хонины ноосон эсвэл мал, амьтны нарийн үс, ноосон	0%
258	6203 42	-- Хөвөн	0%
259	6203 43	-- Нийлэг мяндсан	0%
260	6203 49	-- Нэхмэлийн бусад материалан	0%
261	6204 11	-- Хонины ноосон эсвэл мал, амьтны нарийн үс, ноосон	0%
262	6204 19	-- Нэхмэлийн бусад материалан	0%
263	6204 22	-- Хөвөн даавуун	0%
264	6204 29	-- Нэхмэлийн бусад материалан	0%
265	6204 31	-- Хонины ноосон эсвэл мал, амьтны нарийн үс, ноосон	0%
266	6204 32	-- Хөвөн	0%
267	6204 39	-- Нэхмэлийн бусад материалан	0%
268	6204 41	-- Хонины ноосон эсвэл мал, амьтны нарийн үс, ноосон	0%
269	6204 42	-- Хөвөн	0%
270	6204 43	-- Нийлэг мяндсан	0%
271	6204 44	-- Хиймэл мяндсан	0%
272	6204 49	-- Нэхмэлийн бусад материалан	0%
273	6204 51	-- Хонины ноосон эсвэл мал, амьтны нарийн үс, ноосон	0%
274	6204 52	-- Хөвөн	0%
275	6204 59	-- Нэхмэлийн бусад материалан	0%
276	6204 61	-- Хонины ноосон эсвэл мал, амьтны нарийн үс, ноосон	0%
277	6204 62	-- Хөвөн	0%
278	6204 69	-- Нэхмэлийн бусад материалан	0%
279	6205 20	- Хөвөн	0%
280	6205 30	- Химийн мяндсан	0%
281	6205 90	- Нэхмэлийн бусад материалан	0%
282	6206 10	- Торгон эсвэл хаягдал торгон мяндсан	0%
283	6206 20	- Хонины ноосон эсвэл мал, амьтны нарийн үс, ноосон	0%
284	6206 30	- Хөвөн	0%
285	6206 40	- Химийн мяндсан	0%
286	6206 90	- Нэхмэлийн бусад материалан	0%
287	6207 11	-- Хөвөн	0%
288	6207 21	-- Хөвөн	0%
289	6207 99	-- Нэхмэлийн бусад материалан	0%
290	6208 21	-- Хөвөн	0%
291	6208 29	-- Нэхмэлийн бусад материалан	0%



292	6208 91	-- Хөвөн	0%
293	6208 99	-- Нэхмэлийн бусад материалан	0%
294	6210 10	- Зүйл 56.02 эсвэл 56.03-д заагдсан даавуугаар хийсэн	0%
295	6210 20	- Зүйл 62.01-д тодорхойлсон төрөл загварын оёмол бусад хувцас	0%
296	6210 30	- Зүйл 62.02-д тодорхойлсон төрөл загварын оёмол бусад хувцас	0%
297	6210 40	- Эрэгтэйчүүдийн эсвэл хөвгүүдийн бусад хувцас	0%
298	6210 50	- Эмэгтэйчүүдийн эсвэл охидын бусад хувцас	0%
299	6211 11	-- Эрэгтэйчүүдийн эсвэл хөвгүүдийн	0%
300	6211 12	-- Эмэгтэйчүүдийн эсвэл охидын	0%
301	6211 32	-- Хөвөн	0%
302	6211 39	-- Нэхмэлийн бусад материалан	0%
303	6211 42	-- Хөвөн	0%
304	6211 49	-- Нэхмэлийн бусад материалан	0%
305	6212 10	- Хөхний даруулга	0%
306	6212 20	- Бүс, бүс-агтавч	0%
307	6212 30	- Гэдэсний даруулга	0%
308	6214 10	- Торгон эсвэл хаягдал торгон мяндсан	0%
309	6214 20	- Хонины ноосон эсвэл мал, амьтны нарийн үс, ноосон	0%
310	6214 90	- Нэхмэлийн бусад материалан	0%
311	6215 90	- Нэхмэлийн бусад материалан	0%
312	6216 00	Таван хурууны, нэг хурууны эсвэл хуруу гаргаагүй оёмол бээлий.	0%
313	6217 10	- Тоног хэрэглэл	0%
314	6301 20	- Хонины ноосон эсвэл мал, амьтны нарийн үс, ноосон хөнжил (цахилгаанаар халдгаас бусад), аяны хөнжил:	0%
315	6301 90	- Бусад хөнжил ба аяны хөнжил	0%
316	6302 10	- Орны сүлжмэл даавуун цагаан хэрэглэл	0%
317	6302 21	-- Хөвөн	0%
318	6302 29	-- Нэхмэлийн бусад материалан	0%
319	6302 31	-- Хөвөн	0%
320	6302 39	-- Нэхмэлийн бусад материалан	0%



321	6302 51	-- Хөвөн	0%
322	6302 59	-- Нэхмэлийн бусад материалан	0%
323	6302 91	-- Хөвөн	0%
324	6302 99	-- Нэхмэлийн бусад материалан	0%
325	6303 12	-- Нийлэг мяндсан	0%
326	6303 19	-- Нэхмэлийн бусад материалан	0%
327	6303 99	-- Нэхмэлийн бусад материалан	0%
328	6304 11	-- Сүлжмэл	0%
329	6304 19	-- Бусад	0%
330	6304 91	-- Сүлжмэл	0%
331	6304 92	-- Хөвөн мяндсан, оёмол	0%
332	6304 99	-- Нэхмэлийн бусад материалан, оёмол	0%
333	6305 20	- Хөвөн	0%
334	6305 32	-- Дамжлагын бөөний савлагааны зориулалттай, их даацын уян шуудай	0%
335	6305 39	-- Бусад	0%
336	6305 90	- Нэхмэлийн бусад материалан	0%
337	6306 12	-- Нийлэг мяндсан	0%
338	6306 19	-- Нэхмэлийн бусад материалан	0%
339	6306 22	-- Нийлэг мяндсан	0%
340	6306 29	-- Нэхмэлийн бусад материалан	0%
341	6306 90	- Бусад	0%
342	6307 10	- Шал, сав суулга, тоос шорооны болон ижил төстэй цэвэрлэгээний алчуур	0%
343	6307 20	- Хамгаалалтын хантааз, бүслүүр	0%
344	6307 90	- Бусад	0%
345	6308 00	Жижиг хивс, аравчны материал, уран хатгамалт ширээний бүтээлэг, салфетка зэргийг хийхэд зориулсан нэхмэл материал, ээрмэл, бусад тоноглол хэрэгслийг оруулж бүрдүүлсэн эсвэл бүрдүүлээгүй жижиглэн худалдаалах зориулалтаар савласан иж бүрдэл	0%
346	6402 91	-- Богино түрийтэй (шагайнаас дээш)	0%
347	6402 99	-- Бусад	0%
348	6403 51	-- Богино түрийтэй (шагайнаас дээш)	0%



349	6403 59	-- Бусад	0%
350	6403 91	-- Богино түрийтэй (шагайнаас дээш)	0%
351	6403 99	-- Бусад	0%
352	6404 19	-- Бусад	0%
353	6404 20	- Жинхэнэ эсвэл хиймэл ширэн гадуур ултай гутал	0%
354	6405 10	- Жинхэнэ буюу хиймэл савхин түрийтэй	0%
355	6405 20	- Нэхмэл материалан түрийтэй	0%
356	6405 90	- Бусад:	0%
357	6406 90	- Бусад	0%
358	6501 00	Бүрх малгайн хэлбэр оруулаагүй, хүрээ гаргаагүй эсгий хэв, хэлбүүр болон орой; хавтгай болон бортого хэлбэрийн эсгий бэлдэц (туушид нь эсгэсэн бортого орно).	0%
359	6504 00	Янз бүрийн материалан туузыг сүлжиж эсвэл зүйж хийсэн, доторлосон буюу доторлоогүй, чимэглэсэн эсвэл чимэглээгүй бүрх малгай болон бусад малгай.	0%
360	6505 00	Сүлжмэл, торон нэхмэл, эсгий эсвэл бусад нэхмэл даавуу (гэхдээ туузаар биш)- гаар хийсэн, доторлосон эсвэл доторлоогүй, чимэглэсэн буюу чимэглээгүй бүрх малгай, бусад малгай; янз бүрийн материалаар хийсэн, доторлосон эсвэл доторлоогүй, чимэглэсэн буюу чимэглээгүй усний тор.	0%
361	6506 10	- Хамгаалалтын малгай	0%
362	6506 99	-- Бусад материалан:	0%
363	6704 19	-- Бусад	0%
364	7403 11	-- Катодын зэс болон түүний бүрдэл хэсэг	0%
365	9402 90	- Бусад	0%
366	9406 10	- Модон:	0%
367	9406 90	- Бусад:	0%



ХАВСРАЛТ 2 МОНГОЛ УЛСЫН ТАРИФЫН ЖАГСААЛТ

Энэхүү Хавсралтын зорилгоор “БТКУС-ийн код”, “Барааны бичиглэл” нь Монгол Улсын хувьд 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр үйлчилж буй Уялдуулсан системийн жагсаалтыг үндэслэсэн болно.

Энэ Хавсралтад заасан зохих гарал үүсэлтэй бараанд аль нэг Тал ногдуулсан гаалийн татварын хувь хэмжээ Талууд тохиролцон энэ Хавсралтын 4 дүгээр баганад заасан холбогдох хувь хэмжээнээс ихгүй байна.

No.	УС-ийн код	Барааны бичиглэл	Хөнгөлөлттэй тарифын хувь хэмжээ
1	2	3	4
1	0203 11	-- Гулууз болон өрөөл	0%
2	0203 21	-- Гулууз болон өрөөл	0%
3	0203 29	-- Бусад	0%
4	0207 14	-- Хөлдүү, хэсэглэсэн мах болон дайвар мах	0%
5	0402 10	- Жингийн 1.5%-аас ихгүй тослогтой нунтаг, үрлэн эсвэл хатуу байдалтай	1500 тонн хүртэл 0%
6	0402 21	-- Саахар болон бусад амтлагчийн хольцгүй	1500 тонн хүртэл 0%
7	0403 20	- Йогурт	0%
8	0403 90	- Бусад:	0%
9	0404 10	- Саахар эсвэл бусад чихэрлэг амтлагчийн хольцтой эсвэл хольцгүй, өтгөрүүлсэн эсвэл өтгөрүүлээгүй шар сүү, хувиргасан шар сүү	0%
10	0405 10	- Цөцгийн тос	Үндэсний нэн тааламжтай нөхцөлөөс 50% бууруулах
11	0406 10	- Шинэ (бүрэн боловсроогүй эсвэл хатаагаагүй) бяслаг, түүнчлэн шар сүүнээс гаргасан бяслаг болон аарц	Үндэсний нэн тааламжтай нөхцөлөөс 50% бууруулах



12	0406 30	- Хайлмал бяслаг (үүрмэг биш, нунтаглаагүй)	Үндэсний нэн тааламжтай нөхцөлөөс 50% бууруулах
13	0406 90	- Бусад бяслаг	Үндэсний нэн тааламжтай нөхцөлөөс 50% бууруулах
14	0407 21	-- Тахиа (Gallus domesticus)-ны	90 000 000 ширхэг хүртэл 7.5%
15	0409 00	Зөгийн цэвэр бал.	0%
16	0808 10	- Алим	0%
17	0810 10	- Гүзээлзгэнэ	0%
18	0810 20	-Бөөрөлзгөнө, ялам модны жимсгэнэ, бөөрөлзгөнийн төрлийн жимс	0%
19	0811 10	- Гүзээлзгэнэ	0%
20	0813 30	- Алим	0%
21	0813 40	- Бусад жимс	0%
22	0902 30	- 3 кг-аас ихгүй жингээр савласан байхуу цай (ферментжүүлсэн) болон хэсэгчлэн ферментжүүлсэн цай	0%
23	1001 91	-- Үрийн:	0%
24	1001 19	-- Бусад	50 000 тонн хүртэл 3.75%
25	1001 99	-- Бусад	
26	1003 90	- Бусад:	0%
27	1004 90	- Бусад:	0%
28	1005 90	- Бусад:	0%
29	1006 30	- Цагаан будаа, дотуур бүрхүүлийг хагас эсвэл гүйцэд хальсалсан, үрсэн эсвэл үрээгүй, өнгөлсөн эсвэл өнгөлөөгүй	0%
30	1104 29	-- Бусад үр тарианы:	0%
31	1107 10	- Хуураагүй	0%
32	1209 29	-- Бусад	0%
33	1507 10	- Тунгалагшуулсан эсвэл тунгалагшуулаагүй эх тос	0%
34	1507 90	- Бусад	0%
35	1512 11	-- Боловсруулаагүй эх тос	0%
36	1512 19	-- Бусад	0%



37	1517 10	- Маргарин (шингэн маргарин орохгүй)	0%
38	1517 90	- Бусад	0%
39	1602 50	- Үхрийн махан	0%
40	1701 99	- Бусад:	0%
41	1702 30	- Фруктоз агуулаагүй эсвэл хуурай төлөвт тооцсоноор жингийн 20%-иас бага хэсэгт фруктоз агуулсан глюкоз болон глюкозын өтгөн шүүс	0%
42	1704 90	- Бусад:	0%
43	1806 20	- 2 кг-аас их жинтэй хавтгай, хавтан, гулдмай хэлбэртэй, эсвэл 2 кг-аас дээш жингийн савлагаатай буюу анхан шатны баглаа боодолтой шингэн, зуурмаг, нунтаг, үрэл эсвэл бөөний савлагаатай бусад хэлбэрийн бэлдмэл	0%
44	1806 31	-- Чөмөгтэй	0%
45	1806 32	-- Чөмөггүй	0%
46	1806 90	- Бусад	0%
47	1901 10	- Жижиглэн худалдаалах зориулалтаар савласан, нярай болон бага насны хүүхдэд зориулсан хоол тэжээлийн бэлдмэл	0%
48	1901 20	- Зүйл 19.05-д заасан гурилан бүтээгдэхүүн хийхэд зориулагдсан хольц, зуурмаг	0%
49	1901 90	- Бусад	0%
50	1902 19	-- Бусад	0%
51	1902 20	- Чанасан эсвэл чанаагүй, эсвэл бусад аргаар бэлтгэсэн, хавчуургатай гоймонгийн зүйлс	0%
52	1902 30	- Бусад гоймонгийн зүйлс	0%
53	1904 10	- Үр тариа эсвэл үр тариан бүтээгдэхүүнийг хөөлгөх эсвэл хуурах аргаар бэлтгэсэн хүнсний бэлдмэл	0%
54	1904 20	- Үр тарианы хуураагүй нэвсээр, эсвэл үр тарианы хуурсан нэвсний холимгоор, хөөлгөсөн үр тариагаар бэлтгэсэн хүнсний бэлдмэл	0%
55	1905 31	-- Амтат жигнэмэг	0%




56	1905 32	-- Өрмөнцөр	0%
57	1905 90	- Бусад:	0%
58	2002 10	- Бүтэн эсвэл хэрчмэл улаан лооль	0%
59	2002 90	- Бусад	0%
60	2004 10	- Төмс	0%
61	2004 90	- Бусад ногоо болон ногооны холимог	0%
62	2006 00	Саахранд нөөжилсөн (нэвчүүлсэн, бүрсэн, түрхсэн) хүнсний ногоо, жимс, самар, жимсний хальс болон ургамлын бусад эд хэсэг.	0%
63	2007 10	- Нэгэн төрлийн болгосон бэлдмэл	0%
64	2007 99	-- Бусад	0%
65	2008 19	-- Бусад, түүнчлэн холимог	0%
66	2008 50	- Гүйлс	0%
67	2008 60	- Интоор	0%
68	2008 70	- Тоор (нектарин орно)	0%
69	2008 99	-- Бусад	0%
70	2009 50	- Улаан лоолийн шүүс	0%
71	2009 61	-- Бриксийн утга нь 30-аас ихгүй байх	0%
72	2009 71	-- Бриксийн утга нь 20-иос ихгүй байх	0%
73	2009 89	-- Бусад	0%
74	2009 90	- Холимог шүүс	0%
75	2103 90	- Бусад	0%
76	2105 00	Какао агуулсан эсвэл агуулаагүй зайрмаг, хүнсний зориулалтын бусад мөсөн бүтээгдэхүүн.	0%
77	2106 90	- Бусад:	0%
78	2201 10	- Рашаан болон хийжүүлсэн ус	0%
79	2202 10	- Саахар эсвэл амт, үнэр оруулагч бусад бодисын хольцтой ус, байгалийн эсвэл хиймэл рашаан, хийжүүлсэн ус	0%
80	2202 91	-- Согтууруулах бус шар айраг	0%
81	2202 99	-- Бусад	0%
82	2203 00	Амуугаар исгэсэн шар айраг	Үндэсний нэн тааламжтай нөхцөлөөс 25% бууруулах
83	2204 10	- Хөөсөрдөг дарс:	0%



84	2204 21	-- 2 л эсвэл түүнээс бага багтаамжийн савтай:	0%
85	2204 22	-- 2 л-ээс их боловч 10 л-ээс ихгүй багтаамжийн савтай:	0%
86	2204 29	-- Бусад:	0%
87	2204 30	- Усан үзмийн бусад шүүс /сусл/:	0%
88	2208 20	- Усан үзмийн дарс эсвэл усан үзмийн шахдасыг нэрж гаргаж авсан архины зүйлс:	0%
89	2208 60	- Цагаан архи:	Үндэсний нэн тааламжтай нөхцөлөөс 25% бууруулах
90	2302 30	- Улаанбуудайн	0%
91	2304 00	Шар буурцгийн тосыг ялгах явцад гарсан, нунтагласан эсвэл нунтаглаагүй, хорголжилсон эсвэл хорголжлоогүй шахдас болон бусад хатуу хаягдал:	0%
92	2402 20	- Тамхи агуулсан янжуур:	0%
93	2403 19	-- Бусад:	0%
94	2403 99	-- Бусад:	0%
95	2520 20	- Боловсруулсан гөлтгөнө (алебастр)	0%
96	2523 29	-- Бусад	0%
97	2710 12	-- Хөнгөн тос болон бэлдмэл:	0%
98	2710 19	-- Бусад:	0%
99	2804 29	-- Бусад	0%
2. In considering which benefits to suspend, the complaining Party should first seek to suspend concessions or other obligations granted under this Agreement in the same sector or sectors as that affected by the measure that the Arbitral Panel has found not to be in conformity with this Agreement. If the complaining Party considers that it is not practicable or effective to suspend concessions or other obligations granted under this Agreement in the same sector or sectors it may suspend concessions or other obligations granted under this Agreement in other sectors.

3. Within 15 (fifteen) days from the receipt of such notification, the Party complaint against may request the original Arbitral Panel to rule on whether the concessions or other benefits granted under this Agreement which the complaining Party intends to suspend are equivalent to those affected by the measure found not to be in conformity with this Agreement, and whether the proposed suspension is in accordance with paragraphs 1 and 2 of this Article. The ruling of the Arbitral Panel shall be given within 30 (thirty) days from the receipt

of such request and shall be accepted unconditionally by the Parties. Benefits shall not be suspended until the Arbitral Panel has issued its ruling.

4. The suspension of the concessions or other obligations granted under this Agreement shall be temporary and be applied by the complaining Party, only until:

- (a) any measure taken to comply which the final report of the Arbitral Panel has found to be inconsistent with the covered provisions has been withdrawn or amended so as to bring the Party complained against into conformity with those provisions;
- (b) the Arbitral Panel decides that the compliance measure is compatible with the award and with the provisions of this Agreement; or
- (c) the Parties have otherwise settled the dispute or reached mutually agreed solution.

5. Upon request of a disputing Party, the original Arbitral Panel shall rule on the conformity with its final report of any implementing measure adopted after the suspension of concessions or other obligations granted under this Agreement and, in light of such rulings, whether the suspension of benefits should be terminated or modified. The rulings of the Arbitral Panel shall be made within 30 (thirty) days from the date of the receipt of such request.

Article 18

General Provisions

All notifications, requests and replies made pursuant to this Annex shall be in writing.

Article 19

Mutually Agreed Solution

1. The disputing Parties may reach a mutually agreed solution at any time with respect to any dispute referred to in Article 3 of this Annex.

2. If a mutually agreed solution is reached during the Arbitral Panel or mediation procedure, the disputing Parties shall jointly notify that solution Chair of the Arbitral Panel or the mediator, respectively and the Joint Committee shall be informed on such notification. Upon such notification, the Arbitral Panel or the mediation procedure shall be terminated.

3. Each Party shall take measures necessary to implement the mutually agreed solution within the agreed time period.

4. No later than at the expiry of the agreed time period the implementing Party shall inform the other Party, in writing, of any measure that it has taken to implement the mutually agreed solution.

Article 20 **Time Limits**

All time limits laid down in this Annex, shall be counted in calendar days, from the day (when a notice, notification, communication or proposal is received) following the act or fact to which they refer unless otherwise specified. If the last day of such period is an official holiday or a non-work day in the Party of the addressee, the period is extended until the first work day which follows. Official holidays or non-work days occurring during the running of the period of time are included in calculating the period.

Any time limit referred to in this Annex may be modified by mutual agreement of the disputing Parties.

The Arbitral Panel may at any time propose to the disputing Parties to modify any time limit referred to in this Annex, stating the reasons for the proposal.

Article 21 **Remuneration and Expenses**

1. Unless the disputing Parties agree otherwise:

- (a) each disputing Party shall bear the costs of its appointed arbitrator, its own expenses and legal costs derived from the participation in the Arbitral Panel or mediation procedure; and
- (b) the costs of the Chair of the Arbitral Panel, the mediator and other expenses associated with the conduct of the Arbitral Panel proceedings shall be borne in equal parts by the disputing Parties.

2. Upon request of a disputing Party, the Arbitral Panel may decide on the expenses referred to in subparagraph (b) of paragraph 1 of this Article taking into account the particular circumstances of the case.

Article 22 **Language**

1. All proceedings pursuant to this Annex shall be conducted in the English language.

2. Any documents submitted for use in the proceedings pursuant to this Annex shall be in the English language. If any original document is not in the English language, the disputing Party submitting it shall provide an English language translation of such document.

**МОНГОЛ УЛС БОЛОН ЕВРАЗИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХОЛБОО, ТҮҮНИЙ ГИШҮҮН
ОРНУУД ХООРОНДЫН ХУДАЛДААНЫ ТҮР ХЭЛЭЛЦЭЭРИЙГ СОЁРХОН БАТЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ
ТАНДАН СУДАЛСАН СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ
2025 он**

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах ажлын зорилт: Тодорхой асуудлыг шийдвэрлэх зохицуулалтын хувилбарыг тодорхойлж, эерэг болон сөрөг талыг харьцуулан судалсны үндсэн дээр үр нөлөөг урьдчилан тооцож, уг асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй хувилбарыг хууль санаачлагчид санал болгоход оршино.

Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын урьдчилсан тандан судалгааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтын дагуу хийлээ.

ХОЁР. УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ АЖЛЫН ҮЕ ШАТ

Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын¹ /цаашид Аргачлал гэх/ 2.1-д заасан 7 үе шатаар тандан судлах үнэлгээг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Асуудалд дүн шинжилгээ хийх;
2. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг томъёолсон байдал;
3. Асуудлыг зохицуулах хувилбар, эерэг сөрөг талыг харьцуулах;
4. Хувилбаруудын үр нөлөөг тандах;
5. Хувилбаруудыг харьцуулсан дүгнэлт;
6. Олон улсын болон бусад улсын хууль эрх зүйн зохицуулалттай харьцуулсан байдал;
7. Зөвлөмж.

ГУРАВ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн Зорилт 4.4-т “Бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцид нэгдэж, худалдааг хөнгөвчилнө”, “Зорилтыг хэрэгжүүлэх I үе шат 2021-2030 онд Хөрш орнуудыг дамжсан эдийн засгийн коридорыг хөгжүүлэх, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Оросын Холбооны Улстай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулж, бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцид нэгдэх замаар эдийн засгийн гадаад харилцааг эрс нэмэгдүүлэх үе” гэж заасан.

Мөн Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.5.1-т “Цөөн зах зээл, цөөн нэр төрлийн бүтээгдэхүүний экспорт, импортоос хэт хамааралтай үндэсний эдийн засгийн эмзэг байдлыг бууруулна.”, 3.2.5.3-т “Нэг орноос худалдан авах бараа бүтээгдэхүүн нийт импортод хэт давамгайлахаас сэргийлэх бодлого баримтална”, 3.2.5.4-т “Бүс нутгийн болон олон улсын интеграцид нэгдэх, чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах асуудлыг эдийн засгийн аюулгүй байдал, хөгжлийн шаардлагыг харгалзан,

¹Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

судалгаа, тооцоонд тулгуурлан, шат дараатай, сонголттойгоор хэрэгжүүлнэ” гэж тус тус заасан.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.2.11-т “Бүгд Найрамдах Солонгос Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, Бүгд Найрамдах Хятад Ард Улстай эдийн засгийн түншлэл, чөлөөт худалдааны хэлэлцээрийг байгуулж, худалдааны түнш улс орнуудтай хамтран ажиллах эдийн засгийн чиглэлийг нарийвчлан тодорхойлж, хөрөнгө оруулалт, экспорт, бизнесийг дэмжсэн харилцааг хөгжүүлнэ” гэж тусгагдсан.

Монгол Улсын худалдааны салбар нь 2024 оны байдлаар ДНБ-ны 17.31 хувь, идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн 352 хувийг бүрдүүлж, 1,180,4743 үнийг ажлын байраар тогтвортой хангаж байна.

Монгол Улсад 1990 оноос 2024 оны III дугаар улирал хүртэл нийт 47.01 тэрбум ам.долларын гадаадын хөрөнгө оруулалт орж ирснээс 74 хувь нь уул уурхайн олборлолт, 10 хувь нь худалдаа, үйлчилгээний салбарт хийгдсэн бол бусад салбарууд нийлээд 16 хувийг эзэлж байгаа нь гадаадын хөрөнгө оруулалт төрөлжихгүй, зөвхөн нэг салбарт харьцангуй ихээр төвлөрч байгааг харуулж байна.

Манай Улс уул уурхайд түшиглэсэн эдийн засагтай, нэг салбараас хэтэрхий их хамааралтай байх нь эдийн засгийн эмзэг байдлыг нэмэгдүүлж байна. Иймд эдийн засгийг төрөлжүүлж бусад салбарыг хөгжүүлэх зайлшгүй шаардлагатай.

Монгол Улс хөрөнгө оруулалт, худалдааны чиглэлээр хийсэн олон улсын гэрээ, хэлэлцээрт оролцдог ч хөдөө аж ахуй, мал аж ахуйн салбарт үр дүнтэй хэрэгжиж чадаагүй, уул уурхайн салбарт хөрөнгө оруулалт татах, экспортлоход илүү төвлөрч байсан ч хөдөө аж ахуй, мал аж ахуйн салбарт хөрөнгө оруулалт татах дорвитой арга хэмжээ авч байгаагүй.

Манай Улсын хүн ам цөөн 3.5 сая орчим, дотоодын зах зээл хязгаарлагдмал, жижиг байдаг тул гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид хөдөө аж ахуй, мал аж ахуйн бүтээгдэхүүнийг дотоодод худалдах бус, харин өндөр үнэ хүрэх экспортын бүтээгдэхүүн болгон олон улсын зах зээлд гаргах замаар хөрөнгө оруулалт хийх сонирхолтой байдаг. Үүний улмаас олон улсын зах зээлд манай бүтээгдэхүүний үнэ цэнэ нэмэгдэхгүй, өрсөлдөх чадвар дээшлэхгүй байгаа нь гадаадын хөрөнгө оруулагчид энэ салбарыг сонирхохгүй байх шалтгаан болж байна.

Монгол Улсын өөрийн зах зээл харьцангуй жижиг боловч газар зүйн байршлын хувьд дэлхийн 2 том зах зээл болох БНХАУ, ОХУ-тай хөрш, мөн Япон, БНСУ зэрэг томоохон зах зээлүүдэд ойр гэдгээрээ стратегийн ач холбогдолтой гэж үздэг.

Төрийн зүгээс хувийн хэвшлийг гадаад зах зээл рүү худалдаа хийх бололцоог нээх, экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээг авах нь чухал. БНСУ-тай эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр, ЕАЭЗХ-той зарим нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг татвараас чөлөөлүүлэх тухай хэлэлцээрүүдийг амжилттай байгуулсан тохиолдолд хөрөнгө оруулагч нарыг татаж,

Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгжүүдийн орлого, экспортыг нэмэгдүүлж, эдийн засгийг төрөлжүүлэхэд томоохон түлхэц болно гэж харж байна.

Хөрөнгө оруулалт болон худалдаа нь хоорондоо салшгүй хамааралтай байдаг. Иймд гадаад худалдааны таатай орчныг бий болгож, Монгол Улсад үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг экспортлох зардлыг бууруулах замаар хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх боломжтой юм.

Монгол Улс нь зөвхөн Япон улстай эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг байгуулсан. Мөн Ази, номхон далайн худалдааны хэлэлцээр, Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх тухай ерөнхий хэлэлцээрийг соёрхон баталсан. Гэсэн хэдий ч олон улсын хэмжээнд чөлөөт худалдааны гэрээ байгуулсан орны үзүүлэлтээр Монгол Улс хамгийн цөөн гэрээ байгуулсан орны тоонд багтаж байна.

Монгол Улс нь далайд гарцгүй, хоёр том эдийн засагтай улсын дунд байрладаг, уул уурхайн бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэлд өртөмтгий, гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ бага, эмзэг бүтэцтэй эдийн засагтай улс юм. Ийм нөхцөлд бүс нутгийн эдийн засгийн интеграцид нэгдэх нь эдийн засгийн тогтвортой байдал, гадаад худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, экспортын чиг баримжаатай үйлдвэрлэлийг дэмжих стратегийн ач холбогдолтой.

Монгол Улсын нийт бараа эргэлтийн 77.2 хувийг БНХАУ, ОХУ эзэлж байгаагаас, нийт экспортын 80 гаруй хувийг БНХАУ-д экспортолж байна. Энэ нь экспортын зах зээлийн хэт төвлөрөл, эрсдэл дагуулсан хамаарлыг бий болгож байгаа тул экспортын зах зээлийг төрөлжүүлэх, шинэ зах зээлд нэвтрэх шаардлага зайлшгүй тулгарч байна.

ЕАЭЗХ нь нэгдсэн гаалийн нутаг дэвсгэртэй бөгөөд холбооны гишүүн орнууд (ОХУ, Беларусь, Казахстан, Армени, Киргизстан) нь гаалийн нэгдсэн нэг нутаг дэвсгэртэй ба бусад орнуудтай хийх худалдаанд гаалийн нэгдсэн нэг татвар болон зохицуулалтыг хэрэгжүүлдэг. Евразийн эдийн засгийн холбооноос хөдөө аж ахуй бүтээгдэхүүнд дунджаар 15-50%-ийн гаалийн татвар ногдуулдаг нь Монгол Улсын бүтээгдэхүүн ЕАЭЗХ-ны зах зээлд өрсөлдөх чадвар багатай, экспортыг сааруулж буй гол хүчин зүйл болж байна.

Монгол Улс ЕАЭЗХ, түүний гишүүн 5 улстай хийсэн гадаад худалдааны нийт бараа эргэлт 2023 онд 2.6 тэрбум ам.доллар, экспорт 143.0 сая ам.доллар, импорт 2.5 тэрбум ам.доллар байна. Гишүүн 5 улсын худалдааны 95.5 хувийг ОХУ, 2.9 хувийг Казакстан улс, 1.3 хувийг Беларусь улс, 0.3 хувийг Киргизстан улс, 0.03 хувийг Армени улс тус тус бүрдүүлж байна. Евразийн эдийн засгийн холбоо нь манай улсын нийт бараа эргэлтийн 10.7%, экспортын 0.9%, импортын 26.8%-г бүрдүүлж байгаа бөгөөд бараа эргэлтийн харьцаа 95:5 байна. Ийнхүү бараа эргэлтийн харьцаа 95:5 байгаа нь гадаад худалдааны тэнцэл эрс алдагдсаныг харуулж байна.

Монгол Улсаас ЕАЭЗХ-ны зах зээлд хийж буй экспортын хязгаарлагдмал байдал нь хөдөө аж ахуй болон боловсруулах салбарын бүтээгдэхүүнд ногдуулж буй өндөр гаалийн тариф болон тарифын бус саад тотгоруудтай шууд холбоотой юм. Ийнхүү зах зээлийн

нэвтрэх чадвар хязгаарлагдаж байгаа нь экспортын бодит өсөлтөд үндсэн хүндрэл, саад болж байна.

Монгол Улс ЕАЭЗХ-ны гишүүн орнуудтай худалдааны хэлэлцээр байгуулах замаар экспортыг төрөлжүүлэх, тарифын болон тарифын бус саад тотгорыг бууруулах, гадаад худалдааны тэнцлийг сайжруулах, улмаар бүс нутгийн эдийн засгийн интеграцид тэнцвэртэй, үр ашигтайгаар нэгдэх зайлшгүй шаардлагатай байна.

Дээр дурдсан хууль, эрх зүй, нийгэм, эдийн засгийн практик хэрэгцээ, шаардлагад тулгуурлан Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн хуулийн төслийг боловсруулах шаардлагатай байна.

3.1. Асуудлыг тодорхойлж шийдвэрлэх гэж байгаа тухайн асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоох:

Монгол Улс нь гадаад худалдааны тэнцлийг сайжруулах, экспортын бараа бүтээгдэхүүний нэр төрөл болон хэмжээг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, бүс нутгийн эдийн засгийн интеграцид идэвхтэй оролцох зорилгоор ЕАЭЗХ болон түүний гишүүн орнуудтай худалдааны түр хэлэлцээр байгуулах бодит шаардлагатай тулгарч байна.

ЕАЭЗХ нь Оросын Холбооны Улс, Беларусь, Казахстан, Армени, Киргиз зэрэг улсуудыг нэгтгэсэн бүс нутгийн эдийн засгийн интеграцийн байгууллага бөгөөд гишүүн орнуудын нийт хүн ам болон зах зээлийн цар хүрээг харгалзан үзвэл Монгол Улсын экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, худалдааны таатай нөхцөлийг бүрдүүлэх чухал боломжийг олгож байна.

Одоогийн байдлаар Монгол Улс болон ЕАЭЗХ-ны гишүүн орнууд хооронд тарифын болон тарифын бус саад бэрхшээлүүдээс шалтгаалан бараа бүтээгдэхүүний чөлөөт урсгал хязгаарлагдмал байсаар байна. Энэ нь үндэсний үйлдвэрлэл, экспортын баримжаатай аж ахуйн нэгжүүдийн өрсөлдөх чадварыг бууруулах, эдийн засгийн өсөлтийг сааруулах эрсдэл дагуулж байна.

Худалдааны түр хэлэлцээр байгуулснаар Монгол Улсын экспортын бүтээгдэхүүнийг ЕАЭЗХ-ны зах зээлд нэвтрүүлэх нөхцөлийг сайжруулах, худалдааны саад тотгорыг бууруулах, эдийн засгийн өсөлт болон ажлын байр нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлэх боломжтой.

Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг боловсруулах шаардлагатай гэж тодорхойлж байна.

3.2. Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлох:

Гаалийн татвараас чөлөөлөх барааны жагсаалтын талаар үйлдвэрлэл, гадаад худалдаа эрхлэгчдийн санал, байр суурийг нэгтгэх зорилгоор МҮХАҮТ-тай хамтран 2023.12.13 болон 2024.05.09-ний өдрүүдэд хоёр удаагийн төр, хувийн хэвшлийн 150 гаруй төлөөлөл оролцсон хэлэлцүүлгийг зохион байгуулж, гарсан санал, хүсэлтүүдийг айлын талтай хийсэн албан ёсны хэлэлцээний үеэр тавьж, зөвшөөрсөн саналуудыг хэлэлцээрийн төсөлд тусгасан болно. Мөн хэлэлцээрийн явцад МҮХАҮТ, ХХААХҮЯ-ны холбогдох мэргэжилтнүүдтэй уулзалт зохион байгуулж, барааны жагсаалтын талаар тухай бүр санал солилцсон.

ЭЗХЯ-ны зүгээс ХХААХҮЯ-аас 2023.10.20-ны өдрийн 03/1978 болон МҮХАҮТ-аас 2023.11.20-ны 03/2159 тоот албан бичгээр барааны жагсаалтад тусгайлан санал авч, ХХААХҮЯ-аас 2023.11.13-ны өдрийн 01/3970 албан бичгээр, МҮХАҮТ-аас 2023.11.29-ны өдрийн 01/1124 албан бичгээр тус тус хариу ирүүлсэн. Мөн холбогдох яамдаас 2024.07.25-ны өдрийн 01/1390 тоот албан бичиг болон бүх яамдаас 2024.10.03-ны өдрийн 01/2009 тоот албан бичгээр хэлэлцээрийн төсөлд санал авсан болно.

ЭЗХЯ-аас тус хэлэлцээрийг байгуулах ажилд олон нийтийн оролцоог хангах, хэлэлцээрийн үр шимийг хүртэгч, оролцогч талуудын санал, байр суурийг нэгтгэх зорилгоор ээлжит хэлэлцүүлгийг 2024 оны 1 дүгээр сарын 07-10-ны өдрүүдэд нийт 4 өдрийн турш мах, ноос, ноолуур, арьс шир, шингэн хүнс үйлдвэрлэл, архи, тамхи, газар тариалан, хүнсний ногоо, гурилан бүтээгдэхүүн, өндөг зэрэг бүх дэд салбарын хүрээнд үйлдвэрлэл, гадаад худалдаа эрхлэгч нар хооронд зохион байгуулсан.

Евразийн эдийн засгийн холбооны гишүүн орнуудтай худалдааны түр хэлэлцээр байгуулах нь Монгол Улсын дараах салбарын болон нийгмийн бүлгийн эрх ашигт шууд болон шууд бусаар нөлөөлөхөөр байна. Үүнд:

1. Экспортын чиглэлтэй аж ахуйн нэгжүүд: Ноос, ноолуур, арьс шир, мах, хөдөө аж ахуйн түүхий эд, хүнсний бүтээгдэхүүн зэрэг экспортын голлох салбарын үйлдвэрлэл эрхлэгчид нь энэхүү хэлэлцээр байгуулагдсанаар зах зээлд нэвтрэх нөхцөл, өрсөлдөх чадвар сайжрах хүлээлттэй байна.
2. Импортын чиглэлтэй аж ахуйн нэгжүүд: ЕАЭЗХ-ноос тоног төхөөрөмж, хүнс, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн импортлогч бөөний болон жижиглэн худалдаа эрхлэгчдийн хувьд тариф буурснаар бүтээгдэхүүний өртөг буурч, зах зээлийн өрсөлдөөнд давуу байдал үүсэх боломжтой.
3. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн нийлүүлэгч иргэд, малчид: Экспортын зах зээл тэлэх нь түүхий эдийн үнийг өсгөх, орлогыг нэмэгдүүлэх, зах зээлийн тогтвортой байдлыг хангах нөхцөл бүрдүүлнэ.
4. Хэрэглэгчид, нийт иргэд: Гаалийн импортын тариф буурах нь өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийг бууруулж, хэрэглэгчдийн худалдан авах чадварыг нэмэгдүүлэх боломжтой.

ДӨРӨВ. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОМЬЁОЛОХ

Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл батлагдсанаар дараах үр нөлөөг үзүүлнэ Үүнд:

1. Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбооны гишүүн орнуудтай байгуулах худалдааны түр хэлэлцээр хэрэгжсэн тохиолдолд Монгол Улсын ДНБ-ны бодит өсөлт 0.0203 хувиар нэмэгдэнэ. импортын тарифын орлого буурч өрхийн хэрэглээ болон экспорт нэмэгдсэнээр эцсийн хэрэглээ нэмэгдэж ДНБ-ний бодит өсөлтөд эерэг нөлөө үзүүлэхээр байна. Хөрөнгө оруулалтын өртөг хямдарч, хөрөнгө оруулалт нэмэгдэхтэй холбогдон бодит ДНБ суурь үеийнхээс өсөх төлөвтэй байна.
2. Өрсөлдөх чадвар бүхий бусад салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээ өсөх хандлагатай байгаа бөгөөд үүнд савхин эдлэл, малын мах, дайвар бүтээгдэхүүн, үхэр, хонь, ямаа, элсэн чихэр, тослог ургамал, нэхмэл, бусад мах, махан бүтээгдэхүүн зэрэг 30 салбар багтаж байна. Тухайлбал, эцсийн хувилбараар түр хэлэлцээр байгуулах тохиолдолд малын мах, дайвар бүтээгдэхүүн 1.4 хувь, үхэр, хонь, ямаа 1.2 хувь, элсэн чихэр 0.9 хувь, тослог ургамал 0.8 хувь, бусад мах, махан бүтээгдэхүүн 0.6 хувиар өсөлт үзүүлэх төлөвтэй байна.
3. Монгол Улсаас ЕАЭЗХ-ны гишүүн орнууд руу гаргах гол нэрийн барааны экспортын хэмжээ бусад орнуудтай харьцуулахад өндөр өсөлт үзүүлэхээр байна. Тухайлбал, ОХУ-д экспортлох бусад мах, махан бүтээгдэхүүний хэмжээ 140 хувийн өсөлт үзүүлэхээр байгаа нь хамгийн өндөр өсөлттэй салбар байна. Мөн ОХУ, Казахстан улсад экспортлох малын мах, дайвар бүтээгдэхүүний хэмжээ тус тус 125.0 хувь, 113.0 хувь, нэхмэл эдлэл тус тус 55.4 хувь, 27.0 хувь, савхин эдлэл тус тус 45.7 хувь, 152.0 хувиар өсөхөөр байна.
4. ЕАЭЗХ-ны гишүүн орнуудын экспорт буюу Монгол Улсын импортын барааны өөрчлөлтийн хувь бага байна. Тухайлбал Монгол Улсын модон эдлэлийн импорт 3.6%, шил керамик гипс 2.8%, гахай тахианы мах 2.1%, судаг өвсний үр 2.0%, жимс жимсгэнэ, шүүс, сахар, шоколад зэрэг хүнсний бүтээгдэхүүн 1.5%, хар төмөрлөг 1.5% тус тус өсөхөөр байна.
5. Монгол Улсын хувьд ЕАЭЗХ-ны гишүүн орнуудад нийт 511 барааны гаалийн тарифыг тэглэснээр тухайн барааг үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдийн орлого нэмэгдэж, хөдөө аж ахуйн салбарын шинэ зах зээлд нэвтрэх боломж бүрдэж, дотоодын бизнес эрхлэгчдийн гадаад худалдааны туршлага, чадварыг нэмэгдэж, олон улсын стандартад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд түлхэц болно.
6. Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн экспортлох үеийн эрүүл ахуй, хорио цээрийн шаардлагыг хялбаршуулах, мөн тохирлын үнэлгээний дүнг харилцан хүлээн зөвшөөрөх талаар хэлэлцээг эхлүүлэх нөхцөл бүрдэнэ.
7. Гаалийн мэдүүлгийг бүртгэснээс хойш 4 цагийн дотор барааг олгох зохицуулалт нь бараа бүтээгдэхүүний хил дээр саатал үүсэх эрсдэлийг бууруулж, нийлүүлэлтийн сүлжээг илүү шуурхай болгоно. Цахимаар мэдээлэл солилцох, бага эрсдэлтэй бараанд хялбаршуулсан горим хэрэглэх, итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж хөтөлбөр хэрэгжүүлснээр бизнес эрхлэгчдийн цаг хугацаа болон холбогдох зардлыг хэмнэж,

Монгол Улсын гаалийн шинэчлэлийг олон улсын жишигт хүргэхэд чухал алхам болно.

8. Гарал үүслийн гэрчилгээг цахимаар солилцох боломжийг бүрдүүлж, заавал цаасан эх хувь шаардах шаардлагагүй болгосон нь гаалийн үйл ажиллагааг хурдасгаж, бичиг баримтын бүрдүүлэлтийг хялбаршуулна. Мөн гадаад худалдаа эрхлэгч бараагаа экспортлох үед бүрдүүлэх гарал үүслийн гэрчилгээг МҮХАҮТ-аас авах шаардлагагүй бөгөөд 5000 еврогоос хэтрэхгүй бараанд гарал үүслийн мэдүүлгийг өөрөө гаргаж болохоор тусгасан. Ийнхүү гарал үүслийн мэдүүлгийг өөрсдөө гаргах нь цаг хугацаа, зардал хэмнэсэн, жижиг, дунд үйлдвэрлэгчдийг дэмжсэн зохицуулалт болно.
9. ЕАЭЗХ-ны гишүүн орнуудаас гаралтай материалыг ашиглан Монгол Улсад үйлдвэрлэсэн барааг Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд тооцох, барааг тээвэрлэхэд зориулж савласан савлагаа, баглаа боодлын материал, хайрцаг савыг тухайн барааны гарал үүслийг тогтооход тооцохгүй, тухайн бараанд 50%-иас ихгүй хувийн зохих гарал үүслийг тодорхойлсон нь барааг үйлдвэрлэхэд зарим нэг гарал үүсэлгүй материалыг ашиглах боломжийг олгосон нь Монгол Улсын үйлдвэрлэгчдэд гарал үүслийн хувьд илүү таатай нөхцөл олгоно.
10. Экспортын хэмжээ нэмэгдсэнээр гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалт өсөх хандлагатай бөгөөд энэ нь хүнс, хөдөө аж ахуйн салбарын өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг өргөжүүлж, чанар, бүтээмжийг нэмэгдүүлэхэд эергээр нөлөөлнө. Дотоодын үйлдвэрлэл өссөнөөр ажлын байрыг нэмэгдүүлнэ.
11. Мөн үйлдвэрлэлийн зардал буурч, импортын бүтээгдэхүүний үнэ хямдарснаар эцсийн хэрэглээнд таатай нөлөө үзүүлнэ. Энэ нь хэрэглэгчдийн худалдан авах чадварыг дэмжихийн зэрэгцээ инфляцын дарамтыг бууруулах боломжтой.
12. Монгол Улсын уул уурхайн бус бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэн эдийн засаг төрөлжиж, аливаа нэг улсаас импортын болон экспортын талаар хараат байдал багасаж, уул уурхайн бүтээгдэхүүний хамаарал буурах нөхцөл бүрдэнэ. Энэ нь эдийн засгийн тогтвортой байдалд эерэг нөлөө үзүүлнэ.

Иймд аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх зорилгыг дараах байдлаар тодорхойлж байна:

“Хэлэлцээрийн үр дүнд экспортын чиг баримжаатай хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх суурь нөхцөл бүрдэнэ.”

ТАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРЫГ ТОГТООЖ, ЭЕРЭГ БОЛОН СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛАХ

5.1. Асуудал зохицуулах хувилбаруудыг тогтоож, эерэг болон сөрөг талыг харьцуулан үзэх ажлын хүрээнд энэхүү аргачлалын Дөрөв дэх хэсэгт заасан зорилгыг биелүүлэхэд чиглэсэн зохицуулалтын хувилбаруудыг тогтооно. Зохицуулалтын дараах хувилбарууд байна:

Хувилбар		Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1	Тэг хувилбар	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй.	Шууд зардал гарахгүй ч, урт хугацаанд сөрөг үр дагавар (экспортын боломж алдах, үйлдвэрлэлийн зогсонги байдал) нэмэгдэнэ.	Үр дүн сөрөг
2	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Зорилгыг бүрэн хангахгүй	Зардал тодорхой хэмжээнд гарна. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бүрэн бууруулж чадахгүй.	Хязгаарлагдмал үр дүн
3	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Гаалийн тарифыг худалдааны хэлэлцээр байгуулахгүйгээр бууруулах боломжгүй.	Тодорхой хэмжээний зардал гарна. Гэвч асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй.	Дангаар үр дүнд хүрэхгүй
4	Төрөөс санхүүгийн интервенц хийх	Асуудлыг хэсэгчлэн зохицуулах боловч тогтвортой, урт хугацааны шийдэл биш.	Их хэмжээний зардал гарна. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй.	Тогтворгүй, богино хугацааны үр дүн
5	Захиргааны шийдвэр гаргах	Гаалийн тарифыг худалдааны хэлэлцээр байгуулахгүйгээр бууруулах боломжгүй.	Тодорхой хэмжээний зардал гарна. Гэвч асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй.	Дангаар үр дүнд хүрэхгүй
6	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Асуудлыг цогцоор нь шийдвэрлэж бүрэн зохицуулах боломжтой. Зорилгод бүрэн хүрнэ.	Эхний шатанд зардал гарна. Харин урт хугацаанд өндөр үр өгөөжтэй, тогтвортой үр нөлөө үзүүлнэ.	Үр дүнтэй

Хууль тогтоомжийн төсөл боловсруулж батлах нь асуудлын уг шалтгааныг шийдвэрлэх, олон талын үр өгөөжийг бий болгох, эрх зүйн үндэслэл бүхий, тогтвортой шийдэл болж байна.

Харин тэг хувилбар болон түр зуурын захиргааны арга хэмжээ нь бодит үр нөлөө багатай, сөрөг үр дагавар үүсгэх эрсдэлтэй тул хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг шууд сонголоо.

ЗУРГАА. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Хууль, тогтоомжийн тухай хуулийн 13, 14 дүгээр зүйл, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг тандан судлахдаа аргачлалд заасан дор дурдсан суурь асуултуудыг ашиглана судалгааг хийлээ. (Хүснэгт 1, 2, 3, 4-т харуулав)

6.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөөний тандан судалгаа: /Хүснэгт 1/

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх		
	1.1.1. Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх;	Тийм	Түр хэлэлцээр нь “үндэсний харьцааны зарчим” (national treatment)-ыг баримтлахыг заасан бөгөөд энэ нь дотоодын болон гадаадын этгээдэд ижил нөхцөлөөр хандах, ялгаварлан гадуурхахгүй байх зарчмыг тусгасан. Энэхүү зохицуулалт нь хүний эрхийн суурь зарчимтай нийцэж байна.
	1.1.2. Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх;	Үгүй	Түр хэлэлцээр нь аль нэг этгээд, аж ахуйн нэгжид онцгой давуу эрх олгохгүй, бүх талуудад ижил нөхцөл, харилцан ашигтай, тэгш боломжийг олгох зарчимд тулгуурласан.
	1.1.3. Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх;	Үгүй	Түр хэлэлцээрийн хүрээнд хөдөө аж ахуйн түүхий эд нийлүүлэгч малчид, хөдөө орон нутгийн жижиг үйлдвэрлэгчдийг дэмжих боломж бүрдэнэ.
	1.2. Оролцоог хангах		
	1.2.1. Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх;	Тийм	Түр хэлэлцээрийн төслийн явцад үйлдвэрлэл, гадаад худалдаа эрхлэгчид, салбарын холбоод, төрийн болон төрийн бус байгууллагууд, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн нийлүүлэгч иргэд зэрэг олон талын 150 гаруй төлөөллийг хамруулсан хэлэлцүүлгүүдийг МҮХАҮТ-тай хамтран хоёр удаа зохион байгуулсан. Мөн салбар тус бүрээр 4 өдрийн турш хэлэлцүүлэг зохион байгуулж, оролцогч талуудын санал бодлыг хэлэлцээрийн төсөлд тусгасан.
	1.2.2. Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх;	Тийм	Хэлэлцээрийн төсөл боловсруулах явцад экспорт, импортын чиглэлийн аж ахуйн нэгжүүд, малчид, жижиг дунд үйлдвэрлэгчид, худалдаа эрхлэгчид зэрэг олон талын

				оролцогчдын эрх ашиг, ашиг сонирхлыг тодорхойлсон.
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага			
	1.3.1. Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх;		Үгүй	Түр хэлэлцээр нь худалдааны харилцааг зохицуулж байгаа тул хүний эрхийн хамгааллын чиглэлээр шууд нөлөө үзүүлэхгүй.
	1.3.2. Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмын талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх;	Тийм		Хэлэлцээрийн төсөл нь Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн олон улсын гэрээ, НҮБ-ийн хүний эрхийн хамгааллын механизмд нийцсэн зохицуулалт, арга хэмжээнд нийцсэн.
	1.3.3. Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх;		Үгүй	хамааралгүй
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх;		Үгүй	Тус хэлэлцээр нь хүний үндсэн эрх, эрх чөлөөг хууль бус байдлаар хязгаарлах зохицуулалт агуулаагүй.
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх;		Үгүй	Хэлэлцээрийн төсөлд хүний эрхийг хязгаарлах шаардлагатай зайлшгүй хязгаарлалтууд тусгагдаагүй.
3. Эрх агуулагч	3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх;	Тийм		Хэлэлцээрийн төсөлд эрх ашиг нь хөндөгдөж буй болон оролцогч талууд болох экспортлогч, импортлогч аж ахуйн нэгжүүд болон бусад сонирхогч талуудыг тодорхойлж, тэдгээрийн эрх ашгийг харгалзан үзсэн.
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх;		Үгүй	Хэлэлцээрийн төсөлд эрх агуулагчдыг эмзэг байдлын хэмжээгээр ялган тодорхойлох зохицуулалт тусгагдаагүй.
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх;		Үгүй	Хэлэлцээрийн төсөлд эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах, хамгаалах чиглэлийн тусгай зохицуулалт тусгагдаагүй.
	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг		Үгүй	Хэлэлцээрийн төсөлд хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнхийн ялгаатай

	тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй);			хэрэгцээг тусгасан мэдрэмжтэй зохицуулалт тусгагдаагүй.
4. Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх;	Тийм		Хэлэлцээрийн төсөлд үүрэг хүлээгч талууд буюу хэлэлцээрийг хэрэгжүүлэх, хяналт тавих, зохицуулалт хийх төрийн байгууллага, аж ахуйн нэгж болон бусад оролцогчдыг тодорхойлсон бөгөөд тэдгээрийн үүргийг тусгасан.
5. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендерийн үзэл баримтлалыг тусгасан эсэх;		Үгүй	Хэлэлцээрийн төсөлд жендерийн үзэл баримтлал, жендерийн эрх тэгш байдлыг хангах заалтууд тусгагдаагүй.
	5.2. Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх;		Үгүй	Хэлэлцээрийн төсөлд эрэгтэй, эмэгтэй хүний эрх тэгш байдлыг баталгаажуулах тодорхой зохицуулалт, механизм тусгагдаагүй.

6.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөөний тандан судалгаа: /Хүснэгт 2/

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1. Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1. Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх;		Үгүй	Хэлэлцээрийн төсөл нь дотоодын болон гадаад хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдийн хоорондын өрсөлдөөнийг шууд нэмэгдүүлэх буюу хязгаарлах нөлөө үзүүлэхгүй.
	1.2. Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан);	Тийм		Хэлэлцээр байгуулагдсанаар хөдөө аж ахуйн салбарт хөрөнгө оруулалт нэмэгдэж, зарим салбарын үйлдвэрлэл, үйлчилгээ тодорхой бүс нутагт төвлөрөх боломжтой.
	1.3. Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх;	Тийм		ЕАЭЗХ-ны орнуудаас импортлох хүнс, шатахуун, бордоо зэрэг бүтээгдэхүүнд тогтвортой хангамж бүрдэх боломжтой.
2. Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1. Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх		Үгүй	Бараа, бүтээгдэхүүний сонголтыг нэмэгдүүлж, импортын зардал буурах тул зарим бүтээгдэхүүний үнэ тогтворжих, өрсөлдөөн нэмэгдэж, хэрэглэгчид илүү олон сонголт хийх боломжтой болно.
	2.2. Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас		Үгүй	Хэлэлцээр нь зах зээлийн нээлттэй байдлыг дэмжиж,

	үнийн хөөргөдлийг бий болгох эсэх;			худалдааны саад тогторыг бууруулах зорилготой тул нийлүүлэгчийн тоо нэмэгдсэнээр импортын барааны үнэ тогтворжиж, өрсөлдөөн нэмэгдэж үнийн хөөргөдөл үүсэх эрсдэл буурна.
	2.3. Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх;		Үгүй	Энэхүү хэлэлцээр нь гаалийн тариф, бусад худалдааны саад тогторыг бууруулах тул зах зээлд нэвтрэх нөхцөл сайжирна.
	2.4. Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх;		Үгүй	Хэлэлцээр нь онцгой эрх олгохгүй, тусгайлан нэг этгээдийг зах зээлд давамгайл болгохгүй.
3. Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1. Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх;		Үгүй	Аж ахуйн нэгжүүдэд шинэ төрлийн үүрэг, бүртгэл, тайлагналын нэмэлт шаардлага үүсгэхгүй.
	3.2. Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх;		Үгүй	Санхүүжилттэй шууд холбоотой зохицуулалтад өөрчлөлт оруулахгүй.
	3.3. Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх;		Үгүй	Хэлэлцээр нь зах зээл дээрх тодорхой бараа, бүтээгдэхүүнийг заавал худалдан авах, эсвэл тодорхой улс орноос нийлүүлэхийг шаардсан зохицуулалт агуулаагүй.
	3.4. Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх;		Үгүй	Бараа бүтээгдэхүүний борлуулалтад хязгаарлалт буюу хориг тавих зохицуулалт агуулаагүй.
	3.5. Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх;		Үгүй	Хэлэлцээрт аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэх, үйл ажиллагаагаа зогсооход хүргэх зохицуулалт, хоригийг тусгаагүй.
4. Мэдээлэх үүргийн улмаас үүсэж байгаа захиргааны зардлын ачаалал	4.1. Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх;		Үгүй	Хэлэлцээрт хуулийн этгээдэд мэдээлэл өгөх, тайлан гаргах зэрэг захиргааны нэмэлт зардал үүсгэх шаардлага тусгагдаагүй тул нэмэлт зардал үүсэхгүй.
5. Өмчлөх эрх	5.1. Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх;		Үгүй	Хэлэлцээр нь өмчлөх эрх, үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус баялагтай холбоотой эрхүүдэд нөлөө үзүүлэх зохицуулалт тусгагдаагүй.
	5.2. Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд		Үгүй	Хэлэлцээрт өмчлөх эрхийг олж авах, шилжүүлэх, хэрэгжүүлэхэд хязгаарлалт тогтоох зохицуулалт тусгагдаагүй.

	хязгаарлалт бий болгох эсэх;			
	5.3. Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх;		Үгүй	Оюуны өмчийн эрхийг хөндсөн зохицуулалт тусгагдаагүй.
6. Инновац болон судалгаа шинжилгээ	6.1. Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх;		Үгүй	Судалгаа, шинжилгээ хийх, инноваци, шинэ бүтээл гаргах үйл ажиллагааг шууд дэмжих зорилготой тусгай зохицуулалт тусгагдаагүй.
	6.2. Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх;		Үгүй	Хэлэлцээрт үйлдвэрлэлийн шинэ технологи, шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхтэй холбогдох зохицуулалт тусгагдаагүй.
7. Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1. Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Импортын бараа бүтээгдэхүүний үнэ буурах тул өрхийн хэрэглээний үнийн түвшнийг бууруулах нөлөө үзүүлэх боломжтой.
	7.2. Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх;		Үгүй	
	7.3. Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх;	Тийм		Хэлэлцээр хэрэгжсэнээр барааны хүртээмж, төрөлжилт нэмэгдэх, үнийн өрсөлдөөн бий болох зэрэг эерэг өөрчлөлтүүд гарна. Ингэснээр хэрэглэгчдийн сонголт нэмэгдэх, чанартай бараа бүтээгдэхүүн авах боломж сайжрах, үнэ буурах зэргээр хэрэглэгчдийн эрх ашигт эерэг нөлөө үзүүлнэ.
	7.4. Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх;	Тийм		Хэлэлцээрийн нөлөөгөөр импортын тариф буурах, бараа бүтээгдэхүүний өрсөлдөөн нэмэгдсэнээр нь хувь хүн, гэр бүлүүдийн өдөр тутмын хэрэглээний зардлыг бууруулах боломжтой.
8. Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1. Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх;	Тийм		Экспортын хэмжээ нэмэгдсэнээр гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалт өсөх хандлагатай бөгөөд энэ нь хүнс, хөдөө аж ахуйн салбарын өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг өргөжүүлж, чанар, бүтээмжийг нэмэгдүүлэхэд эергээр нөлөөлнө.

			Дотоодын үйлдвэрлэл өссөнөөр ажлын байрыг нэмэгдүүлнэ.
	8.2. Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх;	Тийм	Орон нутгийн зарим салбар, үйлдвэрлэл өрсөлдөөн нэмэгдсэнээс ажлын байр багасгах эрсдэл үүсэх боломжтой.
	8.3. Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх;	Тийм	Өрсөлдөх чадвар бүхий бусад салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээ өсөх хандлагатай байгаа бөгөөд үүнд савхин эдлэл, малын мах, дайвар бүтээгдэхүүн, үхэр, хонь, ямаа, элсэн чихэр, тослог ургамал, нэхмэл, бусад мах, махан бүтээгдэхүүн зэрэг 30 салбар багтаж байна. Тухайлбал, эцсийн хувилбараар түр хэлэлцээр байгуулах тохиолдолд малын мах, дайвар бүтээгдэхүүн 1.4 хувь, үхэр, хонь, ямаа 1.2 хувь, элсэн чихэр 0.9 хувь, тослог ургамал 0.8 хувь, бусад мах, махан бүтээгдэхүүн 0.6 хувиар өсөлт үзүүлэх төлөвтэй байна. ОХУ-д экспортлох бусад мах, махан бүтээгдэхүүний хэмжээ 140 хувийн өсөлт үзүүлэхээр байгаа нь хамгийн өндөр өсөлттэй салбар байна. Мөн ОХУ, Казахстан улсад экспортлох малын мах, дайвар бүтээгдэхүүний хэмжээ тус тус 125.0 хувь, 113.0 хувь, нэхмэл эдлэл тус тус 55.4 хувь, 27.0 хувь, савхин эдлэл тус тус 45.7 хувь, 152.0 хувиар өсөхөөр байна. Монгол Улсын модон эдлэлийн импорт 3.6%, шил керамик гипс 2.8%, гахай тахианы мах 2.1%, судаг өвсний үр 2.0%, жимс жимсгэнэ, шүүс, сахар, шоколад зэрэг хүнсний бүтээгдэхүүн 1.5%, хар төмөрлөг 1.5% тус тус өсөхөөр байна.
9. Төрийн захиргааны байгууллага	9.1. Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх;	Тийм	Хэлэлцээрээр импортын тариф буурч, гаалийн орлого багассанаар улсын төсөвт орж ирэх орлого буурах боломжтой. Гэхдээ экспортын өсөлт, эдийн засгийн өссөнөөр нь татварын орлогыг нэмэгдүүлж төсвийн алдагдлыг нөхөх боломжтой.

	9.2. Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх;		Үгүй	
	9.3. Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх;	Тийм		Гаалийн мэдээлэл болон гарал үүслийн гэрчилгээг цахимаар солилцох боломжийг бүрдүүлж, заавал цаасан эх хувь шаардах шаардлагагүй болгосон нь гаалийн үйл ажиллагааг хурдасгаж, бичиг баримтын бүрдүүлэлтийг хялбаршуулна.
10. Макро эдийн засгийн хүрээнд	10.1. Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх;	Тийм		Экспортын хэмжээ нэмэгдсэнээр гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалт өсөх хандлагатай бөгөөд энэ нь хүнс, хөдөө аж ахуйн салбарын өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг өргөжүүлж, чанар, бүтээмжийг нэмэгдүүлэхэд зөргээр нөлөөлнө. Дотоодын үйлдвэрлэл өссөнөөр ажлын байрыг нэмэгдүүлнэ.
	10.2. Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх;	Тийм		Экспортын хэмжээ нэмэгдсэнээр гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалт өсөх хандлагатай бөгөөд энэ нь хүнс, хөдөө аж ахуйн салбарын өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг өргөжүүлж, чанар, бүтээмжийг нэмэгдүүлэхэд зөргээр нөлөөлнө. Дотоодын үйлдвэрлэл өссөнөөр ажлын байрыг нэмэгдүүлнэ.
	10.3. Инфляц нэмэгдэх эсэх;		Үгүй	Үйлдвэрлэлийн зардал буурч, импортын бүтээгдэхүүний үнэ хямдарснаар эцсийн хэрэглээнд таатай нөлөө үзүүлнэ. Энэ нь хэрэглэгчдийн худалдан авах чадварыг дэмжихийн зэрэгцээ инфляцын дарамтыг бууруулах боломжтой.
11. Олон улсын харилцаа	11.1. Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх;	Тийм		ДХБ-ын хэлэлцээр болон бусад Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байна.

6.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөөний тандан судалгаа: /Хүснэгт 3/

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1. Ажил эрхлэлтийн	1.1. Шинээр ажлын байр бий болох эсэх;	Тийм		Дотоодын үйлдвэрлэл өссөнөөр ажлын байрыг нэмэгдүүлнэ.

байдал, хөдөлмөрийн зах зээл	1.2. Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх;		Үгүй	хамааралгүй
	1.3. Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх;	Тийм		Монгол Улсын хувьд ЕАЭЗХ-ны гишүүн орнуудад нийт 511 барааны гаалийн тарифыг тэглэснээр тухайн барааг үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдийн орлого нэмэгдэж, хөдөө аж ахуйн салбарын шинэ зах зээлд нэвтрэх боломж бүрдэж, дотоодын бизнес эрхлэгчдийн гадаад худалдааны туршлага, чадвар нэмэгдэж, олон улсын стандартад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд түлхэц болно.
	1.4. Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх;		Үгүй	хамааралгүй
2. Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1. Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх;	Тийм		Хэлэлцээрийн үр дүнд дотоодын бизнес эрхлэгчдийн гадаад худалдааны туршлага, чадвар нэмэгдэж, олон улсын стандартад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд түлхэц болно.
	2.2. Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх;		Үгүй	хамааралгүй
	2.3. Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх;		Үгүй	хамааралгүй
	2.4. Шинээр ажлын стандарт гаргах эсэх;		Үгүй	хамааралгүй
	2.5. Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх;		Үгүй	хамааралгүй
3. Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1. Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх;		Үгүй	хамааралгүй
	3.2. Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт;		Үгүй	хамааралгүй
	3.3. Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх;		Үгүй	Гадаадын иргэдэд шууд болон илэрхий сөрөг нөлөө үзүүлэхгүй.

4. Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1. Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх;		Үгүй	Засаглалын харилцаанд оролцогчдод шууд, илэрхий сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	4.2. Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх;	Тийм		Зарим төрийн байгууллага (гааль гм) шинэ үүрэг, хариуцлага хүлээх, үйл ажиллагааны хүрээ өргөжих, цахимжих боломжтой.
	4.3. Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх;		Үгүй	хамааралгүй
	4.4. Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх;		Үгүй	хамааралгүй
	4.5. Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх;		Үгүй	хамааралгүй
5. Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1. Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх;		Үгүй	хамааралгүй
	5.2. Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх;		Үгүй	хамааралгүй
	5.3. Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх;	Тийм		Зохицуулалтын хувилбар нь тамхи татвараас чөлөөлөх асуудлыг тусгасан тул тамхины хэрэглээ нэмэгдэх магадлалтай. Онцгой албан татвар нэмэгдүүлэх, тамхинд квот тогтоох зэргээр арга хэмжээ авч хэрэгжүүлэх тул тамхины хэрэглээний өсөлтийг хязгаарлах боломжтой.
6. Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1. Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх;		Үгүй	хамааралгүй
	6.2. Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх;		Үгүй	хамааралгүй
	6.3. Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан		Үгүй	хамааралгүй

	сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх;			
	6.4. Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх;		Үгүй	хамааралгүй
	6.5. Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх;		Үгүй	хамааралгүй
7. Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1. Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх;		Үгүй	хамааралгүй
	7.2. Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх;		Үгүй	хамааралгүй
	7.3. Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх;		Үгүй	хамааралгүй
	7.4. Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх;		Үгүй	хамааралгүй
8. Соёл	8.1. Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх;		Үгүй	хамааралгүй
	8.2. Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх;		Үгүй	хамааралгүй
	8.3. Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх;		Үгүй	хамааралгүй

6.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөөний тандан судалгаа: /Хүснэгт 4/

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1. Агаар	1.1. Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх;		Үгүй	хамааралгүй
2. Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1. Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх;		Үгүй	хамааралгүй
	2.2. Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх;		Үгүй	хамааралгүй

	2.3. Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх;		Үгүй	хамааралгүй
	2.4. Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх;		Үгүй	хамааралгүй
3. Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1. Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх;		Үгүй	хамааралгүй
	3.2. Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх;		Үгүй	хамааралгүй
	3.3. Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх;		Үгүй	хамааралгүй
	3.4. Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх;		Үгүй	хамааралгүй
4. Усны нөөц	4.1. Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх;		Үгүй	хамааралгүй
	4.2. Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх;		Үгүй	хамааралгүй
	4.3. Ундны усны чанарт нөлөөлөх эсэх;		Үгүй	хамааралгүй
5. Хөрсний бохирдол	5.1. Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх;		Үгүй	хамааралгүй
	5.2. Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх;		Үгүй	хамааралгүй
6. Газрын ашиглалт	6.1. Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх;		Үгүй	хамааралгүй
	6.2. Газрын зориулалтыг өөрчлөх эсэх;		Үгүй	хамааралгүй
	6.3. Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх;		Үгүй	хамааралгүй

7. Нөхөн сэргээгдэх /нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1. Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхыг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх;		Үгүй	хамааралгүй
	7.2. Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх;		Үгүй	хамааралгүй

6.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх талаар

“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн Зорилт 4.4-т “Бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцид нэгдэж, худалдааг хөнгөвчилнө”, “Зорилтыг хэрэгжүүлэх I үе шат 2021-2030 онд Хөрш орнуудыг дамжсан эдийн засгийн коридорыг хөгжүүлэх, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Оросын Холбооны Улстай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулж, бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцид нэгдэх замаар эдийн засгийн гадаад харилцааг эрс нэмэгдүүлэх үе” гэж заасан.

Мөн Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.5.1-т “Цөөн зах зээл, цөөн нэр төрлийн бүтээгдэхүүний экспорт, импортоос хэт хамааралтай үндэсний эдийн засгийн эмзэг байдлыг бууруулна.”, 3.2.5.3-т “Нэг орноос худалдан авах бараа бүтээгдэхүүн нийт импортод хэт давамгайлахаас сэргийлэх бодлого баримтална”, 3.2.5.4-т “Бүс нутгийн болон олон улсын интеграцид нэгдэх, чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах асуудлыг эдийн засгийн аюулгүй байдал, хөгжлийн шаардлагыг харгалзан, судалгаа, тооцоонд тулгуурлан, шат дараатай, сонголттойгоор хэрэгжүүлнэ” гэж тус тус заасан.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.2.11-т “Бүгд Найрамдах Солонгос Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, Бүгд Найрамдах Хятад Ард Улстай эдийн засгийн түншлэл, чөлөөт худалдааны хэлэлцээрийг байгуулж, худалдааны түнш улс орнуудтай хамтран ажиллах эдийн засгийн чиглэлийг нарийвчлан тодорхойлж, хөрөнгө оруулалт, экспорт, бизнесийг дэмжсэн харилцааг хөгжүүлнэ” гэж тусгагдсан.

Түр хэлэлцээрийг соёрхон батлах нь Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээ, хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилттой бүрэн нийцэж байгаа бөгөөд эдийн засгийн олон тулгуурт харилцаа, бүс нутгийн интеграцид Монгол Улсын оролцоог нэмэгдүүлэх бодлогын хэрэгжилтийг хангахад эерэг үр нөлөөтэй.

ДОЛОО.ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛЖ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ БОЛОВСРУУЛСАН БАЙДАЛ

7.2 Дүгнэлт:

Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын урьдчилсан тандан судалгааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтын дагуу хийлээ.

Дурдсан асуудлуудыг шийдвэрлэх хүрээнд эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох гэсэн зорилгыг хангахаар захиргааны шийдвэр гаргах, хуулийн төсөл боловсруулах гэсэн хувилбаруудыг дэвшүүлж, хувилбаруудын зорилгод хүрэх байдал, эерэг, сөрөг талуудыг харьцуулан судалж, хуулийн төсөл боловсруулах гэсэн хувилбарыг оновчтой хувилбар гэж сонгож байна.

Энэхүү хувилбарын хүний эрх, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур үзүүлэлтүүдийн дагуу тандан судалснаас хамааралтай үзүүлэлтүүдэд эерэг хариулттай байна.

7.2.Зөвлөмж:

Иймээс “Алсын хараа-2050” Монгол Улсын хугацааны хөгжлийн бодлого болон бусад дунд хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулахад үүднээс тус хуулийн төслийг боловсруулахыг зөвлөж байна.

-----o0o-----

МОНГОЛ УЛС БОЛОН ЕВРАЗИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХОЛБОО, ТҮҮНИЙ ГИШҮҮН
ОРНУУД ХООРОНДЫН ХУДАЛДААНЫ ТҮР ХЭЛЭЛЦЭЭРИЙГ СОЁРХОН БАТЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨЛЛИЙН СУДАЛГАА

УЛААНБААТАР ХОТ

2025 он

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
11 дүгээр зүйл Амьтан, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээ	3. Хоорондын худалдаанаас үүссэн, эсхүл үүсэж болзошгүй амьтан, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээтэй холбоотой аливаа асуудлын талаар нэг Тал бичгээр хүсэлт гаргасан тохиолдолд нөгөө Тал цаг тухайд нь мэдээллийг гаргаж өгнө. 4. Хэрэв нэг Тал нь нөгөө Талыг худалдаанд далд хориг үүсгэх, эсхүл үүсгэсэн арга хэмжээг авсан гэж үзвэл Хамтарсан хорооны хүрээнд Талууд тохиролцон техникийн зөвлөлдөх уулзалт хийнэ. Техникийн зөвлөлдөх уулзалтыг Талуудын харилцан тохиролцсон аливаа хэлбэрээр зохион байгуулж болно.	<u>Үгүй. Одоо хэрэгжиж буй хууль, тогтоомжийн хүрээнд хэрэгжиж буй үйл ажиллагаа.</u> Монгол Улсын Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Ургамал хамгааллын тухай хууль болон Хүнсний тухай хуулийн хүрээнд хэрэгжинэ.
13 дугаар зүйл. Гаалийн байгууллага ба худалдааг хөнгөвчлөх	6. Талууд тэдгээрийн хоорондын худалдааг хөнгөвчлөх үүднээс барааг түргэн шуурхай олгоход чиглэсэн гаалийн горим, арга ажиллагаа баталж, эсхүл тийм горим, арга ажиллагаатай бол цаашид үргэлжлүүлэн мөрдөнө. Энэ нь аль нэг Талын бараа олгоход тавьсан шаардлага хангагдаагүй тохиолдолд уг барааг олгохыг тухайн Талаас шаардаагүй болно. 7. Талууд энэхүү зүйлийн 6 дахь хэсэгт заасны дагуу	<u>Үгүй. Одоо хэрэгжиж буй хууль, тогтоомжийн хүрээнд хэрэгжиж буй үйл ажиллагаа.</u> 6, 7-д заасан үйл ажиллагаа нь Монгол Улсын Гаалийн тухай

	дараах арга хэмжээг авна: (а) Талуудын гаалийн хууль тогтоомж, дүрэм журамд өөрөөр зааснаас бусад тохиолдолд, барааг гаалийн мэдүүлгийг бүртгэснээс хойш 4 цагаас илүүгүй хугацааны дотор олгохоор заах; (b) бараа ирмэгц түргэн шуурхай олгох нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор гаалийн мэдээллийг бараа ирэхээс өмнө цахимаар илгээх болон боловсруулах журам батлах, эсхүл тийм журамтай бол цаашид үргэлжлүүлэн мөрдөх; (с) хяналт шалгалтыг өндөр эрсдэлтэй бараанд төвлөрүүлэх, бага эрсдэлтэй бараанд хамаарах гаалийн арга ажиллагааг хялбарчлах зорилгоор эрсдэлийг системтэй үнэлэх боломжтой эрсдэлийн удирдлагын системийг хэрэгжүүлэх. 8. Талууд цаашид Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж (ИААН)-ийн хөтөлбөр гэх аюулгүй байдлын тодорхой шалгуур хангасан аж ахуйн нэгжид зориулсан худалдааг хөнгөвчлөх түншлэлийн хөтөлбөрийг Дэлхийн гаалийн байгууллагын Дэлхийн худалдааг аюулгүй байлгах, хөнгөвчлөх Аюулгүй байдлын багц стандартын дагуу хэрэгжүүлнэ. 9. Талууд дараах байдлаар хамтран ажиллахыг эрмэлзэнэ: (а) тэдгээрийн ИААН-ийн холбогдох хөтөлбөрийг хэрэгжүүлсэн болон сайжруулсан туршлагаасаа солилцох, боломжтой бол шилдэг туршлагаудаас нэвтрүүлэхийг эрмэлзэх; (b) хөтөлбөр тус бүрийн дагуу итгэмжлэл авсан аж ахуйн нэгжүүдийн талаарх мэдээллийг тус тусын Талын хууль тогтоомж болон тогтсон журмын дагуу харилцан солилцох; (с) Нөгөө Талын итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжид худалдааг хөнгөвчлөх чиглэлээр үзүүлэх хөнгөлөлтийг тодорхойлох, хэрэгжүүлэхэд хамтран ажиллах.	хууль болон Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн хүрээнд хэрэгжинэ. Гаалийн ерөнхий газар нь барааг түргэн шуурхай олгох, эрсдэлийн удирдлагын систем ашиглан хяналт шалгалтыг автоматжуулах чиг үүргийг хэрэгжүүлдэг. 8, 9-т заасан үйл ажиллагаа нь Гаалийн тухай хуулийн хүрээнд хэрэгжиж байгаа бөгөөд ИААН-ийн хөтөлбөрийг Гаалийн ерөнхий газар олгодог. Олон улсын хэмжээнд гаалийн хяналт, хамтын ажиллагааны хөтөлбөрүүдэд нэгдэж, мэдээлэл солилцох нь журмаар зохицуулагдаж байна. Одоогоор Монгол Улсад 6 аж ахуйн нэгж итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн хөтөлбөрт хамрагдсан байна.
14 дүгээр зүйл Гаалийн хамтын ажиллагаа	3. Аль нэг Талаас энэхүү зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу гаргасан хүсэлт нь бичгээр байх бөгөөд түүнд тухайн мэдээллийг ямар зорилгоор хүсэж байгаа талаар тодорхой бичсэн, мөн тухайн барааг ялган таних хангалттай мэдээллийг хавсаргасан байна. Хүсэлтийг энэ Зүйлийн 6 дахь хэсэгт заасан харилцаа холбооны сувгийг ашиглан цахим хэлбэрээр дамжуулна. Мөн хүсэлтийн цаасан хувийг шуудангаар илгээнэ. Энэхүү зүйлд заасан бүх хүсэлт, тэдгээрийн бүх хариуг англи хэл дээр илгээнэ. 4. Энэхүү зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу гаргасан хүсэлтийг хүлээн авсан Талын гаалийн байгууллага нь уг хүсэлтэд заасан мэдээлэл агуулсан хариуг өөрийн Талын холбогдох хууль тогтоомж болон дүрэм журмын дагуу, уг хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 2 (хоёр) сарын дотор бичгээр гаргаж өгнө. Хариуг тогтоосон хугацаанд бүрэн, эсхүл хэсэгчилсэн байдлаар гаргаж өгөх боломжгүй бол хүсэлт хүлээн авсан гаалийн байгууллага нь хүсэлт гаргасан гаалийн байгууллагад тухайн мэдээллийг гаргаж өгөх тодорхой хугацааг мэдэгдэнэ. 6. Талуудын гаалийн байгууллагууд мэдээллийг түргэн шуурхай бөгөөд аюулгүй байдлаар солилцох, мөн	<u>Үгүй. Одоо хэрэгжиж буй хууль, тогтоомжийн хүрээнд хэрэгжиж буй үйл ажиллагаа.</u> Гаалийн тухай хуулийн дагуу Гаалийн ерөнхий газар нь гадаадын гаалийн байгууллагуудтай мэдээлэл солилцох, хамтран ажиллах эрх, үүрэгтэй байдаг бөгөөд энэ хүрээнд бүрэн хэрэгжинэ.

	гаалийн асуудлыг зохицуулах ажлыг боловсронгуй болгох явдлыг хөнгөвчлөх үүрэг бүхий холбоо барих этгээдүүдийг томилох зэргээр гаалийн хамтын ажиллагааны харилцаа холбооны сувгууд бий болгож, ажиллуулахыг эрмэлзэнэ. 7. Гаалийн байгууллага ба худалдааг хөнгөвчлөхөд хамаарах тодорхой асуудлуудыг хэлэлцэх техникийн уулзалтуудыг Талуудын тохиролцсон хугацаа, газарт зохион байгуулна. 10.Талууд мэдээллийг цахимаар солилцохдоо ЕАЭЗХ-ны Мэдээллийн нэгдсэн системийн техникийн дэд бүтэц болон Монгол Улсын холбогдох дэд бүтцийг ашиглана.	
23 дугаар зүйл Цахим худалдаа	9. Талууд дотоодын хууль тогтоомж, дүрэм журмын дагуу хувийн мэдээллийг хамгаалах, түүний дотор хувийн мэдээллийг хил дамнуулан дамжуулах болон хувийн мэдээллийг хил дамнуулан дамжуулахтай холбогдох нөхцөл, шаардлагыг хангах арга хэмжээг баталж, хэрэгжүүлнэ. 10. Тал тус бүр энэхүү зүйлийн хэрэгжилтээс үүдэх аливаа асуудлаар нөгөө Тал болон Хамтарсан хороотой харилцах харилцааг хариуцах холбоо барих этгээдийг томилно.	<u>Үгүй. Одоо хэрэгжиж буй хууль, тогтоомжийн хүрээнд хэрэгжиж буй үйл ажиллагаа.</u> 9-д заасан арга хэмжээ нь Монгол Улсын Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн хүрээнд хэрэгжинэ. 10-т заасан Холбоо барих этгээдийг асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон харьяа байгууллагын одоо ажиллаж буй хүний нөөцийн хүрээнд шийдвэрлэх боломжтой.
26 дугаар зүйл Хамтарсан хороо	1. Талууд нь Хэлэлцээрийн Тал бүрийн төлөөлөгчдөөс бүрдсэн Хамтарсан хороог байгуулах ба тус хороог хоёр төлөөлөгч хамтран даргалах ба нэг төлөөлөгч нь ЕАЭЗХ болон түүний гишүүн орнуудыг төлөөлж Евразийн Эдийн Засгийн Комиссын Удирдах зөвлөлийн гишүүн, нөгөө төлөөлөгч нь Монгол Улсын Эдийн засаг, хөгжлийн яам ба/эсхүл түүнийг залгамжлагч этгээд байна. Энэхүү зорилгоор зохих ёсоор эрх олгогдсон өндөр албан тушаалтнууд Талуудыг төлөөлнө. 2. Талууд Хамтарсан хорооны хуралдаан болохоос 30 (гуч)-аас ихгүй хоногийн өмнө Хамтарсан хороонд томилсон тус тусын төлөөлөгчийн талаар харилцан мэдэгдэнэ. 3. Хамтарсан хороо нь дараах чиг үүрэгтэй байна: - энэхүү Хэлэлцээрийн хэрэгжилт, үйл ажиллагаатай холбоотой бүх асуудалд хяналт тавих, шалгах; - Талуудын хоорондын худалдааны харилцааг цаашид хөгжүүлэх боломжийг судлах; - энэхүү Хэлэлцээрт оруулах нэмэлт, өөрчлөлтийг судалж, Талуудад хэлэлцүүлэхээр хүргүүлэх; мөн	<u>Үгүй. Одоо хэрэгжиж буй хууль, тогтоомжийн хүрээнд хэрэгжиж буй үйл ажиллагаа.</u> Хамтарсан хороог Хэлэлцээрийн хэрэгжилтэд хамаарах төрийн байгууллагын холбогдох албан тушаалтнуудыг оролцуулан байгуулах ба тэдгээр нь ажлын байрны үүргийн хүрээнд олон улсын гэрээ, хэлэлцээрийг хэрэгжүүлэх, ажлын хэсэг, хороонд оролцох үүрэгтэй тул нэмэлт зардал үүсэхгүй. Энэ тохиолдолд Эдийн засаг, хөгжлийн яам болон Гадаад харилцааны яам,

	d. энэхүү Хэлэлцээрийн хамрах хүрээ, зорилгын хүрээнд Талуудаас тус Хамтарсан хороонд даалгасан Хэлэлцээрт хамаарах аливаа асуудалтай холбоотой бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх. 6. Талууд өөрөөр тохиролцоогүй бол Хамтарсан хорооны хуралдааныг дор хаяж жил тутам тухай бүр Талуудад ээлжлэн хуралдуулна. 7. Талууд Хамтарсан хорооны үйл ажиллагааны дүрмийг нэгтгэн боловсруулж, Хамтарсан хорооны анхны хуралдаанаар батална.	Гаалийн ерөнхий газар зэрэг холбогдох байгууллагаас ажиллах боломжтой.
27 дугаар зүйл Холбоо барих этгээд	1. Энэхүү Хэлэлцээрийн үр дүнтэй хэрэгжилтийг хангах болон энэхүү Хэлэлцээрт хамаарах аливаа асуудлаар Талуудын хоорондын харилцаа холбоог дэмжихийн тулд Тал тус бүр энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 1 (нэг) сарын дотор холбоо барих этгээд эсхүл холбоо барих этгээдүүдийг томилж, нөгөө Талд мэдэгдэнэ. Талууд харилцах этгээдийн тухай дэлгэрэнгүй мэдээлэлд оруулсан аливаа өөрчлөлтийг нөгөө Талдаа даруй мэдэгдэнэ. 2. Талуудын холбоо барих этгээд нь дор дурдсан үүрэгтэй байна: (a) нөгөө Талаас гаргасан санал эсхүл хүсэлтийг хүлээн авах; (b) энэхүү хэсгийн (a) заалтад дурдсан санал, хүсэлтэд хариу өгөх бөгөөд шаардлагатай тохиолдолд тухайн Талын холбогдох бусад эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллана.	<u>Үгүй. Одоо хэрэгжиж буй хууль, тогтоомжийн хүрээнд хэрэгжиж буй үйл ажиллагаа.</u> Энэ нь олон улсын гэрээ хэлэлцээр хэрэгжүүлэхтэй холбоотой нийтлэг зохицуулалт бөгөөд Монгол Улсын холбогдох яам, агентлагууд өөрийн чиг үүргийн хүрээнд албан ёсны холбоо барих ажилтныг томилж ажиллуулах боломжтой.
Хавсралт 1. Евразийн эдийн засгийн холбооны тарифын жагсаалт	Энэ Хавсралтад заасан зохих гарал үүсэлтэй бараанд аль нэг Тал ногдуулсан гаалийн татварын хувь хэмжээ Талууд тохиролцон энэ Хавсралтын 4 дүгээр баганад заасан холбогдох хувь хэмжээнээс ихгүй байна.	<u>Тийм. Хэлэлцээрт оролцогч талуудын барааны гаалийн тарифыг хэрэгжүүлснээр эдийн засаг, төсөвт үзүүлэх нөлөөллийг тооцсон.</u>
Хавсралт 2 Монгол Улсын тарифын жагсаалт	Энэ Хавсралтад заасан зохих гарал үүсэлтэй бараанд аль нэг Тал ногдуулсан гаалийн татварын хувь хэмжээ Талууд тохиролцон энэ Хавсралтын 4 дүгээр баганад заасан холбогдох хувь хэмжээнээс ихгүй байна.	
Хавсралт 3. Гарал үүслийн дүрэм. 28 дугаар зүйл: Мэдээллийн веб сан ашиглах, гарал үүслийн мэдээллийг цахимаар солилцох систем хөгжүүлж, нэвтрүүлэх	1. Тарифын хөнгөлөлт эдлэх журмыг хялбарчлах зорилгоор Талууд олгосон гарал үүслийн гэрчилгээний талаарх мэдээлэл агуулсан бөгөөд олгосон аливаа гарал үүслийн гэрчилгээ үнэн зөв эсэхийг импортлогч Талын гаалийн байгууллагаас шалгах боломжийг бүрдүүлсэн, итгэмжлэгдсэн байгууллагуудын аюулгүй мэдээллийн веб сан (цаашид “мэдээллийн веб сан” гэх)-г ашиглаж болно. 4. Хэрэв Талууд мэдээллийн веб сан ашиглаж байгаа бол импортлогч Талын гаалийн байгууллага гарал үүслийн оригинал гэрчилгээ шаардахгүй. Энэ тохиолдолд тухайн гарал үүслийн гэрчилгээний хуулбар (цаасан, эсхүл файл хэлбэртэй), эсхүл гарал үүслийн цахим гэрчилгээ нь тарифын хөнгөлөлт үзүүлэхэд хангалттай. 5. Хэрэв гарал үүслийн гэрчилгээний талаарх мэдээлэл гаалийн мэдүүлгийг бүртгэсэн өдөр мэдээллийн веб санд ороогүй байвал зөвхөн энэ зүйлийн 3 дахь хэсэгт	<u>Үгүй. Одоо хэрэгжиж буй хууль, тогтоомжийн хүрээнд хэрэгжиж буй үйл ажиллагаа.</u> Монгол Улсын Гаалийн тухай хуулиар гаалийн мэдээллийн сангийн асуудал зохицуулагдаж байгаа ба Гаалийн ерөнхий газар нь гадаад худалдааны мэдээлэл, тэр дундаа гарал үүслийн гэрчилгээний мэдээллийг цахим

	заасны дагуу гарал үүслийн гэрчилгээг цахимаар олгосноос бусад тохиолдолд импортлогч Талын гаалийн байгууллага оригинал гарал үүслийн гэрчилгээ гаргаж өгөхийг шаардана. 8. Хэрэв Талууд EODES-ийг нэвтрүүлсэн бол импортлогч Талын гаалийн байгууллага гарал үүслийн оригинал гэрчилгээ, түүний хуулбар, эсхүл гарал үүслийн цахим гэрчилгээ шаардахгүй. Энэ тохиолдолд, тарифын хөнгөлөлт зорилгоор тухайн гарал үүслийн гэрчилгээний огноо, дугаарыг гаалийн мэдүүлэгт тусгасан байна. 9. Хэрэв гарал үүслийн гэрчилгээний мэдээлэл гаалийн мэдүүлгийг бүртгэсэн өдөр EODES-т ороогүй байвал импортлогч Талын гаалийн байгууллага гарал үүслийн гэрчилгээний хуулбарыг шаардаж, түүний үнэн зөв эсэхийг мэдээллийн веб сан ашиглан шалгана. Хэрэв итгэмжлэгдсэн байгууллагад мэдээллийн веб сан байхгүй бол зөвхөн энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу гарал үүслийн гэрчилгээг цахимаар олгосноос бусад тохиолдолд гарал үүслийн гэрчилгээний эхийг гаргаж өгнө.	хэлбэрээр солилцох, мэдээллийн сан ашиглах эрхтэй. Одоогийн Цахим гааль болон Эрсдэлийн удирдлагын системүүдийг ашиглан энэхүү үүргийг хэрэгжүүлэх боломжтой юм. Мөн гадаад худалдааны цахим нэг цонх нэвтрүүлэхээр ажиллаж байгаа ба энэ хүрээнд шийдвэрлэх бүрэн боломжтой.
Хавсралт 3. Гарал үүслийн дүрэм. 29 дүгээр зүйл: Гарал үүслийг шалгах	1. Хэрэв импортлогч Талын гаалийн байгууллага гарал үүслийн нотлох баримт үнэн зөв эсэхэд, мөн/эсхүл уг гарал үүслийн нотлох баримтад заасан бараа нь энэхүү Дүрмийн 3 дугаар зүйлд заасан гарал үүслийн шалгуурт нийцэж байгаа эсэхэд эргэлзэж байгаа бол, эсхүл санамсаргүй сонголтоор шалгалт хийх тохиолдолд тухайн гарал үүслийн нотлох баримт үнэн зөв эсэхийг, мөн (эсхүл) тухайн бараа нь гарал үүслийн холбогдох шалгуурт нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах, түүнчлэн (эсхүл), хэрэв тийнхүү хүссэн бол, тухайн барааг үйлдвэрлэгч, эсхүл экспортлогчоос нотлох баримт гаргуулах хүсэлтийг экспортлогч Талын шалгах эрх бүхий байгууллагад илгээж болно (цаашид "шалгах хүсэлт" гэх). 2. Энэ Дүрмийн 25 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "b"- "g"- д заасан тохиолдолд, импортлогч Талын гаалийн байгууллага тарифын хөнгөлөлт үзүүлэхээс татгалзсан шийдвэр гаргах зорилгоор шалгах хүсэлт гаргах шаардлагагүй. 3. Бүх шалгах хүсэлтэд тухайн барааг ялган таних хангалттай мэдээлэл, гарал үүслийн нотлох баримтын хуулбарыг хавсаргаж, тийм хүсэлт гаргах болсон нөхцөл, шалтгааныг дурдсан байна. 5. Шалгах хүсэлтийн хуулбар болон түүний дагалдах бичиг баримтууд, түүнчлэн тухайн хүсэлтийн дагуу шалгасан хариуг импортлогч Талын гаалийн байгууллага болон экспортлогч Талын шалгах эрх бүхий байгууллага хооронд энэхүү Дүрмийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан холбоо барих цахим шуудангийн хаягаар цахим хэлбэрээр илгээнэ. 6. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүсэлтийн хариуд экспортлогч Талын шалгах эрх бүхий байгууллага нь тухайн гарал үүслийн нотлох баримт үнэн зөв эсэхийг, мөн (эсхүл) тухайн барааг тэрхүү Талын гарал үүсэлтэй гэж үзэж болох эсэхийг тодорхой зааж өгөх бөгөөд түүнд бас тухайн хүсэлтэд заасны дагуу холбогдох бараа үйлдвэрлэгчээс, эсхүл экспортлогчоос гаргуулан авсан нотлох баримтыг хавсаргасан байна. Шалгах хүсэлтийн хариуг хүлээн авахаас өмнө энэхүү Дүрмийн 24 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийг ашиглаж болно. Хэрэв хүлээн авсан шалгалтын үр дүнг харахад тухайн бараа зохих гарал үүсэлтэй бөгөөд энэхүү Дүрмийн бусад бүх	<u>Үгүй. Одоо хэрэгжиж буй хууль, тогтоомжийн хүрээнд хэрэгжиж буй үйл ажиллагаа.</u> Гаалийн тухай хуулийн хүрээнд зохицуулагдаж байна.

	шаардлагыг хангасан болох нь батлагдсан бөгөөд тодорхой бол урьдчилан төлсөн гаалийн татвар болон депозитыг буцаан олгоно.	
Хавсралт 3. Гарал үүслийн дүрэм. 30 дугаар зүйл: Газар дээр нь очиж шалгах	1. Хэрэв импортлогч Талын гаалийн байгууллага энэхүү Дүрмийн 29 дүгээр зүйлд заасан шалгалтын үр дүнг хангалтгүй гэж үзвэл онцгой тохиолдолд экспортлогч Талд очиж шалгах, энэхүү Дүрмийн 23 дугаар зүйлд заасан бүртгэлтэй танилцах, мөн (эсхүл) тухайн барааг үйлдвэрлэхэд ашигласан байгууламжийг үзэж харах хүсэлт тавьж болно. 2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шалгалтыг газар дээр нь очиж хийх үүднээс импортлогч Талын гаалийн байгууллага тийнхүү газар дээр нь очиж шалгах хүсэлтэй байгаагаа илтгэсэн хүсэлт (цаашид "газар дээр нь очиж шалгах хүсэлт" гэх)-ийг экспортлогч Талын шалгах эрх бүхий байгууллагад бичгээр илгээнэ. Уг газар дээр нь очиж шалгах хүсэлтийн хуулбарыг импортлогч Талын гаалийн байгууллагаас экспортлогч Талын шалгах эрх бүхий байгууллагад энэхүү Дүрмийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан холбоо барих цахим шуудангийн хаягаар цахим хэлбэрээр илгээнэ. 3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан, газар дээр нь очиж шалгах хүсэлт нь аль болох дэлгэрэнгүй байх бөгөөд түүнд тухайлбал дараах зүйлсийг тусгасан байна: (a) тухайн Талын тийм хүсэлт гаргасан гаалийн байгууллагын нэр; (b) бараа үйлдвэрлэгч, эсхүл экспортлогч ямар байгууллагын байр агуулахыг очиж үзэх гэж байгаа; (c) газар дээр нь хэзээ очиж шалгах саналтай байгаа; (d) газар дээр нь очиж шалгах ажлын хамрах хүрээ, түүний дотор шалгах бараа, тэдгээрийн гарал үүсэл ямар асуудалтай байгаа; мөн (e) газар дээр нь очиж шалгалт хийх гэж буй эрх бүхий байгууллагын талаарх урьдчилсан мэдээлэл. 5. Газар дээр нь очиж шалгах хүсэлт гаргасан өдрөөс хойш жар (60) хоногийн дотор шалгах эрх бүхий байгууллагаас бичгээр үйлдсэн зөвшөөрөл хүлээж аваагүй, эсхүл газар дээр нь очиж шалгахыг татгалзсан хариу хүлээж авсан тохиолдолд хүсэлт гаргасан Тал газар дээр нь очиж шалгах байсан гарал үүслийн нотлох баримт(ууд)-ад дурдсан бараанд тарифын хөнгөлөлт үзүүлэхээс татгалзана. 7. Газар дээр нь очиж шалгах ажлыг импортлогч болон экспортлогч Талуудын эрх бүхий байгууллагуудын төлөөлөгчдөөс бүрдсэн шалгах баг хийж гүйцэтгэнэ. 10. Хэрэв шалгуулж буй Талын эрх бүхий байгууллага, аж ахуйн нэгжийн зүгээс газар дээр нь очиж шалгах ажилд саад учруулсны улмаар газар дээр нь очиж шалгах боломжгүй болсон бол импортлогч Тал тухайн бараанд тарифын хөнгөлөлт үзүүлэхээс татгалзах эрхтэй. 14. Газар дээр нь очиж хийх шалгалтад импортлогч Талын төлөөлөгчид оролцохтой холбогдон гарах бүх зардлыг импортлогч Тал хариуцна.	<u>Үгүй. Одоо хэрэгжиж буй хууль, тогтоомжийн хүрээнд хэрэгжиж буй үйл ажиллагаа.</u> Гаалийн тухай хуулийн хүрээнд зохицуулагдаж байгаа ба Гаалийн байгууллага гаалийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор чөлөөт эргэлтэд байгаа барааны мэдээллийн үнэн зөвийг шалгах эрхтэй. Шаардлагатай тохиолдолд газар дээр нь очиж шалгалт хийх нь энэ эрх, үүргийн үргэлжлэл юм. Уг шалгалтыг хоёр талын гаалийн байгууллагын төлөөлөгчдөөс бүрдсэн баг гүйцэтгэхээр заасан нь олон улсын практикт нийцсэн, хэрэгжиж болох зохицуулалт юм. Шалгалтын зардлыг импортлогч тал хариуцахаар заасан нь мөн хуулийн хүрээнд төсөвлөн шийдвэрлэх боломжтой.

МОНГОЛ УЛС БОЛОН ЕВРАЗИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХОЛБОО, ТҮҮНИЙ ГИШҮҮН
ОРНУУД ХООРОНДЫН ХУДАЛДААНЫ ТҮР ХЭЛЭЛЦЭЭРИЙГ СОЁРХОН БАТЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨЛЛИЙН СУДАЛГАА

УЛААНБААТАР ХОТ

2025 он

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээний ажлын гол зорилт нь Монгол Улс болон ЕАЭЗХ, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл /цаашид “хуулийн төсөл” гэх/-ийн үр нөлөөг үнэлж, хуулийн төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилган хуулийг хэрэглэхэд ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад чиглэсэн зөвлөмж өгөхөд оршино. Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх үйл ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан Хуулийн төслийн үр нөлөөг тооцох аргачлалд заасны дагуу дараах үе шатын дагуу боловсруулав. Үүнд:

- Шалгуур үзүүлэлтийг сонгох;
- Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
- Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
- Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах харилцаатай уялдуулан аргачлалд дурдсан 6 шалгуур үзүүлэлтүүдийн дагуу гүйцэтгэсэн. Үүнд:

- Зорилгод хүрэх байдал;
- Практик хэрэгжих байдал;
- Ойлгомжтой байдал;
- Хүлээн зөвшөөрөгдөх байдал;
- Харилцан уялдаа.

Монгол Улс болон ЕЭЗХ, түүний гишүүн орнууд хоорондын Худалдааны түр хэлэлцээр байгуулах асуудал нь “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн Зорилт 4.4, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.5.1, 3.2.5.3, 3.2.5.4, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.2.11-т тус тус тусгагдсан. Энэ хүрээнд хуулийн төслийн үр нөлөөг олон талаас нь шинжилж, холбогдох нөлөөллийн судалгаануудыг гүйцэтгэсэн болно.

Зорилгод хүрэх байдал гэсэн шалгуур үзүүлэлтээр хуулийн төсөл нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцэж буй эсэх, хуулийн төслийн хүрээнд дэвшүүлсэн зорилгод хүрэх боломжтой эсэхийг үнэлэхэд ашигласан.

Практикт хэрэгжих боломж гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг хэрэгжүүлэх боломжтой эсэхийг шалгаж тооцсон.

Ойлгомжтой байдал гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийг хэрэгжүүлэх, субъектүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтай боловсруулсан эсэхийг шинжилж, Хууль, тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагын дагуу боловсруулсан эсэхийг хянаж, үнэлгээг хийсэн.

Хүлээн зөвшөөрөгдөх байдал гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн зохицуулалт иргэд, байгууллагад хэрхэн нөлөөлөх талаар болон оролцогч талууд хүлээн зөвшөөрөх эсэхийг шалган шинжилсэн болно.

Харилцан уялдаа гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн зүйл, заалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж буй бусад хууль тогтоомжтой нийцтэй байдал, төрийн байгууллагын чиг үүрэг давхардсан болон зөрчилдсөн эсэх, тухайн чиг үүргийг төрийн байгууллага зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай эсэх, уг чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжтой эсэх, хуулийн төсөлд жондөрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх, шударга бус өрсөлдөөнийг бий болгоход болон авлига, хүнд суртлыг үүсгэхэд чиглэсэн заалт тусгагдсан эсэхийг үнэлсэн.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ

Зорилгод хүрэх байдал гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл боловсруулах болон хууль зүйн болон практик үндэслэл, хэрэгцээ шаардлагад хуулийн төслийн зорилт, холбогдох зохицуулалтууд нийцэж байгаа эсэхэд үзэл баримтлал болон хуулийн төслийн зорилт, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээг хийсэн.

Түүнчлэн хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангаж боловсруулагдсан эсэхийг хянах зорилгоор төслийг бүхэлд нь сонгож байна. Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог аргачлалын дагуу тусгайлан боловсруулсан тул энэхүү үр нөлөөний үнэлгээнд оруулаагүй болно.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтоохдоо сонгосон 5 шалгуур үзүүлэлт тус бүрээр үр нөлөөг тооцож, судалгаа хийсэн бөгөөд тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгах хэрэгсэл /Хүснэгт 1/

	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1.	Зорилгод хүрэх байдал	1 дүгээр зүйл. “Монгол Улс болон ЕАЭЗХ түүний гишүүн орнууд хооронд байгуулах худалдааны түр хэлэлцээрийн”-ийн	Хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад хуулийн төслийн зорилго, зорилт, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд хуулийн төсөлд бүхэлд нь дүн
2.	Практикт		

	хэрэгжих боломж	хуулийн төсөл бүхэлд нь.	шинжилгээ хийсэн. Тухайлбал Монгол Улс болон ЕАЭЗХ, түүний гишүүн орнууд хоорондын Худалдааны түр хэлэлцээр байгуулах асуудал нь “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн Зорилт 4.4, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.5.1, 3.2.5.3, 3.2.5.4, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.2.11-т тус тус тусгагдсан. Тус хэлэлцээрийг хэрэгжүүлэх нь бүс нутгийн интеграцид нэгдэх, нэг эдийн засгаас хараат байдлыг бууруулах, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг хэрэгжүүлэх, цаашлаад аж ахуйн нэгжүүд, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, экспортын зах зээлийг тэлэх, худалдааг хөнгөвчлөх бодлогыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Дээр дурдсан Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд тусгагдсан болон худалдааг төрөлжүүлэх Засгийн газрын бодлогын зорилгын хүрээнд тус хэлэлцээрийн зорилго уялдаж байна. Хэлэлцээрийг хэрэгжүүлснээр худалдааг өргөжүүлэх, тарифын болон тарифын бус саадыг бууруулах, экспортын боломжийг нэмэгдүүлэхэд чиглэлээр өргөн хүрээний боломжууд нээгдэх бөгөөд экспортын бүтээгдэхүүний чанар, стандартыг ЕАЭЗХ-ны гишүүн орнуудтай уялдуулан сайжруулснаар зорилгод хүрэх бүрэн боломжтой байна.
3.	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Ойлгомжтой байдлыг үнэлэх хүрээнд хуулийн төсөл нь хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдүүдэд ойлгомжтой байдлаар томъёологдсон эсэхийг шалгах үүднээс хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад

			тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг шалгасан. Хэлэлцээрийн бүтэц, нэр томьёо, холбогдох заалтууд Монгол Улсын нэгдэн орсон олон улсын худалдааны хэлэлцээрийн нэр томьёо болон зохицуулалттай нийцэж байгаа тул ойлгомжтой гэж дүгнэсэн.
4	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Хуулийн төслийн зохицуулалт нь иргэд, байгууллага, аж ахуй нэгжүүдэд хүндрэл учруулахгүй. Хуулийн төслийн зохицуулалтаар иргэдийн эрх чөлөөг хязгаарласан болон аж ахуйн нэгжүүдэд шинээр үүрэг хүлээлгэж байгаа заалт байхгүй боловч хэлэлцээрийн хүрээнд худалдаа хийх тохиолдолд хэлэлцээрт заасан тодорхой шаардлага, стандартыг мөрдөн ажиллахаар тусгагдсан.
5.	Харилцан уялдаа	Хуулийн төсөл бүхэлдээ	Хуулийн төслийн харилцан уялдаа холбоог шалгах хүрээнд холбогдох төрийн байгууллагууд болон хувийн хэвшлээс саналуудыг авч тусгасан.

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтүүдийн хүрээнд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар дэлгэрэнгүй үнэлж байна.

3.1. ЗОРИЛГОД ХҮРЭХ ДҮН ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсын экспортын бүтэц, гадаад худалдаа нэг улсаас хэт хамааралтай байгаа нь эдийн засгийн эрсдэлийг нэмэгдүүлж, гадаад зах зээлд өрсөлдөх боломжийг хязгаарлаж байна. Тухайлбал, 2024 оны байдлаар нийт экспортын 91.3 хувийг БНХАУ-д хийж буй нь нэг зах зээлээс хэт хамааралтай, гадаад худалдааны эмзэг байдалд оруулж байгааг харуулж байна. Иймд экспортын зах зээлийг төрөлжүүлэх, бүс нутгийн шинэ түншлэлүүдийг эрэлхийлэх нь Монгол Улсын дунд болон урт хугацааны эдийн засгийн бодлогын хувьд зайлшгүй шаардлагатай байна.

Энэ хүрээнд Монгол Улс болон ЕАЭЗХ, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээр байгуулах асуудал нь "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн Зорилт 4.4, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.5.1, 3.2.5.3, 3.2.5.4, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.2.11-т тус тус тусгагдсан.

Тус хэлэлцээрийг хэрэгжүүлснээр бүс нутгийн интеграцид нэгдэх, нэг эдийн засгаас хараат байдлыг бууруулах, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг хэрэгжүүлэх, цаашлаад аж ахуйн нэгжүүд, жижиг дунд үйлдвэрлэлийг

дэмжих, экспортын зах зээлийг тэлэх, төрөлжүүлэх, худалдааг хөнгөвчлөх бодлогыг хэрэгжүүлэхэд чухал үр нөлөөтэй байна.

Одоогийн байдлаар Монгол Улс ОХУ болон ЕАЭЗХ-ны гишүүн орнуудтай худалдаа хийхэд өндөр гаалийн тариф, квотын хязгаарлалт, техникийн зохицуулалт, хорио цээрийн шаардлагыг хангах зэрэг олон саад тотгор байгаа нь экспорт, импортын үйл явцыг удаашруулж, зардлыг нэмэгдүүлэхэд гол нөлөө үзүүлж байна.

Иймд ЕАЭЗХ, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг байгуулах нь Монгол Улсад хэр үр ашигтай болох талаар эдийн засгийн нөлөөллийн шинжилгээг Дэлхийн худалдааны анализ төсөл (GТАР) ерөнхий тэнцвэрийн стандарт загвар ашиглан хийсэн.

Тус шинжилгээгээр импортын 367 бараанаас 356-д тарифыг бүрэн тэглэх, 6 бараанд 25–50 хувиар бууруулах, 2 бараанд тохирсон квотын хэмжээнд тарифыг тэглэх, 3 бараанд квотын хэмжээнд тарифын хөнгөлөлт эдлэх тохиолдолд импортын тарифын орлого буурах хэдий ч өрхийн хэрэглээ болон экспорт нэмэгдэж, улмаар эдийн засгийн бодит өсөлтөд эерэг нөлөө үзүүлэхээр тооцоологдсон байна.

Худалдааны түр хэлэлцээр байгуулах тохиолдолд өрсөлдөх чадвар бүхий бусад салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн биет хэмжээ өсөх хандлагатай байна. Үүнд савхин эдлэл, малын мах, дайвар бүтээгдэхүүн, үхэр, хонь, ямаа, элсэн чихэр, тослог ургамал, нэхмэл, бусад мах, махан бүтээгдэхүүн зэрэг 30 салбар багтаж байна. Тухайлбал, малын мах, дайвар бүтээгдэхүүн 1.4 хувь, үхэр, хонь, ямаа 1.2 хувь, элсэн чихэр 0.9 хувь, тослог ургамал 0.8 хувь, бусад мах, махан бүтээгдэхүүн 0.6 хувиар тус тус өсөлт үзүүлэх төлөвтэй байна.

Экспортын хувьд ОХУ-д экспортлох хиам, нөөшилсөн махан бүтээгдэхүүн 140 хувь, малын мах, дайвар бүтээгдэхүүн 125 хувь, бэлэн хувцас 84.3 хувь, нэхмэл эдлэл 55.4 хувь, савхин эдлэл 45.7 хувиар өсөх бол Казахстан улсад экспортлох арьс ширэн бүтээгдэхүүн 152 хувь, малын мах, дайвар бүтээгдэхүүн 113 хувь, бэлэн хувцас 134 хувь, нэхмэл эдлэл 27 хувь, савхин эдлэл 152 хувиар тус тус өсөхөөр байна. Бразил, Аргентин, Парагвай, Уругвай, Австрали, Шинэ Зеланд болон Европын Холбооны зарим улстай харьцуулахад 15-аас 50 хувийн гаалийн татвар ногдуулж буй Монголын бүтээгдэхүүн “0” хувийн татвартай болох нь зах зээл дээр шууд үнийн давуу талыг бий болгож, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.

Импортын хувьд Монгол Улсад ЕАЭЗХ-ны гишүүн орнуудаас импортлох барааны өсөлт хязгаарлагдмал, дунджаар 1.5-аас 3.6 хувийн хооронд байхаар тооцоологдсон байна.

Түүнчлэн Монгол Улс болон ЕАЭЗХ-ны гишүүн орнуудын дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ний хэмжээ нэмэгдэхээр байна. Үүнээс нийт 367 барааны импортын тарифыг хэсэгчлэн чөлөөлөх буюу импортын тарифыг тэглэх үед Монгол Улсын бодит ДНБ 0.0203 хувиар өсөхөөр байгаа нь ЕАЭЗХ-ны гишүүн орнуудтай харьцуулахад оролцогч талуудын дунд хамгийн өндөр өсөлт үзүүлэхээр

Хэлэлцээрийг хэрэгжүүлснээр дээрх эдийн засгийн эерэг, бодит үзүүлэлтүүд

бий болохоос гадна бүс нутгийн эдийн засгийн интеграцид Монгол Улсын оролцоог нэмэгдүүлэх, ЕАЭЗХ-ийн гишүүн орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, Монгол Улсын хараат бус эдийн засгийн байр суурийг бататгах өргөн хүрээний зэрэг үр нөлөөг үзүүлэхээр байна.

3.2. ПРАКТИКТ ХЭРЭГЖИХ БОЛОМЖ

Хэлэлцээр хэрэгжсэнээр Монгол Улсын үйлдвэрлэгч, экспортлогч аж ахуйн нэгжүүдийн орлого нэмэгдэх, шинэ зах зээлд нэвтрэх, хөдөө аж ахуйн салбарын өрсөлдөх чадвар сайжрах, олон улсын стандарт хангасан үйлдвэрлэл хөгжих боломж бүрдэнэ. Үүнтэй уялдан эрүүл ахуй, хорио цээрийн шаардлагыг хялбаршуулах, тохирлын үнэлгээний дүнг харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээг эхлүүлэх нөхцөл бүрдэнэ.

Түүнчлэн зарим барааны импортын үнэ буурах нь богино хугацаанд дотоодын зарим бүтээгдэхүүний үнийн өрсөлдөх чадварт дарамт учруулж болох боловч нөгөө талаас дотоодын үйлдвэрүүдийн түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн зардлыг бууруулах боломжийг нэмэгдүүлнэ. Энэхүү өртгийн бууралтад үндэслэн аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө оруулалт, шинэчлэл сайжирч, экспортын бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар сайжрах суурь нөхцөл бүрдэнэ.

Мөн хэлэлцээрийн хүрээнд гарал үүслийн дүрмийн шаардлага нэмэгдэх нь жижиг аж ахуйн нэгжүүдэд тодорхой зардал учруулах боловч урт хугацааны хувьд бүтээгдэхүүний чанар, баталгаажуулалт, экспортын бэлэн байдлыг сайжруулж, бүс нутгийн болон олон улсын зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх давуу талтай. Мөн барааны төрөлжилт сайжирч, хэрэглэгчийн сонголт өргөжиж, дотоодын үйлдвэрлэгчдэд зах зээлийн шударга, ил тод өрсөлдөөний орчныг бий болгох нөхцөл бүрдэнэ.

Цаашлаад гаалийн байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд гаалийн мэдүүлгийг бүртгэснээс хойш 4 цагийн дотор барааг олгох, цахим мэдээлэл солилцох, итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн хөтөлбөр зэрэг арга хэмжээг хэрэгжүүлснээр бараа хил дээр саатах хугацааг багасгаж, бизнесийн орчныг сайжруулах ач холбогдолтой. Мөн гарал үүслийн гэрчилгээг цахимаар солилцох, 5,000 еврогоос бага үнийн дүнтэй бараанд үйлдвэрлэгч өөрөө мэдүүлэг гаргах боломж нь бичиг баримтын бүрдүүлэлтийг хялбаршуулж, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжсэн зохицуулалт тул хэрэгжүүлэхэд ямар нэгэн хүндрэл учрахгүй гэж дүгнэсэн.

Мөн ЕАЭЗХ-ноос гаралтай түүхий эдийг ашиглан Монгол Улсад үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг гарал үүслийн хувьд Монгол улсаас гаралтай бараанд тооцох зохицуулалт, барааны 50 хувиас дээш нь Монгол Улсаас гаралтай тохиолдолд мөн адил Монгол Улсаас гаралтайд тооцох зэрэг заалт нь дотоодын үйлдвэрлэгчдэд гарал үүслийн хувьд таатай нөхцөл бүрдүүлж байна.

Хэлэлцээрийн үр дүнд худалдааны эргэлт болон хөдөө аж ахуй, хүнсний салбарт гадаад болон дотоодын хөрөнгө оруулалт нэмэгдэх, үйлдвэрлэлийн бүтээмж, чанар, өрсөлдөх чадвар сайжрах, ажлын байр нэмэгдэх, үйлдвэрлэлийн зардал болон импортын үнэ буурснаар өрхийн хэрэглээ, инфляцад зэрэг нөлөө

үзүүлэх боломжтой. Уул уурхайн бус үйлдвэрлэл нэмэгдсэнээр эдийн засгийн төрөлжилт сайжирч, худалдааны хараат байдал буурах үр нөлөөг үзүүлэх бөгөөд экспортын чиг баримжаатай хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх суурь нөхцөл бүрдэх юм.

4.3. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨГДӨХ БАЙДАЛ

Хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд тарифын зохицуулалт, гаалийн үйл ажиллагаа, гарал үүслийн дүрэм зэрэгт холбогдох төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд өөрчлөлт орох ч хуулийн төслийг дагалдуулан холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах, эрх зүйн уялдаа холбоо зохион байгуулалтын зарим арга хэмжээг авч хэрэгжүүлснээр тус асуудлыг зохицуулах боломжтой гэж дүгнэсэн.

Аж ахуйн нэгж, хувийн хэвшлийн зүгээс экспортын зах зээлийн хүртээмж нэмэгдэх, гаалийн бичиг баримтын давхардал буурах, тээвэр логистикийн өртөг буурах зэрэг эерэг нөлөө бий болно. Ялангуяа өрсөлдөх чадвартай салбарууд (савхин эдлэл, ноос ноолуур, мах, хүнсний бүтээгдэхүүн, логистик үйлчилгээ, дижитал үйлчилгээ) хэлэлцээрийн нөлөөг дэмжиж байгаа нь судалгаагаар тогтоогдсон.

Хэрэглэгч, олон нийтийн хувьд бараа, бүтээгдэхүүний үнэ буурах болон, барааны сонголт нэмэгдэх, зах зээлийн өрсөлдөөн нь бүтээгдэхүүний чанарыг сайжруулах эерэг нөлөө үзүүлэхээр байна. Тарифын бууралтаар хэрэглээний зардал буурах тооцоо нь олон нийтийн дунд хүлээн зөвшөөрөгдөх байдлыг нэмэгдүүлж байна.

Монгол Улс болон ЕАЭЗХ түүний гишүүн орнууд хооронд байгуулсан Худалдааны түр хэлэлцээрийн үр дүнг үнэлэн баримтжуулж, зөвлөмжийг дараах хийгдсэн уулзалт, сургалтын үр дүнд гарсан санал дүгнэлтээр баримтжуулсан болно. Үүнд:

1. ЭЗХЯ-ны зүгээс 2023 оны 12-оос 13-ны өдрүүдэд болон 2024 оны 05 сарын 09-ны өдрүүдэд 2 удаа төр, хувийн хэвшлийн нийт 150 гаруй төлөөлөгчдийг хамруулсан олон нийтийн хэлэлцүүлгийг МҮХАҮТ-тай хамтран зохион байгуулж, олон нийт, ААН-ийн саналыг авч хэлэлцээрийн төсөлд тусгасан болно.
2. Хэлэлцээрийн явцад МҮХАҮТ, ХХААХҮЯ-ны холбогдох мэргэжилтнүүдтэй уулзалт зохион байгуулж, барааны жагсаалтын талаар санал солилцсон бөгөөд ЭЗХЯ-ны зүгээс 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 03/1978 дугаартай албан бичгээр ХХААХҮЯ болон МҮХАҮТ-аас барааны жагсаалтад тусгах саналуудыг авч, хэлэлцээрийн төсөлд тусгасан.
3. Хэлэлцээ хийх тухай бүр хэлэлцээрийн явцын талаар Засгийн газрын хуралдаанд танилцуулж, хуралдаанаас гарсан санал дүгнэлтийг тусгаж ажилласан.

4.4. ОЙЛГОМЖТОЙ БАЙДЛЫГ ШАЛГАХ

Хуулийн төслийн зохицуулалт нь найруулга, хэлзүйн болон агуулгын хувьд ойлгомжтой байдлаар томъёологдсон эсэхийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагын хүрээнд дор дурдсанаар нарийвчлан үнэлсэн болно.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага /Хүснэгт 2/

Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан байх	Шаардлага хангасан.
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх	Шаардлага хангасан.
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх	Шаардлага хангасан.
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх	Шаардлага хангасан.
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх	Шаардлага хангасан.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх	Шаардлага хангасан.
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх	Шаардлага хангасан.

29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох зарчим, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журмыг тусгасан байх.	Шаардлага хангасан.
29.2.Хуулийн төсөлд шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцох, зарим үг, өгүүлбэр, тоо, тэмдэгт хасах талаар тусгана.	Шаардлага хангасан.
29.3.Шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулна.	Шаардлага хангасан.
29.4.Энэ хуулийн 14.5-д зааснаас бусад хуулийн төслийг дагалдуулан анхдагч болон шинэчилсэн найруулгын төслийг өргөн мэдүүлэхийг хориглоно.	Шаардлага хангасан.
Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх	Шаардлага хангасан.
30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх	Шаардлага хангасан.
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих	Шаардлага хангасан.
30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх	Шаардлага хангасан.
30.1.5.ЖИНХЭНЭ нэрийг ганц тоон дээр хэрэглэх	Шаардлага хангасан.

4.5. ХАРИЛЦАН УЯЛДААГ ШАЛГАХ

Харилцан уялдаа гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн зүйл, заалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж буй бусад хууль тогтоомжтой нийцтэй байдал, төрийн байгууллагын чиг үүрэг давхардсан болон зөрчилдсөн эсэх, тухайн чиг үүргийг төрийн байгууллага зайлшгүй хэрэгжүүлэх

шаардлагатай эсэх, уг чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжтой эсэх, хуулийн төсөлд жөндөрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх, шударга бус өрсөлдөөнийг бий болгоход болон авлига, хүнд суртлыг үүсгэхэд чиглэсэн заалт тусгагдсан эсэхийг үнэлсэн.

ТАВ. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ТОГТООСОН БАЙДАЛ

5.1. ЕРӨНХИЙ

Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах хүрээнд дараах асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог шалгасан болно.

Хуулийн төслийн уялдаа холбоо /Хүснэгт 3/

Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Тийм
Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	Тийм
Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцсэн.

Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	Хуулийн төсөл нэг зүйлтэй.
Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	Үгүй
Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Тийм
Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг бүрэн тусгасан.
Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Үгүй
Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх	Үгүй

боломжтой эсэх	
Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх	Үгүй
Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх	Тийм
Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх	Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулаагүй.
Хуулийн төслийн зүйл, заалт жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Тус хуулийн төслөөр зохицуулагдах харилцаанд хамааралгүй байна.
Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Үгүй
Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Үгүй
Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх	Тус хуулийн төслөөр зохицуулагдах харилцаанд хамааралгүй байна.

5.2. ҮҮСЭЖ БОЛОХ ЭДИЙН ЗАСГИЙН ҮР НӨЛӨӨ:

Хэлэлцээр хэрэгжсэнээр Монгол Улсын экспортын боломж тэлж, ЕАЭЗХ-ны гишүүн орнуудын зах зээлд хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэл, хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүн зэргийг хөнгөлөлттэй нөхцөлөөр гаргах боломж бүрдэнэ. Энэ нь үйлдвэрлэлийн хүчин чадал нэмэгдэж, валютын орлого өсөхөд дэмжлэг үзүүлнэ. Импортын тариф буурснаар зарим өргөн хэрэглээний болон үйлдвэрлэлийн барааны үнэ буурч, хэрэглэгчдийн худалдан авах чадвар дээшлэхийн зэрэгцээ дотоодын зах зээлийн өрсөлдөөн нэмэгдэнэ. Үүний үр дүнд бизнесийн орчин илүү нээлттэй, үр ашигтай болох нөхцөл бүрдэнэ.

Хэлэлцээрийн хэрэгжилтийн эхний шатанд дотоодын жижиг, дунд үйлдвэрүүд ЕАЭЗХ-ны өрсөлдөөнт зах зээлд шинээр нэвтрэхэд стандартын шаардлага хангах, хорио цээрийн шаардлагыг дагаж мөрдөх, зэрэгт хүндрэл үүсэж, богино хугацаанд ашиг буурах эрсдэл үүсэж болзошгүй. Энэхүү хэлэлцээрийн үр ашгийг бүрэн дүүрэн хүртэхийн тулд дотоодын үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг бэхжүүлэх, стандарт, техникийн зохицуулалтыг уялдуулах, хөрөнгө оруулалт болон бизнесийн орчныг сайжруулах бодлогын арга хэмжээг зэрэгцүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай. Энэ хүрээнд ЭЗХЯ-ны зүгээс хэлэлцээрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг холбогдох

байгууллагуудтай хамтран боловсруулж, батлуулж, хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

5.3. АЖ АХУЙН НЭГЖИД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ:

Худалдааны түр хэлэлцээр байгуулах тохиолдолд бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ буурах салбарын тоо бага зэрэг нэмэгдэж болох үр дүн гарсан бөгөөд өрсөлдөх чадвар бүхий бусад салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн биет хэмжээ өсөхөөр байгаа бөгөөд хэлэлцээрийн хүрээнд аж ахуйн нэгжүүд ЕАЭЗХ-ны 180 гаруй сая хэрэглэгчтэй зах зээлд нэвтрэх боломжтой болж, экспортын шинэ суваг нээгдэнэ.

Үйлдвэрлэл, технологи, хөрөнгө оруулалтын чиглэлээр хамтын ажиллагаа өргөжихийн зэрэгцээ стандарт, техникийн шаардлагад нийцэх шинэчлэл хийх хэрэгцээ, шаардлага үүсэн гарна. Энэ нь дотоодын аж ахуйн нэгжүүдийн өрсөлдөх чадварыг сайжруулах, чанар, стандартын түвшнийг дээшлүүлэх, шинэ технологи нэвтрүүлэх түлхэц болох юм.

5.4. ИРГЭДЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ:

Импортын өрсөлдөөн нэмэгдсэнээр өргөн хэрэглээний буюу иргэдийн худалдан авах бараа, бүтээгдэхүүний үнэ тогтворжих, чанар сайжрах, сонголт өргөжих нөхцөл бүрдэнэ. Үйлдвэрлэл болон худалдааны салбарт ажлын байр нэмэгдэж, хөдөлмөрийн орлого өснө. Дунд хугацаанд эдийн засгийн идэвхжил нэмэгдэж, иргэдийн амьжиргааны түвшин дээшлэх бодит боломж бүрдэхээр байна.

ЗУРГАА. ҮР ДҮНГ ҮНЭЛСЭН ДҮГНЭЛТ БА ЗӨВЛӨМЖ

Энэхүү Монгол Улс болон ЕАЭЗХ, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг УИХ-д өргөн барих тухай хуулийн төслийн үр нөлөөг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал"-ын дагуу тооцож судалгаа, шинжилгээний дүнг нэгтгэн дараах дүгнэлтэд хүрлээ. Үүнд:

Энэхүү үнэлгээг эдгээр хуулийн төсөлд хийхэд сонгосон шалгуур үзүүлэлтүүдээр үнэлэхэд хуулийн төслийн үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг хангасан, практикт хэрэгжих бүрэн боломжтой, хуулийн төслийн томьёолол нь ойлгомжтой, хоёрдмол утга санаагүй, тодорхой, Монгол Улсын үндсэн хууль, бусад хууль тогтоомж болон тухайн хуулийн зүйл, заалттай давхардаагүй, зөрчилдөөгүй гэж дүгнэж байна.

Хэлэлцээр нь Монгол Улсын худалдааны бүтцийг төрөлжүүлэх, экспортын бараа бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, ЕАЭЗХ-ны гишүүн орнуудын зах зээлд хөнгөлөлттэй нөхцөлөөр нэвтрэх боломжийг бүрдүүлж байгаа нь эдийн засгийн хувьд эерэг нөлөөтэй байна.

Хэлэлцээрийн хэрэгжилтийн хүрээнд тарифын болон тарифын бус саад, тотгорыг бууруулах, гаалийн болон техникийн зохицуулалтыг уялдуулах, худалдааг хөнгөвчлөх боломж бүрдэж байгаа нь зорилгодоо хүрэх боломжтой болохыг харуулж байна.

Хэлэлцээрийг хэрэгжүүлэх, дагаж мөрдөх чиг үүрэг бүхий байгууллагууд болох

Гаалийн ерөнхий газар, ХХААХҮЯ, МҮХАҮТ болон бусад холбогдох байгууллагууд уг зохицуулалтыг дэмжин, холбогдох ажлын хэсгүүдэд хамтран ажилласан. Хэлэлцээрийн төсөл нь Монгол Улсын худалдааны бодлого, экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, бүс нутгийн интеграцид оролцох оролцоог гүнзгийрүүлэх үндэсний бодлого, зорилттой нийцэж байна.

ЕАЭЗХ болон Монгол Улс хооронд байгуулах Худалдааны түр хэлэлцээр нь зорилгодоо хүрэхүйц, хэрэгжүүлэх, дагаж мөрдөх нөхцөл бүрдсэн, холбогдох байгууллагуудын дэмжлэгтэй, эдийн засаг, худалдааны хувьд эерэг нөлөөтэй гэж үнэлэгдсэн тул хэлэлцээрийн төслийг хэвээр үлдээх нь зүйтэй гэж дүгнэв.

Иймд Монгол Улс болон ЕАЭЗХ, түүний гишүүн орнууд хооронд байгуулах худалдааны түр хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлах тухай хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, уялдаа холбоо хангагдсан байна гэж үзлээ.

—oOo—

МОНГОЛ УЛС БОЛОН ЕВРАЗИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХОЛБОО, ТҮҮНИЙ
 ГИШҮҮН ОРНУУД ХООРОНДЫН ХУДАЛДААНЫ ТҮР ХЭЛЭЛЦЭЭРИЙГ
 СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН АЖЛЫН ХЭСГИЙН
 БҮРЭЛДЭХҮҮНИЙ НЭРС

№	Нэрс	Албан тушаал	Холбоо барих утас
1.	Ж.Энхбаяр	Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд	99117928
2.	И.Батхүү	Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга	99113569
3.	Д.Эрдэнэтуяа	Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газрын дарга	94005933
4.	Б.Урьболд	Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газрын Эдийн засгийн хамтын ажиллагааны хэлтсийн дарга	80190808

---o0o---